



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-19
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	20-113
<hr/>	
1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	23-27
2.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	27-51
3.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	51-69
4.Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Эмийн үйлдвэрлэл, чанар, хяналт, хүртээмжийн зэрэг асуудал болон энэ талаарх цаашидын бодлого, зорилтын талаар”, Улсын Их Хурлын Ц.Туваанаас Эрүүл мэндийн сайдад хандаж “Эм үйлдвэрлэл, эмийн үнийн талаар” тус тус хандаж тавьсан асуулгын хариу сонсох	69-93
Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх үргэлжлэв.	93-101
5.“Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хүний эмийн чанарын асуудлаарх хянан шалгах түр хороо/	102-105
6.“Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг бүхий түр хороо/	105-108
7.“Түр хорооны даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороо/	108-110
8.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	110-113

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 14-ний өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Х.Баделхан, Х.Болорчулуун, С.Бямбацогт,
Б.Жавхлан, Г.Занданшатар, Ж.Мөнхбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Л.Оюун-
Эрдэнэ, Д.Тогтохсүрэн, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл;

Чөлөөтэй: Ц.Анандбазар;

Тасалсан: С.Ганбаатар, Д.Ганбат, Ш.Раднаасэд;

Хоцорсон: Э.Бат-Амгалан -1 цаг 57 минут, С.Батболд -3 цаг 06 минут, Д.Батлут -
20 минут, Н.Учрал -21 минут, Д.Цогтбаатар -1 цаг 28 минут, Б.Энх-Амгалан -2 цаг 01
минут.

Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Пүрэвдорж нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Г.Баяртуяа, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Т.Аюурсайхан: 1.Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 20

Бүгд: 48

58.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 20

Бүгд: 48

58.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 19

Бүгд: 48

60.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 18

Бүгд: 48

62.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 19

Бүгд: 49

61.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 18

Бүгд: 49

63.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 18
Бүгд: 49
63.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

8.Байнгын хорооны саналаар Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 17
Бүгд: 49
65.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

9.Байнгын хорооны саналаар Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 19
Бүгд: 49
61.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

10.Байнгын хорооны саналаар Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 17
Бүгд: 49
65.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

11.Байнгын хорооны саналаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 18
Бүгд: 48
62.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

12.Байнгын хорооны саналаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 16
Бүгд: 48
66.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

13.Байнгын хорооны саналаар Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 17
Бүгд: 48

64.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

14.Байнгын хорооны саналаар Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 21
Бүгд: 48

56.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

15.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 20
Бүгд: 49

59.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

16.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 19
Бүгд: 50

62.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

17.Байнгын хорооны саналаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 21
Бүгд: 50

58.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

18.Байнгын хорооны саналаар Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 18

Бүгд: 50
64.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

19.Байнгын хорооны саналаар Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Органик хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Таримал ургамлын үр, сортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 21
Бүгд: 49

57.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

20.Байнгын хорооны саналаар “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 27
Бүгд: 49

44.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 21
Бүгд: 49

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Т.Аюурсайхан: 20.Байнгын хорооны саналаар “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 19
Бүгд: 50

62.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

21.Байнгын хорооны саналаар “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 25
Бүгд: 48

47.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 18
Бүгд: 46

60.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Т.Аюурсайхан: 21.Байнгын хорооны саналаар “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 18
Бүгд: 47

61.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

22.Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 20
Бүгд: 47

57.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

23.Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 21
Бүгд: 47

55.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

24.Байнгын хорооны саналаар “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 20
Бүгд: 47

57.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

25.Байнгын хорооны саналаар “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 19
Бүгд: 47

59.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын мэргэжилтэн М.Ганбагана, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, хуульч, өмгөөлөгч Ч.Жадамба нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Б.Энхбаяр, Б.Баттөмөр, Х.Булгантуяа, Н.Энхболд, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Н.Энхболд нар үг хэлэв.

Т.Аюурсайхан: Байнгын хорооны саналаар Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 19
Бүгд: 47
59.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар хэлэлцэх асуудлын дарааллын дөрөвдүгээрт байгаа Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллын гуравдугаарт оруулж хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 25
Бүгд: 48
47.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 25
Бүгд: 49
49.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Гурав.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Б.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, мөн яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга Х.Тамир, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга Э.Түмэндэмбэрэл, мөн хэлтсийн ахлах шинжээч Д.Адилбиш, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Жавзанжаргал, мөн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Дэд ерөнхийлөгч Х.Ганбаатар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирал Т.Дүүрэн, мөн танхимын Бодлого, стратегийн газрын дарга Б.Баяртуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Ё.Баатарбилэг, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Ч.Ундрэм, Б.Дэлгэрсайхан нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөл хуралдах тул хуралдаан 13 цаг 16 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 12 минутад эхлэв.

Дөрөв.Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Эмийн үйлдвэрлэл, чанар, хяналт, хүртээмжийн зэрэг асуудал болон энэ талаарх цаашидын бодлого, зорилтын талаар”, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваанаас Эрүүл мэндийн сайдад хандаж “Эм үйлдвэрлэл, эмийн үнийн талаар” тус тус хандаж тавьсан асуулгын хариуг сонсох

Асуулгын хариулттай холбогдуулан Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Буянтогтох, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга Ж.Нарангэрэл, мөн газрын ахлах шинжээч Ч.Амаржаргал, Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, мөн газрын Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Тусламж, үйлчилгээний багц, зохицуулалтын хэлтсийн дарга Б.Баярболд, Эмийн аюулгүй байдлын

тандалт, судалгааны газрын дарга П.Цэцгээ, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Чанарын хяналтын газрын дарга Г.Номин, мөн газрын Эм хангамжийн газрын дарга Г.Цэцэнсанаа, Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул, Эмийн үйлдвэрийн хэлтсийн дарга Д.Бямбадорж, Эм шинжлэх лабораторийн дарга Ш.Энхзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, мөн хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Ж.Монголжингоо нар байлцав.

Асуулгын хариуг Эрүүл мэндийн сайд С.Энхболд танилцуулав.

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Ё.Баатарбилэг, Б.Жаргалмаа, Б.Бейсен, А.Адьяасүрэн, Ц.Туваан, М.Оюунчимэг, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Буянтогтох, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газрын дарга П.Цэцгээ нар хариулж, тайлбар хийв.

Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ц.Туваан нар үг хэлэв.

Нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Эмийн үйлдвэрлэл, чанар, хяналт, хүртээмжийн зэрэг асуудал болон энэ талаарх цаашдын бодлого, зорилтын талаар”, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваанаас Эрүүл мэндийн сайдад хандаж “Эм үйлдвэрлэл, эмийн үнийн талаар” тус тус хандаж тавьсан асуулгын хариуг хэлэлцлээ.

Уг асуудлыг 15 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Б.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, мөн яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга Х.Тамир, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга Э.Түмэндэмбэрэл, мөн хэлтсийн ахлах шинжээч Д.Адилбиш, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Жавзанжаргал, мөн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Дэд ерөнхийлөгч Х.Ганбаатар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирал Т.Дүүрэн, мөн танхимын Бодлого, стратегийн газрын дарга Б.Баяртуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Боловсрол,

соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ё.Баатарбилэг, М.Оюунчимэг, Б.Дэлгэрсайхан, Б.Бейсен, Ш.Адъяаа нар үг хэлэв.

Т.Аюурсайхан: Байнгын хорооны саналаар Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 14
Бүгд: 50
72.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хүний эмийн чанарын асуудлаарх хянан шалгах түр хороо/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Ш.Адъяаа нар үг хэлэв.

Т.Аюурсайхан: Байнгын хорооны саналаар “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг

танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:30/

Уг асуудлыг 16 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. “Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг бүхий түр хороо/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Т.Аюурсайхан: Байнгын хорооны саналаар “Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	31
Татгалзсан:	15
Бүгд:	46

67.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан “Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:43/

Уг асуудлыг 16 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Долоо. “Түр хорооны даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороо/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Төслийн талаарх Түр хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Түр хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Т.Аюурсайхан: Түр хорооны саналаар Түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 17

Бүгд: 46

63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх сонгох саналыг дэмжсэн тул энэ тухай тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан “Түр хорооны даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:50/

Уг асуудлыг 16 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн, Монголбанкны Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, мөн хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын ахлах зөвлөх А.Баянмөнх, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт Ж.Мөнх-Оргил, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн Б.Одмандах, Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын татварын улсын байцаагч Ч.Октябрь, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Ө.Өнөрлхам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Баялагцэнгэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: 1.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “10 өдрийн” гэснийг “15 өдрийн” гэж, 11.4 дэх хэсгийн “харьяалах бүртгэх байгууллагад ирүүлж болно” гэснийг “ирүүлнэ” гэж, 11.5 дахь хэсгийн “бүртгэх байгууллага” гэснийг “энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлээгүй бол бүртгэх байгууллага” гэж, 11.11 дэх хэсгийн “цахимаар, нээлттэй” гэснийг “мэдээлэл хүргэх цахим хуудас, мэдээллийн самбарт гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “өөрчлөлтийг ажлын гурван өдрийн дотор” гэснийг “өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 15

Бүгд: 45

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсгийн “Энэ тохиолдолд бүртгэх байгууллага тухайн этгээдийг бүртгэхгүй.” гэснийг, 11.3, 11.4, 11.5 дахь хэсгийн “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг, 11.12 дахь хэсгийг болон “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлийн хугацаа сунгах” гэсэн 13 дугаар зүйлийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 15

Бүгд: 45

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “удирдлага, эсхүл менежерээр томилогдсоны дараа энэ хуулийн 7.1.1, 7.1.2-г заасан нөхцөл үүссэн бол” гэснийг “удирдлага, эсхүл менежерээр томилогдсоны дараа энэ хуулийн 7.1.1, 7.1.2-г заасан шаардлагыг хангахгүй болох нь тогтоогдсон бол” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 16

Бүгд: 45

64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс” гэснийг “2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 16

Бүгд: 45

59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 286.2 дахь хэсгийн “зөвхөн хөдлөх хөрөнгө барьцаалж болно” гэснийг “зөвхөн хөдлөх хөрөнгө барьцаална” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 17
Бүгд: 45
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: Чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн “Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 6.1.12 дахь заалтыг хасах гэснийг Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.1.13 дахь заалт болгох:

6.1.13.иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 16
Бүгд: 45
64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: Төслийн 18¹.1 дэх хэсэг болон 18¹.1.1 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18¹.1.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа болон иргэнээс байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн этгээдэд гэрчилгээ олгоход 100,000-250,000 төгрөгийн хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, С.Одонтуяа нарын урилгаар Нийслэлийн Баянгол дүүргийн сургууль, цэцэрлэгийн багш нарын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн “Эрдэнэт” өртөөний төмөр замчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын урилгаар Ховд аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийг 1987 онд төгссөн төгсөгчдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Нийслэлийн Налайх дүүргийн 23, 187 дугаар цэцэрлэгийн багш, ажилчид, Улсын Их Хурлын гишүүн П.Анужины урилгаар Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Геологийн төв лабораторийн ахмад ажилтнуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Бат-Эрдэнийн урилгаар Монгол Улсын төрийн соёрхолт уран барималч Намдагийн Дашням болон түүний гэр бүл, Төв аймгийн Баянчандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн багш нар болон 8 дугаар ангийн сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар нарын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн багш нар болон 8 дугаар ангийн сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн урилгаар Монгол Улсын хэмжээнд биеийн тамир, спортын чиглэлээр төрөлжсөн үйл ажиллагаа явуулдаг сургуулиудын захирлууд, Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Ч.Ундрам, Ж.Эрдэнэбат нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Орхон сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, С.Чинзориг нарын урилгаар Өвөрхангай аймгийн “Социал демократ Монголын залуучуудын холбоо”-ны тэргүүлэгчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн урилгаар Говь-Алтай аймгийн Төгрөг сумын ерөнхий боловсролын сургуулийг 1990 онд төгссөн төгсөгчдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар нарын урилгаар Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Идэрбат нарын урилгаар Хэнтий аймгийн Хэрлэн сумын малчин иргэдийн төлөөлөл, Өвөрхангай аймгийн Тарагт сумын иргэдийн төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 56 минут үргэлжилж, 76 гишүүнээс 59 гишүүн хүрэлцэн ирж, 77.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 10 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц 51,3 хувь болсон байна. Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 10-дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдэж байна. Хэлэлцэх асуудал 9 байна.

1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ, хэлэлцэх эсэхийг, 2.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, 3.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, 4.Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, 5.Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 6.Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 7.Түр хорооны даргыг сонгох тухай асуудал, 8.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж Эмийн үйлдвэрлэл, чанар, хяналт, хүртээмжийн зэрэг асуудал болон энэ талаарх цаашдын бодлого, зорилтын талаар, мөн Улсын Их Хурлын

гишүүн Цэвэгдоржийн Туваанаас Эрүүл мэндийн сайдад хандаж Эм үйлдвэрлэл, эмийн үнийн талаар тус тус тавьсан асуулгын хариуг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.4-т гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Адьяаа, Бөхчулууны Пүрэвдорж нараас тус тус ирүүлсэн албан бичгүүд ирсэн. Энэ албан бичгийг танилцуулъя. Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлтээ хүргүүлж байна. Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьяаа гэсэн байна.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржоос мөн ижил агуулгатай албан тоот хуульд заасан хугацаанд хүрэлцэн ирсэн. Ийм учраас Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьяаад микрофон өгье.

Ш.Адьяаа: Та бүгдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Монгол Улсын төсвийн асуудал, мөнгөний бодлогын асуудлыг өнөөдөр Монгол Улсын Их Хурал хэлэлцэж байна. Төсвийн энэ асуудал бол өнөөдөр улс орны эдийн засагт байгаа хүндрэлтэй холбогдуулж, олон шийдлийг дагуулсан, олон эрэл хайгуулыг бий болсон ийм одоо цаг үед бид өнөөдөр улсын төсвийг хэлэлцэж байна. Энэ улсын төсвийн энэ онцгой чухал хэлэлцүүлгийн үед Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд, Эдийн

засгийн хөгжлийн сайд энэ тэр энд оролцохгүй байна, оролцохгүй байна. Энд хамгийн дээд талын албан тушаалтан, дэд сайд, ТНБД, газрын дарга нар байна. Тэгэхдээ энд бол ихэнх сайдууд байгаа, ойлгож байгаа. Засгийн газрын гишүүдийн 50 хувь нь байна. Тэгэхдээ энэ гол чухал сайдууд чинь яахаараа өнөөдөр ингээд байдаггүй юм бэ, энд бас нэг анхаарлаа хандуулахыг хүсье.

Энэ төсөв, мөнгөний бодлого, 2023, 24 оны төсвийг хэлэлцэж байх энэ цаг үед Монгол Улс эдийн засгийн хүнд байдалд орж, валютын хомсдол болсон ийм цаг үетэй бид тулгарч байгаа. Энэ валютын хомсдолыг яаж арилгах вэ, төгрөгийнхөө өрсөлдөх чадварыг яах вэ гэдэг дээр Монголын төр, энэ Сангийн яам энд анхаарал хандуулъя. Энэ төр барьж байгаа Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн анхаарлаа хандуулъя, анхаарлаа хандуулъя. Ингээд дампуурлын байдалд орвол яах юм, цаашидаа энийг яаж засах юм, энэ дээр өнөөдөр энэ төсөв мөнгөний бодлого, төсөв хэлэлцэж байгаа энд онцгой анхаарал хандуулмаар байна. Би удаа дараа ярьж байгаа. Энэ уул гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниуд, гадаадын хөрөнгө оруулалттай газрын тосны ашигт малтмалыг экспортолдог компаниуд өнөөдөр Монгол Улсын банк санхүүгийн байгууллагаар нэг ч одоо тийм төлбөр хийхгүй байна. Төлбөр хийхгүй байна. Зөвхөн энэ цаасан дээр балансын байдлаар өнөөдөр олон арван тэрбум төгрөгийн экспортын бүтээгдэхүүн гаргалаа гэсэн ийм тоог бид хараад сууж байгаа. Зөвхөн урсгал зардлаа гаргаж ирж байна. Одоо Оюу толгой ярьдаг байсан бол одоо Эс Жи, Саусгоби гээд, гээд Капла гээд нэг нөхөр байгаа шүү дээ. Энэний мөнгө орж ирдэггүй. Эндээ ер нь Монголын төр ингээд цаашидаа явах юм уу.

Дээр нь энэ Монголын арилжааны банкнууд өнөөдөр ард иргэддээ, ААН-үүддээ зээл өгөхөө больсон. Ингээд ийм зээл өгөх асуудал чинь хэдий хүртэл

үргэлжлэх юм бэ? Энд Монголын төр яагаад анхаарлаа хандуулахгүй байна вэ? Энэ төсөв мөнгөний асуудлыг ярих энэ цаг үед энэ асуудлыг хөндөж ярихгүй байна. Засгийн газар, Улсын Их Хурал өнөөдөр Үндэсний аюулгүй байдлын асуудал гэдэг нэрийн доор хэдхэн арилжааны банк, банканд барьцаалагдсан энэ байдал чинь хэр зэрэг үргэлжлэх юм бэ, энэ гадаадын хөрөнгө оруулалттай банкиг оруулж ирье. Яагаад оруулж ирж болохгүй байгаа юм бэ?

Дээр нь энэ уул уурхайн гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд, Монголын арилжааны банкнуудад итгэдэггүй гэдэг талаар удаа дараа ярьж байсан. Тэгвэл энэ гадаадын хөрөнгө оруулалттай банкиг нь оруулж ирж, энэ уул уурхайн бүтээгдэхүүнийхээ энэ гүйлгээг Монголын банкаар, банк санхүүгийн байгууллагаар дамжуулж явуулъя л даа. Энэ хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлье. Энэ төсөв хөрөнгийг ярьж байгаа энэ үед энэ асуудлыг хойшлуулахаар оруулж ирэх ийм шаардлагыг би өнөөдөр энэ Засгийн газар, Улсын Их Хурлын олонхын бүлэгт одоо дахин шаардаж байна. Ингээд улс эх орноо дампууруулаад, гаднын энэ хөрөнгө оруулагчдыг татна гэдэг нэрийдлийн дор уул уурхайн энэ газрын тосны ашигт малтмалын энэ барьцаанд барьцаалагдсан байдал ингээд хэр үргэлжлэх юм бэ? Энд одоо Монголын төр арга хэмжээ авах ийм цаг болсон юм биш үү. Бид өнөөдөр хэн нэгэнд таалагдах, хэн нэгнийг энэ барьцаалагдсан энэ байдлаасаа энэ улс эх орныхоо төлөө, ард иргэдийнхээ төлөө, Монгол Улсынхаа эдийн засгийг сайжруулахын төлөө энд одоо анхаарах цаг болсон. Энд одоо Их Хурлын гишүүд та бүхэн өнөөдөр анхаарлаа хандуулж, Засгийн газар энд шийдвэртэй арга хэмжээ авах ийм шаардлагыг би өнөөдөр энэ Улсын Их Хурлын чуулган дээр хэлж байна.

Энийг анхааралтай авч үзээч, ингэхгүй бол одоо ирэх саруудад, оны эхээр энэ Монгол Улс чинь дампуурах, валютын хомсдолд орох, төлбөрийн чадваргүй болох энэ нөхцөлийг яах вэ гэдэг дээр одоо бид энэ төсөв хэлэлцэж, төсөв мөнгөний бодлогыг хэлэлцэж байгаа энэ цаг үед бас ярилцаж шийдвэр гаргах шаардлагатай байна гэж бодож байгаа юм.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржид микрофон өгье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ жилийн хувьд бол зуншлага маш муу байсан. 6 сарын үед нэг жоохон бороо ороод, тэрүүгээрээ бас нэлээн гайгүй ногоо ургасан боловч бүтэн 7, 8 сар, 9 сард ерөөсөө нэг ч бороо орохгүйгээс болоод Баян-Өлгий, Баянхонгор, Ховд, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь, Увс гээд энэ аймгуудын нутагт бол үнэхээр одоо мал тарга тэвээрэг эхэндээ авсан боловч, сүүлдээ бол үнэхээр одоо муудаж байна. Тийм учраас энэ өвөлжилт хүндрэх юм байна. Энэ өвөлжилт хүндэрч хүндрэх нөхцөл байдалтай холбоотойгоор бас тодорхой хэмжээгээр энэ төр засгаас энэ одоо малчдын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах талаар нэг тийм яриа гаргасан боловч ачир дээрээ ерөөсөө нэг ч ширхэг ч одоо ажил хийхгүй байна.

Тийм учраас Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэд энэ өвс тэжээлийг гааль болон НӨАТ-н татвараас чөлөөлөх тухай албан бичгийг одоо өгсөн байгаа. Ингэх юм бол нэг шуудай одоо хорголжин тэжээл дээр ойролцоогоор 9000 орчим төгрөгөөр хямдрах ийм боломжийг одоо гаргаж ирж чадах юм. Ингэх юм бол одоо манай малчид малынх нь үнэ уначихсан энэ үед энэ хэдэн шуудай хорголжин тэжээл ч гэсэн аваад, мал малаа бас муудсан малаа тэжээгээд орох ийм одоо боломж нь бүрдэх юм. Тэгээд энэ дээр ингээд ХХАА яамнаас асуухаар ХХАА яам нь

болохоор манай Монголд бол хангалттай хивээг байгаа гэж яриад байдаг. Гэтэл энэ хивээг чинь баруун аймаг руу очихоороо маш өндөр үнэтэй очдог, цаанаас орж ирж байгаа Оросын одоо хивгээс үнэтэй байдаг. Тийм учраас одоо борлогдохгүй ийм нөхцөл байдал, дээрээс нь хивээг энэ хавиараа одоо төвийн бүсээрээ л борлогдоод дуусчихдаг ийм нөхцөл байдалтай байгаад байгаа юм.

Тийм учраас энэ Засгийн газар, ялангуяа ХХАА яам энэ өвс тэжээлийн баруун аймгаар орж ирж байгаа өвс тэжээлийг татварыг нь тэглэх, энэ одоо асуудлыг Засгийн газрын хуралдаанд яаралтай оруулж шийдэх ийм одоо зайлиггүй шаардлага байна гэдгийг хэлье. Ер нь бол өвөлжилт хүндрэх нөхцөл байдалтай холбоотойгоор 1000 малтай айл гэхэд ойролцоогоор 400 малаа борлуулах ийм сонирхолтой байна. Харамсалтай нь одоо энэ малыг нь худалдаж авах, Оюунчимэг, малыг нь худалдаж авах ийм одоо үйлдвэр, ченжүүд ерөөсөө байхгүй байна. Яагаад гэвэл квот гэдэг нэг ийм хогийн новшийн юм, өөрөөр хэлбэл малчдын квот нэрийн дор одоо малчдын бог тутмаас 20000 төгрөг, бод тутмаас 200000 төгрөг одоо хулгайлж байна шүү дээ. Энэ зүйлээс болоод өнөөдрийг хүртэл 2 жилийн хугацаанд махны экспорт хамгийн доод түвшинд очлоо. Мянгахан тонн гарлаа. Өнөөдрийн байдлаар 10000 тонн дулааны аргаар боловсруулсан мах үйлдвэрүүд дээр байж байна. Энэ нь 330 тэрбум төгрөг гэсэн үг. Энэ 3300 тэрбум төгрөг үйлдвэр дээрээ түгжигдсэнээс болоод үйлдвэрүүд мөнгө байхгүй, үйлдвэрүүд мөнгө байхгүй болохоор ченжүүд мөнгө байхгүй, ченжүүд мөнгө байхгүй болохоор Ховдын Булганд очиж мал авдаг хүн ерөөсөө байхгүй болчихоод байгаа юм.

Ийм учраас энэ экспортын үйл ажиллагааг илүү сайжруулах, шинэ түвшинд аваачих, энэ энийгээ далимдуулаад бас энэ 91 сая толгой болчихсон энэ малынхаа нэг хэсгийг нь

одоо экспортод амжилттай гаргах ийм шаардлага гарчхаж байна. Энэ үүний үр дүнд малчдын орлого маань л одоо илүү сайжрах ийм боломжийг гаргаж ирж чадах юм. Тийм учраас энэ өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, дээрээс нь малын малчдын малыг арай илүү өндөр үнэтэй борлуулах энэ нөхцөл шаардлагын үүднээс махны одоо ААН-үүдийг дэмжих, санхүүжилтийн сайн эх үүсвэрийг олж өгөх, дээрээс нь одоо мянган малтай малчны одоо 400-гаа борлуулна гэхэд үлдсэн 600-нхаа мууг нь хавартаа, өвөлдөө одоо тэжээхэд зориулж, энэ тэжээлийн хямдралтай байлгахын тулд өвс тэжээлийн гаалийн татварыг, НӨАТ-н татварыг хилээр орж ирэхэд нь чөлөөлөх ийм зайлиггүй шаардлага байна.

Тэгээд амьдрал мэдэхгүй хүмүүс маш их байна. Ялангуяа одоо Болорчулуун сайд бол Дорнод аймгаас сонгогдсон учраас тэнд одоо малын өвс тэжээлийн асуудал байдаггүй. Гэтэл энд одоо манай баруун аймагт чинь чулуу долоох нь холгүй явж байж л одоо мал хэдэн тарга авдаг, ийм л одоо нутагтай. Тийм учраас энэ малчдын амьдралыг, өөрөөр хэлбэл одоо гурилын үйлдвэрүүдийн хэвгийг бүрэн борлуулах зорилгоор гадаадын одоо энэ хивэг тэжээлийг хаах биш, илүү одоо хямд бүтээгдэхүүнээр одоо энэ малчдаа.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар, Хассуурын Ганхуяг, Салдангийн Одонтуяа нарын урилгаар БГД-ийн сургууль, цэцэрлэгийн багш нарын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Одоо хэлэлцэх асуудалдаа орно.

Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль,

**тогтоолын төслүүд /Засгийн газар
2022.09.29-ний өдөр өргөн
мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/**

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлуудыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүдээ байр эзлээрэй.

1.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд

хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 65.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 65.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын

хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 64.6 хувийн саналаар дэмжигдлээ

14.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 56.2 хувийн саналаар дэмжигдлээ.

15 Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. 59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 62 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 58 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 64 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэвийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон сууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Органик хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Таримал ургамлын үр сортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд

өөрчлөлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүдээ байраа эзлээрэй, санал хураалт. 57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зочин танилцуулья. Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар УБТЗ-ын Эрдэнэт өртөөний төмөр замын төмөр замчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж байна.

20.Засгийн үнэт цаас гаргах эрх олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44.9 хувиар дэмжигдсэнгүй. Гишүүд Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд горимын санал гаргана гэж байна.

Г.Ганболд: Сая би дэмжиж санал өгсөн, тэгээд эсрэг гарчихлаа. Санал хураалтыг хүчингүй болгож өгөх санал хураалт явуулж өгөөч гэж хүсэж байна.

Т.Аюурсайхан: Ганболд гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 57.1 хувийн саналаар дэмжигдлээ. Ингээд санал хураалтыг дахин явуулах, хүчингүй болгох горимын санал дэмжигдсэн учраас сүүлийн санал хураалтыг дахин явуулъя. 62 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй

гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Боломжгүй. Санал хураалт. Та Засгийн газар дээрээ асуугаарай. Засгийн газрын оруулж ирсэн санал байна. 47.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй. Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин горимын санал гаргана.

Т.Энхтүвшин: Миний хувьд энэ тогтоолын төслийг уул нь дэмжсэн, сая эсрэг гарч байна. Тийм учраас дахин санал одоо хураалт явуулж өгөөч гэж хүсэж байна.

Т.Аюурсайхан: Энхтүвшин гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүдээ байраа эзлээд сууж байгаарай, битгий босож яваад бай. Санал хураалт, санал хураалт явж байна. Засгийн газраас өргөн мэдүүлсэн, сайд нар босож яваад байх юм. 60.9 хувийн саналаар дэмжигдлээ. Горимын санал дэмжигдэж, сүүлийн санал хураалт хүчингүй болсон учраас санал хураалтыг дахин явуулъя. 61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

22. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 57.4 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулъя. 57.4 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд ишлэжүүлж байна. Ингээд хэлэлцүүлгийн үеэр гишүүд бас идэвхтэй оролцож, сая саналуудаа бас тухай бүрд нь гаргаж шийдвэрлүүлэх боломжтой. Дараагийн хэлэлцэх асуудалд оръё.

10.44 цаг

Хоёр.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна. Индэрт урьж байна таныг.

Х.Нямбаатар: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 53-т Дампуурлын тухай

хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгагдсан. Түүнчлэн 2021 оны 12 дугаар сарын гучны өдөр батлагдсан Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын тавдугаар хавсралтаар тус бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төслийн жагсаалтыг баталсан бөгөөд үүнд Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг боловсруулж, 2022 оны нэгдүгээр сард багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан.

Дампуурлын тухай хууль 1997 онд батлагдсан бөгөөд 25 дахь жилдээ зарчмын шинжтэй бие даасан өөрчлөлт ороогүй хэрэгжиж байгаа бөгөөд дотоод, гадаадын судалгааны байгууллага, ОУБ-аас Дампуурлын тухай хуулийг төлбөрийн чадваргүйдлийн харилцааны олон улсын чиг хандлагад нийцүүлэн сайжруулах шаардлагатай талаар дүгнэлт, санал, зөвлөмжид үндэслэн Дампуурлын тухай хуулийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өнөөгийн аргачлал, стандарт зарчмын дагуу шинэчлэн боловсрууллаа. Хуулийн төслөөр хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, нэхэмжлэлийн шаардлага гаргах, түүнийг хангах, хэрэг гүйцэтгэгчийн эрх хэмжээ, түүнийг томилох, чөлөөлөхтэй холбоотой зохицуулалт, үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурал, түүний эрх хэмжээ, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин зохион байгуулах, татан буулгах, төлбөрийн чадвартай боловч санхүүгийн хүндрэлд орж, төлбөрийн үүргээ зогсоосон хуулийн этгээдэд төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Банкны системийн онцлогоос шалтгаалан банкны дампуурлын асуудлыг Банкны хуулиар зохицуулахаар, салбарын онцлогоос шалтгаалан даатгал, ББСБ зэрэг санхүүгийн байгууллага болон төрийн байгууллага, албан газар, шашны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшилээс гүйцэтгэх боломжгүй, төрөөс нийтийн хэрэгцээг хангахдаа зайлшгүй шаардлагатай салбарт үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон орон нутгийн өмчит компани, хуулийн этгээдийн хувьд тэдгээрийн төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой нарийвчилсан харилцааг тус тусын хуулиар нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулахаар тусгасан болно.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Дампуурлын тухай хуулийн дагуу төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэлийг хуулийн этгээдийн өөрийн хөрөнгөтэй холбож тодорхойлсныг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэлийг бэлэн мөнгөний урсгал буюу төлбөрийн үүргээ ерөнхийд нь зогсоох болон балансын аргын аль нэг аргачлалаар тооцохоор төсөлд тусгалаа. Бодит байдал дээр төлбөрийн чадваргүй болсон эсэх нь тодорхой бус байдлаар иргэний эрх зүйн харилцаа, үүрэг хариуцлагаа умартах явдлыг эрх зүйн арга хэрэгслээр таслан зогсоохгүй байгаа нь өрийн сүлжээг нэмэгдүүлэн үүсгэх, шүүхийн шийдвэрээр гарсан төлбөр барагдахааргүй болох, эдийн засгийн харилцаа дахь итгэцлийг бууруулах зэрэг сөрөг үр дагавартай юм.

Тиймээс хууль, эсхүл гэрээнд заасан мөнгөн төлбөрийн үүргээ үргэлжилсэн 6 сараас дээш хугацаагаар биелүүлж чадаагүй хуулийн этгээдийн хуулийн этгээдийг төлбөрийн чадваргүйд тооцож, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх хүсэлт гаргах боломжтой болно. Түүнчлэн дампуурлын хэрэгтэй холбогдуулан ШЕЗ-өөс авсан

мэдээллээр Монгол Улсын шүүхээр 2004-2021 оны хооронд буюу 18 жилийн хугацаанд жилд дунджаар 15 хэрэг, нийт 268 дампуурлын хэрэг шийдвэрлэгдсэн байна. Дампуурлын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүсэлтээр үүсдэг онцгой ажиллагааны хэсгээр зохицуулагддаг байна. Гэтэл дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх онцгой ба ердийн ажиллагааных нь аль алиных нь шинжийг агуулж байна.

Иймд дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессыг төсөлд нарийвчлан тусгаж, уг хуульд заагаагүй харилцааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулахаар тусгалаа. Тус хуулийн төсөл нь төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, татан буулгахаас гадна түүнийг дахин зохион байгуулж, үйл ажиллагааг нь сэргээх, түүнчлэн төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад чиглэсэн хууль тул хуулийн нэрийг олон улсын жишигийн дагуу Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль гэж өөрчилсөн болно.

Хуулийн төсөл батлагдсанаар зах зээлийн эдийн засаг дахь нэг үзэгдэл болох төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг зохицуулсан, олон улсын жишигт нийцсэн үр дүнтэй эрх зүйн орчин бүрдэж, санхүү, зах зээлийн харилцааны ил тод байдал, хариуцлага сайжрах, эдийн засгийг цэвэршүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Тодруулбал бизнес эрхлэх гэж байгаа хуулийн этгээдийн эрсдэлийг хуваарилах, бизнесийг аварч үлдэх, ажлын байрыг хадгалах, дахин зохион байгуулах, хөрөнгө оруулалт хийх, бизнес эрхлэгчдэд 2 дахь боломж олгох, төлбөрийн чадваргүй боллоо гэхэд оруулсан хөрөнгө оруулалтаа ямар дарааллаар гаргуулж авах зэрэг асуудлыг тодорхой,

ойлгомжтой, оролцогч талуудын эрх ашиг, сонирхлын тэнцвэрийг хангах, сайжруулах чиглэлд Дампуурлын тухай хуулийг шинэчлэн боловсруулаа. Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү.

Т.Аюурсайхан: Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чинбат Ундрам танилцуулна. Индэрт урьж байна таныг.

Ч.Ундрам: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь төлбөрийн чадваргүйдлийн харилцааны олон улсын чиг хандлагад нийцүүлэн эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах, хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, нэхэмжлэлийн шаардлага гаргах, түүнийг хангах, хэрэг гүйцэтгэгчийн эрх хэмжээ, түүнийг томилох, чөлөөлөх үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурал, түүний эрх хэмжээ, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин зохион байгуулах, татан буулгах, төлбөрийн чадвартай боловч санхүүгийн хүндрэлд орж, төлбөрийн үүргээ зогсоосон хуулийн этгээдэд төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор хуулийн төслийг шинэчлэн боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг зохицуулах олон улсын жишигт нийцсэн эрх зүйн орчин бүрдэж, санхүү, зах зээлийн харилцааны ил тод байдал, хариуцлага сайжрах зэрэг таатай үр дагавар үүснэ гэж төсөл санаачлагч үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр банкнаас зээл авч зохиомлоор дампууруулах, дампуурах асуудлын зохицуулалтын талаар, давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалан эрсдэлийг тооцсон эсэх, хууль батлагдсанаар иргэд, хуулийн этгээдийн эрх ашигт хэрхэн нөлөөлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр хэрэг гүйцэтгэгчийг хэрхэн бэлтгэх, холимог хэлбэрээр дахин хөрөнгөжүүлэх асуудлыг тусгасан эсэх, хуулийн төслийн нэр оновчтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл хуулийн төслийн нэр, дампуурал гэсэн ойлголтыг бүрэн тодорхойлж чадах эсэх, төлбөрийн чадвартай боловч санхүүгийн түр хүндрэлд орсон этгээдийн асуудлыг энэ хуулиар хэрхэн зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин төлбөрийн чадваргүйдэлд орсон хуулийн этгээдийг дахин зохион байгуулах, бүтцийн өөрчлөлт хийх асуудлыг төсөлд хэрхэн тусгасан, нэхэмжлэлийн шаардлага хангах дарааллын талаар, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлэхээс өмнө үүрэг гүйцэтгэгч этгээд үнэ цэн бүхий патент, үйл ажиллагааны зөвшөөрөл, биет болон биет бус хөрөнгөө бусдад шилжүүлж, төлбөр төлөх үүргээс зайлсхийх асуудлын зохицуулалтын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төсөлд шүүхийн процессын асуудлууд голчлон тусгагдсан тул Хууль зүйн болон Эдийн засгийн байнгын хороо хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллах, Улсын

Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл хуулийн төсөлд хуралдааны талаарх эрх зүйн зохицуулалт дутуу тусгагдсаныг анхаарч, төслийн нэрийг Дампуурлын тухай гэж өөрчлөн илүү өргөн агуулга, харилцааг зохицуулахад чиглүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа банк, санхүүгийн салбарт чанаргүй активуудыг нэгтгэж, татан буулгадаг жишиг тогтоохоос сэргийлэх ТӨК-иуд энэ хуулийн зохицуулалтад хамаарахаар бол өмч хөрөнгийг нь үнэгүйдүүлэх, шамшигдуулахаас хамгаалах, нийтэд нээлттэй ХК-уудын төлбөрийн чадваргүйдлийн асуудал дээр нийтийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалтыг тусгах, энэ талаар бусад улс орнуудын туршилагыг судалж, хэлэлцүүлгийн үед анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа явагдаж байгаа этгээдтэй холбоотой зээлдэгч, хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах, төлбөрийн чадваргүйдэлд орсон этгээдийг үйл ажиллагаагаа дахин эхлүүлэх дараагийн боломжийг нээж өгөх, энэ хуулиар хуулийн этгээдийг татан буулгахтай холбоотой хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх замаар дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлэх гэсэн саналуудыг тус тус хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн

болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Арбитрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруул оруулах тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Векселийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэдийн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн түрээс, лизингийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний

төлбөрийн системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хадгаламж зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Т.Аюурсайхан: Баярлалаа. Ажлын хэсгийн танилцуулъя. Хишгээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сайнзориг мөн яамны ТНБД, Цолмон мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Аюуш Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Ганбагана Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн гэсэн ажлын хэсгийг танилцуулж байна. Одоо хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Булгантуяа гишүүнээр тасаллаа. Гэхдээ дэлгэц хамаагүй. Зочин танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтын урилгаар Ховд аймгийн Жаргалант сумын ЕБС-ийн 1987 оны төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их

Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүн одоо Ширнэнбаньдын Адьшаа асуулт асууна.

Ш.Адьяа: Яасан гэнэ? Явчихсан байна шүү дээ. Энэ Дампуурлын тухай хууль гэж байсныг сайхан ингээд төлбөрийн чадваргүй гээд нэр оруулж ирсэн байна л даа. Тэгэхдээ энэ дампуурлын тухай гэдгээрээ л явах нь зөв байх гэж бодож байгаа юм. Үнэхээр чадваргүй болсон ААН, иргэн хэнбугай ч дампуурч байгааг нь энэ төр зарлаж, энэ нэрээсээ хүртэл цаашидаа ичиж зовох ийм одоо урьдчилан сэргийлэх асуудал хүртэл байна шүү дээ. Тийм учраас энэ нэрийн хувьд тэр төлбөрийн чадваргүй гэдэг ийм сайхан нэр томъёо болих хэрэгтэй байх гэсэн ийм саналтай байна.

Энэ Монгол Улс чинь энэ ер нь ААН-шүд, ТӨК-ууд, иргэд тэгээд олон зүйл ингээд өр ширэнд баригдаж, янз бүрийн байдлаар ингээд дампуурал ирмэг дээр болсон. Энийг засаж залруулах, цаашид ийм асуудал гаргахгүй байхын төлөө энэ хуулийн төслийг оруулж ирж байгаа гэж ойлгож, энийг хэлэлцэх нь зөв гэсэн ийм бодолтой байна. Тэгэхдээ энд бас их олон анхаарал татсан асуудал байна. Энэ төрийн болон энэ улс төрчтэй хамааралтай бүхий энэ Хөгжлийн банкны энэ асуудал өнөөдөр яригдаж байгаа энэ цаг үед энэ Дампуурлын тухай энэ хуулийг оруулж ирж байгаа. Түүнчлэн энэ Хөгжлийн банкны асуудал дээр энэ ирээдүйд олох орлогоор барьцаалж зээл авсан ийм асуудлууд байдаг. Ирээдүйд орлого олохгүй байх юм бол энэ Дампуурлын хуулиар чинь яах ёстой юм бэ, энийг нэг тодруулж өгмөөр байна.

Дээр нь энэ шүүхийн шийдвэрээр энэ өр төлбөрөө барагдуулахгүй байгаа, энэ хүмүүс болон ААН, бусад энэ ТӨК-уудад ямар одоо шат дараатай арга хэмжээ авах юм бэ? Энэ хоосон хүний 2 чихийг авахгүй гэдэг ийм зарчим яриад сууж байвал ер нь цаашидаа энэ

Монголын төр энэ хохирлыг барагдуулахын төлөө ер нь яах ёстой вэ гэдэг энийг бүр тодорхой болгож өгмөөр байна. Түүнчлэн энэ дагалдах олон хуулиудад энэ өөрчлөлт орох юм байна. Энэ улс төрийн намуудын тухай, энэ Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль ч энд ямар одоо байдлаар энд холбогдож энд өөрчлөлт оруулах гэж байгаа юм бэ? Энэ Улс төрийн намуудын тухай, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, энэ Дампуурлын хууль, энэ төлбөрийн чадваргүй болсон энэ асуудал чинь ямар зүйл заалтын өөрчлөлт оруулах юм бэ гэдгийг бас тодруулж асууя. Ийм зүйлийг асууж байна. Ингээд хариулт авъя.

Т.Аюурсайхан: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Баярлалаа, би Адьяа гишүүний асуултад хариулъя. Энэ 1997 онд батлагдсан, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Дампуурлын тухай хуулиар дампуурал, ААН-ийг татан буулгахтай холбоотой харилцааг түлхүү зохицуулчхаад байгаа юм. Дэлхий нийтийн жишиг нь тухайн ААН-ийг төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэх, хуулийн этгээдийг дахин зохион байгуулах, төлбөрийн чадвартай боловч санхүүгийн хүндрэлд орж төлбөрийн үүргээ зогсоосон хуулийн этгээдэд төлбөрийн чадваргүйдлээс нь урьдчилан сэргийлэхтэй холбоотой цогц энэ харилцааг энэ удаагийн төлбөрийн чадваргүйдлийн хуулиар одоо зохицуулахыг зорьж байгаа.

Хоёрдугаарт, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд заасан процессын дагуу дампуурлын хэрэг үүсгэж шийдвэрлэж шийдвэрлэх процесс явагдаж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр энэ дампуурлын харилцаа, төлбөрийн чадварын харилцаа гэж 2 төрлийн харилцаа, 2-улаа процесс шаарддаг харилцаа. Ийм учраас төлбөрийн чадваргүйдлийн харилцаа болон

дампуурлын харилцаа хоёулан дээр нь байвал зохих процессыг энэ төлбөрийн чадваргүйдлийн хуулиар зохицуулж өгөхийг зорьж байгаа. Бусад энэ процессоор зохицуулагдаагүй харилцааг нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулъя гэсэн ийм агуулгаар орж ирж байгаа.

Дэлхийн банк, ОУВС манай улсад одоо санхүүгийн дэмжлэг үзүүлдэг донор байгууллагуудын маш олон жилийн зөвлөмжүүдэд танай улс энэ төлбөрийн чадваргүйдлийнхээ харилцааг шинэ түвшинд, олон улсын стандартын дагуу зохицуулахгүй бол танайд энэ нөгөө ийм төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой харилцаа маань ужгирч даамжирч, олон ААН-үүд одоо дахин зохион байгуулах боломжгүй болтлоо дампуурал руу очиж байна. Мөн иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны дараа төлбөрийн чадваргүй болсон ААН-үүдээс хөрөнгө оруулагчийн оруулсан хөрөнгө оруулалт, төлбөл зохих төлбөрийн одоо тэр гүйцэтгэлийг хангуулахад хүндрэлтэй ийм зүйлүүд их үүсэж байна гэдэг ийм зөвлөмжүүд дурдагдсан.

Саяын таны тэр хэлж байгаа 2 дахь асуулт бол Хөгжлийн банк энэ тэртэй холбоотой асуудал яг ид яригдаж байгаа үед энэ Төлбөрийн чадваргүйдлийн хуулийг хэлэлцэж байгаа нь хардлага төрүүлж байна гэдэг агуулгаар ярьж байна. Та сая намайг хууль санаачлагчийн илтгэлийг уншиж байхад гадаа байсан учраас та сонсоогүй юм шиг байна. Банкны харилцаа, банк бус санхүүгийн харилцаа, даатгалын харилцаа, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой харилцааг тухайн өөр өөрийнх нь салбарын хуулиар зохицуулна. Энэ хуулиар ерөөсөө огт зохицуулалт шаардахгүй гэдгийг хэлье. Цолмон нэмээд тэр Улс төрийн намуудын тухай хууль болон бусад холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж байгаа талаар нэмэлт тайлбар өгчих.

Т.Аюурсайхан: 85 дээр нэмж хариулъя.

Д.Цолмон: Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Цолмон байна. Адьшаа асуултад нэмэлт байдлаар хариулъя. Энэ Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаад бол нэлээд 46, 47 хууль бол дагах хууль төсөл орж ирсэн. Ихэвчлэн бол дандаа одоо хуулийн нэрийг Дампуурлын тухай хуулийн нэрийг Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль гэж нэрийг өөрчилсөнтэй холбоотойгоор орж ирсэн өөрчлөлтүүд байгаа. Тийм.

Хоёрдугаарт гэх юм бол ерөнхийдөө Дампуурлын тухай хуулийн бол гол зорилго бол яг тухайн одоо хуулийн этгээдийг бол татан буулгаад, үйл ажиллагааг нь зогсоогоод дампууруулахдаа дампууруулах зорилгод бол оришихгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл тухайн одоо үйл ажиллагаа нь санхүүгийн хүндрэлд орчихсон, тухайн үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болчихсон хуулийн этгээдийг цаашид дампууруулах эсэх, эсвэл одоо тухайн үйл ажиллагааг нь дэмжээд үүрэг гүйцэтгүүлэгч зээлдэгч нартай нь дэмжиж, одоо харилцан дахин зохион байгуулах ажиллагаанд оруулах байдлаар тухайн бизнесийг нь сэргээх ийм зорилго, мөн түүнчлэн бас энэ хуульд орж ирсэн гол онцлог бол бас төлбөрийн чадвартай боловч тухайн одоо бизнесийг хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болчихсон хуулийн этгээдэд бас бүтцийн өөрчлөлт бол оруулах ийм бас боломжийг олгочихсон энэ зорилгоор бас энэ хууль төсөл бичигдсэн учраас Төлбөрийн чадваруудын тухай хууль гэж хуулийн нэрийг бас олон улсын жишигт нийцүүлэн ...law гэдэг энэ чигт нийцүүлэн бид нэрээ өөрчилсөн гэдгийг бас хэлэх нь зөв байх.

Т.Аюурсайхан: Адьшаа гишүүнд микрофон нэмж өгье.

Ш.Адъяа: Энэ төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдүүдийг одоо дахин шинээр зохион байгуулж, энд дэмжлэг үзүүлэх тухай асуудлыг энэ хуулийн үзэл баримтлалд тодорхой дурдсан байна. Энэ төлбөрийн чадваргүй болсон тэр дампуурсан ААН-үүдийг ямар хэлбэрээр дахиж зохион байгуулж, төрөөс болон хуулиар ямар дэмжлэг үзүүлэх юм бэ гэдэг талаар бас нэг тодорхой хариулт авмаар байна.

Т.Аюурсайхан: 83 дээр хариулъя.

П.Сайнзориг: Энэ дээр бол төрийн ямар нэгэн одоо хөрөнгөөр юм уу, татвар төлөгчдийн мөнгөөр одоо энэ дэмжлэгийг үзүүлэх асуудал ерөөсөө байхгүй. Энэ бизнесийн зарчмаар явуулах харилцаа байгаа. Өөрөөр хэлэх юм бол энэ тухайн хуулийн этгээдтэй холбогдож зээл олгосон ААН-үүд, зээл олгосон хувь этгээдүүд хамтран ажиллаж байгаа одоо ААН болон анхнаас нь одоо хувь нийлүүлж оруулсан хувьцаа эзэмшигчдийн хооронд нь ямар ажлыг энэ тохиролцож, ямар дэс дараалалд оруулж, эсвэл одоо үйл ажиллагааны чиглэлийг нь өөрчлөх үү, эсвэл үнэхээр ашиггүй байгаа тэр секторыг нь татан буулгах уу, зээлийн эргэн төлөлтийн хуваарийг өөрчлөх үү ч гэдэг юм уу, олон энэ үйл ажиллагааг шүүхийн оролцоотойгоор хяналттайгаар хийх ийм алхмыг л хийж байгаа.

Түүнээс биш татвар төлөгчдийн мөнгөөр одоо үйл ажиллагаагаа сэргээгээд нэг төгрөг ч өгөх энэ заалт энэ хууль дээр байхгүй. Ийм ерөөсөө концепцтой хууль биш гэдэг зүйлийг бас танд хэлье.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр асуулт асууна.

Б.Энхбаяр: Ер нь сүүлийн 3 удаагийн Улсын Их Хурал миний мэдэхийн бол 4 Засгийн газар дамнаж одоо орж ирэх маш их хүлээлтэд тоосон

дотор дарагдсан байсан энэ Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийг оруулж ирсэнд баяртай байна. Энэ бол маш чухал хүн болгон анзаардаггүй, ийм харилцаа байгаад байгаа юм. Манай улс чөлөөт эдийн засагт шилжсэн гэж ярьдаг. Бизнес, зах зээлийн харилцаа гэж ярьдаг. Эрсдэлгүй бизнес гэж байдаггүй. Эрсдэлгүй, ялангуяа одоо өөрөөс шалтгаалдаггүй ийм одоо ковидын, дайн тулааны ийм одоо зүйлүүд, нөхцөл байдлууд ямар ч бизнест маш том эрсдэлийг авчирч байна. Ялангуяа энэ сүүлийн 2, 3 жилийн хугацаанд бол маш олон ААН-үүд хаалгаа барилаа, иргэдийн ахуй амьдрал хүндэрлээ. Яалт ч байхгүй одоо дампуурч байгаа хүмүүс байна. Тэгэхээр бусад улс оронд бол энэ гол асуудал бол хүнийг энэ амиа хорлоход хүнийг хэмжээнд хэзээ ч аваачиж болохгүй гэж үздэг. Ямар ч эрсдэл учирсан бай энэ амиа хорлох тэр зүйл рүү түлэхгүйгээр тэр хүнийг бас аварч байх ёстой. Насан туршидаа үхэн үхтлээ өртэйгөө үр хүүхдээ одоо хэн нэгэнд өртэй болгоод үхдэг ийм одоо зүйл байж болохгүй гэж. Тэгэхээр энэ зарчим бол одоо бас нэгдүгээр зарчим.

2 дахь зарчим нь бол манай энэ Дампуурлын хууль үнэхээр шаардлага хангахгүй болсноос улбаалаад сүүлийн 20, 30 жил зохиомлоор худлаа дампууруулж, залилан хийдэг, авлигаждаг, мөнгө угаадаг бүхэл бүтэн технологи бий болсон байна. Хамгийн анх энэ Төв Ази банк гээд 90-ээд оны үед дампуурч байсан. Ард банк, Сэргээн босголтын банк, хамгийн сүүлд Капитал банк. Өөрөөр хэлбэл өөрсдөө одоо танил талууддаа эзэд өөрсдөө зээл аваад, худлаа дампуураад, тэгээд татвар төлөгчдөөр энэ хохирлыг төлүүлдэг, мэргэжсэн ухаантай хашилт дотор хэлж байгаа шүү би. Хашилт дотор ухаантай, ийм сүлжээ хулгай хийдэг технологи бий болчихсон байна.

Тийм учраас энийг хаах ёстой. Өөрөөр хэлбэл худлаа дампуурч, ард түмний мөнгөөр, татвар төлөгчдийн

мөнгөөр ерөөсөө энэ баяждаг, энэ юмыг таслан хаахын тулд энэ хууль заавал орж ирэх шаардлагатай байсан юм. Заавал орж ирж энэ нүх сүвийг хаах шаардлагатай байсан юм. Тийм учраас би хэлж байгаа юм. Энэ маш удаан дарагдсан, би бол энийг бас санаатай байсан байх гэж боддог юм шүү. 3 Улсын Их Хурал, 4 Засгийн газар дамнаж дарагдсан. Нямбаатар сайд оруулж ирлээ. Би энд баяртай байна. Үнэхээр одоо бас нэг энэ цагаан захтны энэ мөнгө угаадаг сүлжээг таслан зогсоочихъя гэсэн ийм одоо сэтгэл зүрх, бодит үйлдэл хийгээд байна, бодит үйлдэл. Тийм учраас энэ хуулийн одоо хэлэлцэх эсэхийг дэмжиж батлах ийм одоо шаардлагатай байна. Тэгэхээр энэ нүх сүвийг хаах чиглэл дээр одоо бас энэ хуулийн төсөлд ямар шинэлэг зохицуулалтууд, онцлог зохицуулалтууд одоо үйлчилж байгаа хуулиас орж ирсэн бэ гэдэг ийм асуулт байна.

Т.Аюурсайхан: 85 дугаар микрофон дээр ажлын хэсэг хариулъя.

П.Сайнзориг: Би хариулчихъя. Энхбаяр гишүүнийг бас дэмжиж байгаад бас юун түрүүнд бас талархаж байна. Тэгээд энэ 1997 оны хууль маань бол анх батлагдаад 3 жилийн дараанаас л өөрчлөлт оруулах шаардлагатай юм байна, шинэчлэх шаардлагатай юм байна гээд энэ яриа үндсэндээ 2000 оноос эхэлсэн байдаг. Үе үеийн Засгийн газар энийг боловсруулах ажлыг хийсэн боловч бас дорвитой яг түлхэцтэй юм болоогүй байсан. Сүүлийн одоо 4, 5 жил бид нар бас ОУВС, Дэлхийн банкны зөвлөхүүдтэй, эргээд энэ судлаачид, шүүхийнхэн, одоо шүүгч нартайгаа хамтарч, бас энэ хуулийн төслийг бол үндсэндээ боловсруулж бас оруулж ирж байгаа юм гэдэг зүйлийг бас танд хэлье.

Тэгээд мэдээж энэ яг санаатайгаар дампуурах буюу яг таны хэлж байгаа энэ гэмт хэрэг, энэ хувь, хөрөнгө оруулагчдын хөрөнгийг эргээд энэ магадгүй банк, банк бус санхүүгийн

сектор дэх тэр хадгаламж одоо эзэмшигчдийн мөнгийг луйвардах энэ ажиллагаа бол тусдаа гэмт хэргээрээ явна. Мэдээж энийг ял хариуцлагыг чангалах ёстой, шалган шийдвэрлэх процесс ч гэсэн бас хуулийн дагуу явна. Банкны дампуурлын харилцаа бол Банкны хуулиар явж байгаа. Тэгэхээр энэ хууль бол одоо ба үйлчлэхгүй гэсэн үг байгаа. Энэ болохоор бусад тэр Монгол Улсад одоо 200-гаад мянган хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хамаатай ийм зүйл байгаа. Таны хэлж байгаа маш зөв, энэ өөрөө эргээд зөвхөн тэр алдаа луйврууд нь банкны секторт яваад байгаа юм биш, бүхий л одоо энэ аж ахуйн төрлийн компаниуд дээр явж байна гэсэн үг. Баахан хөрөнгө төвлөрүүлдэг, захирлуудын одоо юу гэдэг юм үр ашиггүй бодлого шийдвэр, эсвэл одоо юу гэдэг юм тэр компанийг анхнаас нь дампууруулж тооцоод, өөрт байгаа ашигтай хөрөнгүүдийг бусад этгээд рүү үнэ төлбөргүй шилжүүлэх ч гэдэг юм уу, ийм зүйлүүдийг хийдэг үзэгдлүүд сүүлийн үед бас хавтгайдаа байна, гарч байгаа.

Тэгэхээр энэнээс урьдчилан сэргийлж бас одоо нэлээн олон зохицуулалтууд орж байгаа. Тухайлбал одоо юу гэдэг юм яг одоо дампуурлын хэрэг, нөхцөл байдал үүссэнээс өмнөх тэр 2 жилийн хугацаанд аливаа этгээд рүү шилжүүлсэн эд хөрөнгүүдийг үнэ төлбөргүй шилжүүлэх юм бол энэ гэрээнүүдийг хүчин төгөлдөр бусад тооцохоор, эргээд одоо яг энэ үйл ажиллагаа, энэ чиглэлийг нь өр хөрөнгийг дахин хуваарилах, олж тогтоох энэ олон үйл ажиллагаануудыг бас одоо шүүхийн оролцоотойгоор хийх энэ бололцоо бас цаашидаа бүрдэх юм. Тэгэхээр мэдээж одоо юу гэдэг юм бизнес бас хийж байгаа боловч бас таны ярьж байгаа ковид ч байдаг юм уу, логистикийн асуудлаас ч юм уу, олон зүйлээс бас бизнес эрсдэж болно. Энэ эрсдэлийг бид нар яаж хуваарилах вэ, энэ компанийг аварч үлдсэнээр татварын бааз сууриа аварч үлдэх, тэр одоо ажлын байрыг аварч үлдэх энэ алхам руу л илүү их зорихыг

хичээж, бас энэ Засгийн газраас оруулж ирж байгаа.

Тэгээд гаднын хөрөнгө оруулагчид орж ирээд Дампуурлын хуулийг л хардаг. Бид одоо бизнес тодорхой нөхцөл байдал эрсдэх юм бол ямар дэс дарааллаар бид нарын энэ хөрөнгийг гаргах юм бэ гэдэг зүйлийг л одоо харж байгаа. Тэгэхээр бид хэд энэ өөрөө бас гаднын хөрөнгө оруулалтыг татах, бас эдийн засгийг эрүүлжүүлэх, өрийн сүлжээнээс ангид байх суурь одоо бизнес эрхлэгчдийн.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр асуулт асууна.

Б.Баттөмөр: Энэ 25 жилийн хугацаанд бол дорвитой өөрчлөлт ороогүй. Бусад хуульд орсон өөрчлөлтийг дагаж 3, 4 удаа өөрчлөлт орсон нь ингээд нийгэмд гүйцэтгэх үүргээ бол хангалттай биелүүлж чадаагүй гэсэн ийм одоо дүгнэлт гарсан байдаг юм байна лээ. Олон цоорхой байсан нь энэ цоорхойнуудыг одоо бөглөж, тухайн үед нь бөглөж нөхөж чадаагүй. Энд энэ хамгийн гол асуудлуудын нэг нь энэ төлбөрийн чадваргүйд тооцох, одоо гол шалгуур бол өрийн хөрөнгийн талаар, тэр өрийн хөрөнгийн талаар Компанийн тухай хуульд, Дампуурлын тухай хуульд бол өөр өөрөөр заачихсан байгаа. Энийг одоо засаагүй. Хэрэг гүйцэтгэгчтэй холбоотой асуудлуудын энэ зохицуулалт муу байгаа. Дампуурлын хуулийн гол асуудлуудын нэг бол дахин хөрөнгөжүүлэх асуудал байдаг. Энэ өнгөрсөн практикаас үзэхэд бол дампууралтай холбоотой 174 хэрэг одоо шийдсэнээс зөвхөн 7-д нь дахин хөрөнгөжүүлэх асуудлыг шийдсэн. Энэ асуудлыг нь одоо авч хэлэлцсэн асуудлын 4 хувьтай л тэнцэж байна л даа.

Тэгэхээр зэрэг энэ дампууруулаад хаяад авах биш, боломжтой зүйлийг нь дахин хөрөнгөжүүлээд, тэр хохиролгүй болгох асуудал дээр нь их голлож

анхаарах ёстой юм. Тэр энэ тооноос харахад л одоо дампуурлын хууль хохирогчдын эрх ашгийг хамгаалах биш, зөвхөн өр төлбөрөөс л чөлөөлөх, энийг нэг хаах нэг л ийм л одоо болсон ийм л хууль болчихсон байгаа юм л даа. Ер нь одоо энэ сая Энхбаяр гишүүний хэлж байгаа. Энд бол мэргэжлийн хулгайч нар бол их ажиллаж, компани байгуулаад тодорхой ААН-үүдтэй гэрээ байгуулаад, тэгээд тэр бараа бүтээгдэхүүнийг нь авчхаад буцаж төлдөггүй, дампуурсан ийм л юм болчихсон л байгаа юм л даа. Тэгээд энэ цоорхойг одоо яаж нөхөж, одоо хуульд яаж орж ирж байна гэсэн эхний асуулт байгаа.

Энэ 2019 онд Дэлхийн банкнаас гаргасан бизнес эрхлэх үү гэсэн судалгаанд бол 10 гол үзүүлэлтээр судалгаа хийж үзэхэд төлбөрийн одоо чадваруудын үзүүлэлтээр 190 оноос Монгол Улс 152-т орсон байгаа юм л даа. Энэ бол одоо хуулийг өөрчлөх гол одоо ийм үндэслэл болж байгаа юм. Гаднын одоо том компаниуд тухайн оронд хөрөнгө оруулалт хийхдээ төлбөрийн чадваргүйдлийн хуулийн одоо үр дүнтэй байдлыг их онцгойлж үздэг. Өөрөөр хэлбэл одоо хэд юм 20, 30 үзүүлэлтээр одоо үзэхэд бол энэ дотор тэр төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг яаж шийдэж байна гэдэг нь гол үзүүлэлт болдог. Монгол Улсад бол одоо энэ гаднын хөрөнгө оруулалт одоо байхгүй болчихсон байгаа шүү дээ. Тэгээд олон шалтгаан байгаа. Энэний нэг нь бол одоо энэ дампуурлын энэ хууль, энэ чадваргүйдлийн хуульд энэ муу зохицуулалттай бас холбоотой байж болзошгүй гэсэн ийм зүйлийг хэлэх гэж байгаа юм.

Төлбөрийн чадваргүйдлийн асуудлаа одоо сайн шийдсэн улс орнууд, бизнес эрхлэлт одоо нэмэгдэж, хувийн хэвшилд одоо олгосон зээлийн хэмжээ нэмэгдүүлж, санхүүжилт одоо өндөр байдаг гэсэн ийм судалгаа бол гарсан байдаг юм. Тийм учраас бол энэ зүгээр нэг дампуурлын хууль биш, энэ бол өөрөө

хөгжлийг дэмжсэн ийм хууль байх ёстой гэдэг одоо ийм зүйлийг би хэлэх гэж байгаа юм.

Тэгээд дараагийн асуудал бол юу вэ гэхээр энэ бусад орнуудын туршилагыг одоо хэр зэрэг авч үзсэн бэ? Энэ эрсдэл одоо төлөх эрсдэл үүсгээд төлж чадахгүй гээд жүжиглээд, тэгээд одоо баахан ААН хувь хүмүүсийг хохируулах одоо нэр төртэй хүмүүс хүртэл энд оролцчихсон явж байгаа шүү дээ. Тэгээд энэ бол статистик тоо байдаг байх.

Энэ хуулийг хэрэгжүүлэх нэг гол субъект бол шүүгч нар. Шүүгч нар ер нь хэр зэрэг яг энэ чиглэлд одоо бэлтгэгдсэн байдаг юм бол? Энд одоо та бүгд тоо байна уу, үгүй юу? Энэ дахин хөрөнгөжүүлэх асуудал бол би түрүүн асуусан, хариулт авч чадаагүй.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Баттөмөр гишүүнд микрофон өгье, асуултаа гүйцээе.

Б.Баттөмөр: Дахин хөрөнгөжүүлэх асуудал бол шүүхийн одоо хяналт дор хийгдээд байгаа юм. Тэгэхээр би түрүүн хариулт авч чадаагүй. Энэ хосолсон арга гээд байгаа шүү дээ, тийм ээ. Шүүхийн шүүхээс гадуур тэр тохиролцож гэрээгээ хийгээд, шүүхийн хяналт дор хийдэг тэр хосолсон арга гээд энэ олон улсад байдаг юм байна лээ. Энийг та нар судалж барьж үзсэн үү гэсэн ийм асуултуудад хариулт авъя.

Т.Аюурсайхан: Нямбаатар сайдад микрофон өгье.

Х.Нямбаатар: Би Баттөмөр гишүүний асуулт эхний асуултад хариулъя. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Дампуурлын тухай хуулийн дагуу төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэлийг хуулийн этгээдийн өөрийн хөрөнгөтэй холбож үздэг, холбож тодорхойлдог. Тэгвэл олон улсын жишигт юу гэж үзэж байгаа вэ гэвэл

төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэлийг бэлэн мөнгөний урсгал буюу төлбөрийн үүргээ ерөнхийд нь зогсоох болон балансын аргын аль нэг аргачлалаар нь тооцохоор энэ одоогийн энэ өргөн мэдүүлж байгаа төсөлд тусгасан. Өөрийн хөрөнгөтэй нь холболгүйгээр. Энэ балансын арга энэ өөрийн бэлэн мөнгөний урсгал 2-той нь ингээд холбож тайлбар хийе. Ингэхдээ төлбөрийн үүргээ үргэлжилсэн 6 сар буюу түүнээс дээш хугацаагаар биелүүлж чадахгүй байгаа тохиолдолд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлж гэж байгаа юм. Эхлүүлснээс хойш дараагийн арга хэмжээ авагдана. Тэр нь юу вэ гэхээр нэгдүгээрт дахин зохион байгуулах уу, хоёрдугаарт дахин хөрөнгөжүүлэх үү, эсхүл үнэхээр одоо цаашид энэ 2 аргыг авч хэрэгжүүлэх боломжгүй бол шууд одоо тэр хуулийн этгээдийг татан буулгаад, өөрт байгаа хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгүүдийг бүгдийг нь худалдан борлуулаад төлбөр авагсдынх нь дарааллаар шүүхийн шийтгэх шүүхийн шийдвэрт дурдсаны дагуу төлбөр төлөх ийм ажлыг зохион байгуулж байгаа юм.

Тэгэхээр бид нарын таны саяын хэлж байгаа аягүй та чухал зүйлийг хөндөж байна лээ. Энэ дэлхийд аягүй нэр хүндтэй энэ индекс байдаг. Энэ нөгөө бизнес эрхлэх үү гэдэг энэ индекс байдаг. Энэ индексээр манай улсыг 2 зүйл хамгийн хойш татдаг юм. Нэг нь болохоор энэ төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой эрх зүйн орчин тодорхойгүй байгаа. Өөрөөр хэлбэл төлбөрийн чадвараа нөгөө ААН байгууллагууд бусдад төлөх төлбөрөө 6 сар буюу түүнээс дээш хугацаагаар төлбөрөө төлж чадахгүй байхад нь үйл ажиллагааг нь зогсоолгүй явуулсаар л байдаг. Ингэсээр байгаад нөгөө бизнесийн эрх зүйд маш том ужиг өвчнүүдийг үүсгэчихдэг. Жишээлэхэд, одоо нөгөө Дорноговь аймгийн нутгаар тавьсан төмөр замтай холбоотой ААН-үүдийн өр авлага одоо 10 хэдэн жил яригдаад л байгаа юм. Өмнөговьд

тавьсан төмөр замтай холбоотой. Энэ тэрнээс болоод маш олон ААН, байгууллагууд, нөгөө ажил гүйцэтгэгч ААН-үүд нь аль хэдийнээ дампуурчихсан. Гэтэл тэр өр авлагаа нэхээд 18, 36, 54 сар болсон хойно нь нөгөө компанийн үйл ажиллагааг зогсоодоггүй явуулаад л байдаг.

Дараагийн нэг бид нарын ярих гэж байгаа юм бол тэр бизнес эрхлэх үед хамгийн том саад учруулж байгаа 2 дахь зүйл бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа. Өнөөдөр манай улсад хийсэн судалгаагаар иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа 16 жил явсан тохиолдол байна. Дундаж үнийн дүнтэй 3.5 сая төгрөгтэй холбоотой нэхэмжлэлтэй, магадгүй төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой нэхэмжлэлтэй хэрэг өнөөдөр дундаж хугацаа мөн л 3.5 жил үргэлжилж байгаа юм. Гэтэл 15 сая төгрөгийн нэхэмжлэл гаргаад 3.5 жил үргэлжлээд шүүхийн зардалд нь нөгөө нийт үнийн дүнгийнхээ 10 гаруй хувийг, шүүхийн 20 хувийг нь шүүхийн зардалд өгчхөж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ 2 зүйлийг эхний ээлжид засъя гээд өнөөдөр энэ Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийг оруулж ирж байгаа.

Хоёрт нь дараагийн ээлжид бид нар оруулж ирэх гэж байгаа юм бол иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай харилцааг шинэ түвшинд гаргая. Энэ 2-ыг шийдэж байж бид нар олон улсад бизнес эрхлэхүй индексээрээ дээгүүр гарч ирнэ л гэсэн ийм зүйтэй байгаа.

Хоёр гэвэл гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалт хийх хамгийн гол баталгаа нь энэ 2 дээр бас оршиж байгаа юм. Нэмээд хэн Цолмон, Аюуш 2 хариулъя.

Т.Аюурсайхан: 85 дугаар микрофон 1 минут.

Д.Цолмон: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг одоо яг эхлүүлэх гол үндсэн 2 шаардлагыг бол шинэчилсэн найруулгын төсөлдөө бол бид тусгасан. Одоогийн хуулиар бол яг тухайн хариуцагч этгээдийн өөрийн хөрөнгийн 10 хувьтай тэнцэх төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаа тохиолдолд төлбөрийн чадваргүй гэж тооцож байгаа. Тэгэхээр хариуцагч этгээд бол мэдээж өөрийн хөрөнгийг тодорхойлохын тулд тухайн одоо байгууллагын бас нийт өр төлбөрийн асуудлыг судлах, санхүүгийн тайлангийн одоо судлах ийм шаардлага үүсч байдаг учраас, бас нэхэмжлэгчийн зүгээс бол энэхүү баримт бичигтэй танилцах бас энэ боломжууд нь бас хязгаарлагдмал байж байдаг.

Шинэчилсэн найруулга дээр бол бид энэ 2 энэ балансын арга болон бэлэн мөнгөний урсгалын арга 2-ыг хослуулсан. Өөрөөр хэлбэл энэ 2 аргын аль нэг нь одоо нөхцөл нь бүрдсэн тохиолдолд тухайн этгээд маань төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлтээ шүүхэд гаргах эрхийг нь нээж байгаа юм. Өөрөөр хэлбэл, зээлдэгч, зээлдүүлэгч талдаа бол нь одоо төлбөрийн чадвар, үйл ажиллагаагаа эхлүүлэх энэ боломж нь бол их нээлттэй, хялбар болж өгч байгаа юм. Хэрэг гүйцэтгэгчийн хувьд.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Цагтаа багтааж хариулна. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Цэндийн Сандаг-Очир нарын урилгаар Налайх дүүргийн 23, 187 дугаар цэцэрлэгийн багш, ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа асуулт асууна.

Х.Булгантуяа: Энэ бас их чухал хууль орж ирж байгаа. Түрүүн бас Баттөмөр гишүүн бас хэллээ. Монголд компани байгуулна гэдэг бол амархан болчихсон юм байна. Татан буулгана гэдэг бол аягүй хэцүү ажил юм байна, тэгээд хэтэрхий их эрсдэлтэй юм байна. Ингээд ерөөсөө Монголд бизнес хийх сонирхолтой хүмүүс бол орж ирэхдээ хэд хэдэн хуулийг хардаг гэсэн Компанийн тухай хуулийг, Хөрөнгө оруулалтын тухай хуулийг, дээрээс нь нэмээд энэ хуучнаар бол Дампуурлын тухай хуулийг гээд ингээд нэг хэдэн хуулийг харахаар хэтэрхий их процесс ихтэй, их тодорхойгүй ийм байсан учраас бас Монгол Улсын улс хөрөнгө оруулалт хийхэд ийм таатай биш орчин хууль, зүйн эрх зүйн хувьд бол таатай биш орж ингээж үзэж байгаа юм байна.

Би нэг ийм хэдэн асуултыг асуух гэсэн юм. Та бүхэн энэ хууль батлагдахаар жилд ер нь хэдэн дампуурлын хэрэг одоо шүүх дээр очоод ингээд хүн томилж ажиллуулаад ийм хэдэн хэрэг очно гэж үзэж байгаа юм бэ? Шүүх яг энэ асуудлаар ер нь хэр их чадавхажсан юм бэ? Өнгөрсөн хугацаанд Дампуурлын тухай хууль үйлчлэхийн хувьд бол үйлчилсэн. Тэгэхэд ер нь өнгөрсөн хугацаанд энэ хууль үйлчилсэн хугацаанд хэчнээн компанийн асуудлыг шийдвэрлэсэн юм бэ? Энүүгээр яг мэргэшсэн хүмүүс бас байгаа юм уу? Яагаад гэвэл энэ чинь нэлээн жоохон мэргэшсэн ажил болчихдог. Миний одоо мэдэхээр компани нь одоо манайх ингээд дампуурлын ирмэгт ирж байна ч гэдэг юм уу, төлбөр тооцооны хувьд хүндэрлээ гээд ингээд очих юм бол авлагатай компани нь ч гэсэн гомдол гаргаж болно, өөрсдөө ч гэсэн хүсэлт гаргаад танайх санхүүгийнхээ хувьд юу хий, бүтцийн өөрчлөлт хий. Зарим нэг зардлуудаа тана, орлого дээрээ илүү их ажиллаж, авлага дээрээ ажил ч гэдэг юм уу.

Тэгэхээр шүүгчдийн хувьд өнөөдөр яг ийм юман дээр ажиллаж байсан туршилага хэр байна вэ? Ахиад тэнд

очоод та бүхэн 24 сар гэж тавьсан байна лээ, хүсэх юм бол ахиад 6 сараар л сунгана, бүх дампуурлын процессыг явуулах нь. Энэ нөгөө өр төлбөр барагдуулах энэ процессыг явуулах нь тэгээд ингэж амжих уу? Дээрээс нь нэмээд энэ хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьд яах вэ? Хүмүүсийн хөрөнгийг маш ихээр татан төвлөрүүлчхээд хувь хувьцаа эзэмшигч бол тэрүүний нэг өчүүхэн жоохон хэсэг байгаа байх тэг бүхэл, тэг тэг хэдэн хувийн хувьцаа эзэмшээд тэрүүний араас явж дийлэхгүй байж магадгүй. Энэ тохиолдолд бас энэ танай энэ хуулиар зохицуулагдах уу? Банк санхүү бол өөр юм байна. Тэгэхээр танай энэ хуулиар зохицуулагдах уу? Энэ тохиолдолд бас яах вэ? Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк үүн дээр ямар оролцоотой байх вэ?

Үүний одоо нэг жишээ болоод энэ койн гаргасан компаниуд бас яах вэ? 21 оны 5 сараас хойш койн гаргаснууд нь бол нөгөө койн гаргасан хөрөнгийн бирж нь хариуцлагыг нь үүрнэ. Тэрүүнээс өмнөх гаргасан, одоо компаниуд нь яах вэ? Бас танай энэ дампуурлын процессоор явна гэх үү, яах вэ?

Дээрээс нь нэмээд энэ ер нь энэ яваандаа энэ өр, авлага барагдуулалттай холбоотой энэ харилцааг нь ер нь сайжруулахгүй бол үнэнийг хэлэхэд энэ дампуурч байгаа маш олон компаниуд бол заримдаа өөрийнхөө муугаас биш, ерөөсөө өр авлагаа авч чадахгүй байгаа учраас л дампуураад байгаа юм байна лээ. Тэгэхээр та бүхэн шүүх дээр очлоо гэхэд одоо компани нь дампуурах гээд хүн шүүх дээр очлоо гэхэд шүүх тэр компанийн өмнөөс өр авлагынх нь араас хөөцөлдөж өгч чадах уу? Зарим нь улс өгөхгүй байгаа шүү дээ, үнэнийг хэлэхэд төлбөрөө хийхгүй байгаа. Үнэлүүлнэ, аудит хийнэ, харна гээд л ингээд л суучихдаг. Тэгэхээр энэ авлагынх нь араас шүүх араас нь хөөцөлдөж өгч чадах уу? Өмнө нь бол ингээд шүүх шийдвэр гаргаад, шүүхийн шийдвэр дээр очоод авч

чаддаггүй. Шүүхийн шийдвэр дээр очоод өмнө нь бараг 200 сая, 2 тэрбумын авлагатай компаниуд зөндөө их байгаа учраас нэг жижиг авлагатай, 2 сая, 20 саяын авлагатай компаниуд бол хэзээ ч мөнгөө олж авч чадахгүй юм байна лээ. Таны өмнө ахиад зуун авлагатай хүн байгаа, та зуун нэг дэх нь. Тэгээд одоо таны авлага бол магадгүй 5 жилийн дараа барагдах байх гээд сууж байдаг.

Тэгэхээр энэ өр авлагыг нь барагдуулах дээр нь тэгвэл шүүх оролцож ер нь чадах уу? Тэгээд одоо Монголбанкны бас Аюуш хуульч сууж байна. Бид нар ерөөсөө гол бас ярьсан юм нь энэ банкны зээлийн хүүг бууруулахад ч гэсэн дээ, энэ өр авлага барагдуулдаг энэ процессыг л ер нь хурдан шуурхай явуулъя гэсэн одоо энэ хуулиудаа бас та бүхэн маань бас оруулж ирээч гэдэг.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Би Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Энэ койнттой холбоотой асуудал дээр нэгдүгээрт бид нар Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг өнгөрсөн хавар Улсын Их Хурал баталсан. Энэ хууль батлагдаад хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр тухайн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид Санхүүгийн зохицуулах хороонд өөрийнхөө санхүүгийн үзүүлж байгаа үйлчилгээнийхээ талаар одоо мэдээллээ хүргээд хүргүүлээд тухайн Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулах тэр эрх нь эрхээ үүсгэх ёстой гэдгийг хуулиар даалгаж өгсөн.

Сүүлийн үед койнттой холбоотой асуудал яригдаж эхэлж байгаа. Цагдаагийн байгууллагаас тухайн бүр тухайн үед энэ цахим мөнгөтэй холбоотой асуудал дээр ЦЕГ, Монголбанк, СЗХ-ноос удаа дараа тухайн төрлийн үйлчилгээ хүсэж байгаа

иргэдэд одоо анхааруулга санамжуудыг өгч байсан. Монголбанкнаас ч өгч байсан. СЗХ-ноос хэд хэдэн койн гаргаж байгаа ААН-үүдийн үйл ажиллагааг зогсоож, Зөрчлийн тухай хуульд заасан арга хэмжээнүүдийг авагдсан. Харамсалтай нь койн гаргах үйл ажиллагаа бол түүгээр хязгаарлагдаж зогсоогүй явагдсан. Тэгэхээр энэ дээр одоо цаашид яах вэ гэдэг асуудал байгаа.

Нэгдүгээрт, СЗХ-ны хяналтад орсон койн гаргасан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид бүгд тухайн СЗХ-тойгоо ажлаа тэр гаргасан койныхоо талаар тайлангаа гаргаад ингээд явах байх. Юуны койн эзэмшигчийн анхны шаардлагаар койных нь мөнгийг гаргаж өгөхгүй байгаа тохиолдолд тухайн асуудлаа СЗХ-нд тухайн байгууллагууд тавих ёстой. Энэ нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй байгаа тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгээд одоо шалгах ийм процессууд бас явагдахаар манай одоо холбогдох хууль тогтоомжуудад дурдагдсан.

Зүгээр юуны хувьд бол бид нар шинээр оруулж ирж байгаа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль дээр цахим залилангийн тухай тусдаа бие даасан гэмт хэрэг оруулж ирэхээр одоо хуулийн төсөлд туссан байгаа. Хоёрдугаарт, санхүүгийн секторын үгсэн хуйвалдах хэд хэдэн харилцаануудыг Эрүүгийн хуульд тусад нь зохицуулж өгсөн. Тухайлбал одоо нөгөө өөр хоорондоо үнэ зохиох, тийм ээ үгсэн хуйвалдах, м... хийх, энэ үйлдлүүдийг Эрүүгийн хуульд тусгайлан хориглож өгсөн.

Дампуурлын хуулиар энэ койнттой холбоотой холбогдох харилцааг зохицуулах уу гэвэл би танд түрүүн хэлсэн эрүүгийн хэрэг үүсгээд шалгаж байгаа тохиолдолд ЭХХШТХ-д заасны дагуу энэ харилцаа цаашаа үргэлжлээд явна. Энэ Дампуурлын тухай хуулийн гол агуулга бол нөгөө төлбөрийн мөнгөн урсгал, төлбөрийнхөө одоо тэр

даалгаврыг 6 сар буюу түүнээс дээш хугацаанд хэрэгжүүлж чадахгүй болсон тохиолдолд сонин, одоо тэр тухайн этгээд шүүхэд хүсэлтээ гаргаад энэ төлбөрийн чадваргүйдлийнхээ харилцаа хэргийг үүсгээд, тэгээд үүрэг гүйцэтгэгчид тухайн одоо тэр төсөл хөтөлбөр, компанийн удирдлагыг.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд асуулт асууя. 87 дээр Монголбанк уу, Монголбанк 87.

Д.Аюуш: Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Аюуш Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Энэ хууль дээр Монгол банк хувьцаат компанийн хэлбэртэй ч юм уу, банк ингээд татан буугдахтай холбоотой харилцаанд энэ хууль дээр Монголбанкны оролцоо ямар байгаа вэ гэсэн асуулт. Тэгэхээр банкныг буюу банк хуулийн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд татан буулгах 2 үндэслэл байгаа юм. Нэг нь 27 Банкны тухай хуулийн 27.1-д зааснаар хуульд зааснаар татан буугдах гэдэг нь. Өөрөөр хэлбэл сайн дураараа тухайн банк татан буугдаж байгаа бол энэ хуулиар Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулиар явна.

Нөгөөдөх нь банк маань Монголбанкны шийдвэрээр буюу албадан татан буулгах ажиллагаа байгаа. Албадан татан буулгах ажиллагаа бол Банкны тухай хуулиараа явна. Мэдээж төлбөрийн чадваргүйдлийг тогтоох процессын ажиллагаанд бол Монголбанк Төлбөрийн чадваргүйдлийн хуулиараа явах байсан ч гэсэн нөгөө үзүүлэлт тоо аргачлалынхаа дагуу тайлан балансыг нь гаргах энэ процессын ажиллагаанд бол Монголбанк дүгнэлтүүдээ гаргаад явахаар ийм оролцоотой байгаа.

Дараагийнх нь зээлийн хүү бууруулахтай холбоотой хууль тогтоомж юу болж байгаа вэ гэж. Тэгэхээр зээлийн хүүг бууруулахтай холбоотойгоор Засгийн газраас гаргасан

Их Хурлаас гаргасан тогтоолуудын хэрэгжилтийн хүрээнд бид нар нэг арваад хуулийн өөрчлөлтийг танилцуулж байсан. Энэтэй холбогдуулаад хуулийн өөрчлөлтүүд, ажлын хэсгүүд маань гараад явж байгаа. Энэ хуулиудын гол хуулиуд бол одоо сайдын хэлсэнчлэн нэн тэргүүний хууль бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, процессын хуулиуд байгаа. Шийдвэр гүйцэтгэлийн хууль байгаа. Энэ дээр ажлын хэсэгт нь Монголбанкнаас оролцоод явж байгаа. Хууль тогтоомжийн тухай хуулиараа энэ бол Засгаас өргөн баригдах ёстой хууль байгаа юм. Тэгээд судалгааны ажил дээр нь хамтран ажиллаад явж байгаа.

Тэгээд яг энэ дампуурлын хуулиар дампуурсан банк байдаггүй гээд асуухаар энэ өнгөрсөн хориод банк одоо дампуурсан байдаг энэ хугацаанд. 89 оноос хойш анхны тусгай зөвшөөрөл Монгол хоршоо банк авснаас хойш. Энэ дээр явахаар ганцхан Монгол бизнес гэдэг банк өөрөө сайн дураараа татан буугдсан, татан буулгах ажиллагаа нь одоо болтол хэрэг гүйцэтгэгч маань хэрэгжүүлээд явдаг байгаа. Бусад нь бол Монголбанкнаас албадан татан буулгахаар буулгагдсан банкнууд байгаа.

Т.Аюурсайхан: Сайнзориг дарга 83 дугаар микрофон дээр ажлын хэсэг нэмж хариулъя.

П.Сайнзориг: Булгантуяа гишүүн болон Баттөмөр гишүүний асуултад нэгтгээд хариулчихъя. Шүүхийн оролцооны асуудал ярьсан. Мааш чухал асуудал энэ шүүхийн оролцоо байгаа. Тэгэхээр бид хэд бас одоо удахгүй Засгийн газраас Шүүх байгуулах тухай хуулийг ШЕЗ-тэй зөвшилцөж оруулж ирнэ. Энэ хүрээндээ бас ярьж байгаа нэг асуудал юу вэ гэхээрээ иргэний одоо шүүх дотроо арилжааны танхим байгуулах асуудал буюу бизнес эрхлэгчдийн одоо хооронд үүсэж байгаа маргаан болон яг энэ бизнесийн маргаан дээр мэргэшсэн шүүгч ажиллуулах, тэндээ шүүгч нартаа

зориулсан, бас яг энэ эдийн засгийн шинжээчид ажиллуулдаг болох, эдийн засгийн мэдлэгтэй туслахууд ажилладаг болох энэ асуудал руу илүү их анхаарч байгаа гэдгээ хэлье.

Хоёрдугаарт Засгийн газраас удахгүй бас он гараад өргөн барих хуулийн нэг нь иргэний процессын хууль. Иргэний процесс дээр бид нар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэмж оруулж ирнэ. Өөрөөр хэлэх юм бол шүүхийн шийдвэрийг иргэний шүүх нэг гаргачхаад, шүүхийн шийдвэр ажиллагаанд захиргааны шүүх рүү ингээд явчихдаг. Энэ дээрээсээ болоод дахиад ингээд маш удаан процессууд үргэлжилдэг учраас энэ доголдуудыг бид хэд арилгаж, үндсэндээ нэг процессоор яваад шүүх яг хэрэг маргааныг үүсгэсэн бол дуусах хүртэл шүүхийн шийдвэрийг биелүүлдэг процессоо хянаад явах энэ процессын дагуу хуулийн төслүүдийг бас удахгүй бас оруулж ирнэ.

Тэгээд ер нь зүгээр өнгөрсөн хугацаанд, өнгөрсөн хугацаанд одоо үндсэндээ нэг 268-хан хэргийг Дампуурлын хуулиар шийдсэн байгаа. Тэгтэл өнөөдөр Монгол Улсад 200000 хуулийн этгээдийн 70 орчим мянга нь идэвхтэй үйл ажиллагаа, 130000 нь одоо үндсэндээ үйл ажиллагаа нь идэвхгүй байдалд орчихсон, татан буугдах арга зам нь байхгүй болчихсон, ингээд гацчихсан байж байгаа. Тэгэхээр энэ хууль гарч байж бас энэ тодорхой хэмжээний эрх зүйн орчин дээр бас цэгцлэх энэ асуудал гарна. Өр барагдуулах энэ асуудал дээр шүүхийн оролцоотойгоор хийнэ. Тэгээд мэдээж энэ хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх, мэргэшүүлэх, эргээд энэ ШШГБ-тай хамтран ажиллах, нуугдмал хөрөнгүүдийг олж илрүүлэх ч гэдэг юм уу, олон үйл ажиллагаа дээр бас хэрэг гүйцэтгэгчдийг чадавхжуулах энэ асуудал байгаа. Тэгээд бид хэд энэ хуулийг бас баталсан тохиолдолд одоо холбогдох Германы техникийн хамтын ажиллагаа, Дэлхийн банкттай бас ярьж

байгаа. Ер нь шүүгч нарыг болон хэрэг гүйцэтгэгчийг мэргэшүүлэх энэ асуудлыг хариуцуулъя. Энэ дээр бас гол үүрэг рольтой оролцох газар нь Худалдаа аж үйлдвэрийн танхим байгаад байгаа юм. Энэ өөрөө.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд асуулт асууна.

Н.Энхболд: Юуны өмнө энэ хуулийг хэлэлцэхийг дэмжиж байна. Энэ одоо үнэхээр хэрэгтэй хууль. Зохицуулж байгаа харилцааных нь талбарыг бол би ингэж харж байгаа юм, ерөөсөө бизнесийн салбарт явж байгаа 2 туйлын хоорондох л зүйлүүдийг зохицуулах нь. Нэг талаас яг үнэхээр одоо үнэнч шударгаар хөдөлмөрлөж байгаад яах ч аргагүй өөрсдөөсөө хамаарахгүй шалтгаанаас болоод дампуурчихсан асуудлыг одоо байгууллага, иргэнийг яавал тэр хүн цаашидаа бүр бүх насаараа яах ч аргагүй амьдрах боломжгүй болгочихгүй байх вэ гэдэг заал нэгдүгээрт анхаарах хэрэгтэй.

Нөгөө туйл нь бол энэ боломжийг ашиглаад одоо хуурамчаар дампууруулаад л луйварддаг энэ ерөөсөө энэ 2 туйлын хоорондох ажиллагааг зохицуулж байгаа хэрэг шүү дээ. Тийм ээ. Мэдээж дунд нь олон юм байгаа. Гэхдээ яг энэ хоёрыгоо их 2 талд нь тавьж байгаад харж үзсэн, аль нэг тийш нь хэлтийлгээгүй ийм л хууль гаргах дах ёстой гэж бодож байна. Тэгээд энийг хэлэлцэхийг нь дэмжиж байгаа.

Тэгээд энэ дампуурлын асуудлыг нэртэй холбоотой нэг санал хэлье. Би бол дампуурал гэдэг үгээрээ явсан нь зөв байх гэж бодож байна. Энэ тогтчихсон хүмүүсийн сэтгэлд үлдчихсэн. Бизнес дампуурна гэхээр энэ бол архи уугаад дампуурч байгаа хүний тухай асуудал биш, төлбөрийн чадваргүй болчихоод одоо цааш нь ажлаа үргэлжлүүлж чадахаа байчихсан ийм нэгжүүдийн тухай, хүний тухай асуудал ярьж байна. Тэгээд

хүмүүсийн сэтгэлд нэгэнт суучихсан учраас яах вэ тэр гадаад дотоодод хуулиа таниулах, яриулах, тэдэнтэй харьцаж орчуулахдаа бол тэгээд л аль нийтлэг хэрэглэдэг үгийг нь бид түрүүн бас л лавлаж байсан. Bankrupt болчихлоо гэж хэлнэ үү, энэ insolvent болчихлоо гэж хэлнэ үү, хуулийнхаа нэр томъёог тэрүүгээр нь орчуулаад л явахад ерөөсөө болохгүй юм байхгүй.

Төлбөрийн чадваргүйдэл энэ тэр гээд тэгэхээр энэ бас юу болов гээд ийм сонин ойлголт үүсэх гээд байна. Би бол тэгж саналаа өгнө гэж бодож байгаа юм. Тэгээд энэ асуудлыг ер нь дан эрүүгийн хэрэг гэж харахаасаа илүү яаж энэ эдийн засгийг хөгжүүлэх вэ, хүнд суртлыг арилгах уу, луйвраас зугтаах уу, яаж энэ хууль хяналтын байгууллага, прокурор, шүүгч, шийдвэр гүйцэтгэгч, өмгөөлөгч нарын эдийн засгийн зах зээлийн харилцааны мэдлэгийг дээшлүүлэх үү, энэ шийдвэрлэх ажиллагаанд нь яаж зөв оролцуулж байна вэ гэдэг талаас нь бас их бодох ёстой хууль. Яг энэ чиглэлийн ямар заалтууд одоо орсон байна вэ?

Үнэнийг хэлэхэд одоо манайд бол бид нар чинь энэ яг энэ капиталист нийгэм рүү ороод нэг гучаад жил болж байна шүү дээ тийм ээ. Маш олон зүйл хуучны инерцээр явж байгаа. Ялангуяа шүүх, хууль хяналтын байгууллага, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нарын дунд социализмын үеийн инерц маш их байгаа асуудалд энэнээсээ ханддагаас болоод ингэж ханддагаас бол аягүй их гомдол ирдэг. Одоо энэ хэрэгт ингээд шалгагдаад явж байгаа улсууд үнэхээр одоо бизнесийнхэн чинь бас түрүүлээд орчихсон байна. Шүүх, хууль хяналтын байгууллага, бусад байгууллагын хүмүүсийн маань энэ талын мэдлэг, энэ нийгэмд амьдардаг зарчмуудын талаарх ойлголтууд үнэхээр дутуу байна гээд. Тэгээд би сая Сайнзориг Төрийн нарийн хэлж байгаатай бол санал нэг байна. Энэ дээр одоо хүмүүсийг мэргэшүүлэх хэрэгтэй. Хуучны сэтгэлгээгээр орчин

үеийн эдийн засгийн хэргүүдийг шийдэж чадахгүй.

Тэгэхээр энэ шүүхээ, шүүхийн шийдвэрээ, прокурор, хяналт, хяналтын байгууллагуудынхаа хүмүүсийг яг ийм заавал мэргэжлийн байх ёстой, төрөлжсөн байх ёстой гэдгийг нь зохицуулсан ийм заалт энэ хууль дотор байна уу? Тийм заалт байна. Сая хэлж байна. Яах вэ, энэ хууль гарчихвал бид нар яваандаа ийм юм хийнэ гээд. Гэхдээ яг энэ Дампуурлын тухай хуульдаа энэ хэргүүдийг бол зөвхөн одоо магадгүй сертификаттай, энэ талын мэргэжил нь баталгаажчихсан ийм хүмүүсээр шүүж байх ёстой гэдэг энэ агуулгыг бас энэ хуульдаа оруулж өгөөд, тэгээд дараагийн тэр бэлтгэх ажил, дүрэм журам юмаа зохицуулахгүй бол ер нь нийтлэг гарч байгаа гомдлууд, шүүмжлэл энэ бол үнэхээр л одоо болохгүй байна гэдэг нь харагдаж байгаа. Энэ танилцуулгад ч биччихсэн байж байна. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, стандарт зарчмууд манайд мөрдөгдөхгүй байгаагаас болоод нийгэмд ийм бухимдалтай асуудлууд үүсээд байна. Хэрэг хийсэн талд нь ч үүсээд байна, хэргийг шийдэх гэж байгаа тал нь ч шүүмжлэлд өртөөд байна. Тэгэхээр яг.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Энхболд гишүүнд 1 минут нэмж өгье.

Н.Энхболд: Тэгээд энэ салбарт энэ зах зээлийн харилцааны мэдлэгийг дээшлүүлэх, шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа хүмүүсийн яг эдийн засгийн мэдлэгт тавих шаардлагыг нэмэгдэх асуудлуудыг ямар хуулиар тус заалтуудаар тусгасан байна вэ? Энэ бол өөрөө их том асуудал. Яг энэнээс болж л одоо өнөө болтол гарч байгаа маргааны бараг 60, 70 хувь нь бид нар хуучин нийгмийнхээ сэтгэлгээгээр шинэ асуудлыг шийдэх гэж оролдоод байгаад л оршиж байгаа юм. Тэгээд миний зөвлөх, эсхүл санал гаргах юмнуудаа хэлэлцүүлгийн дунд юу вэ гэхээр энэ хууль

дотроо та нар энд үйл ажиллагаанд оролцдог, хууль хяналтын байгууллагын хүмүүст яг эдийн засгийн мэдлэг талаас нь, зах зээлийн мэдлэг талаас нь мэргэшсэн, төрөлжсөн талаас нь тавих шаардлагуудыг ерөнхийдөө тусгаж өгөөд, тэгээд тэр дараагийнхаа сая ярьсан, хийх гээд байгаа ажлуудаа хийгээд явбал их сайн болно. Түүнээс зүгээр ингээд л Дампуурлын тухай хууль гаргачхаад л бүх юм нь хууль нь гарчихдаг, хэрэгжүүлдэг механизм нь тэрэн дотор байж байгаа сэтгэлгээ нь хэвээрээ байж.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужины урилгаар Геологийн төв лабораторийн ахмад геологичид, эрдэмтдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. 83 дугаар микрофон дээр Сайнзориг дарга хариулна.

П.Сайнзориг: Энхболд гишүүний асуултад хариулъя. Түүрүүн бас Хууль зүй, дотоод хэргийн сайд бас илтгэлдээ болон хариултууд дээр хэлсэн. Нэр томъёог бас ингээж сонгож хэрэглэсэн гээд. Гол асуудал яах вэ, зүгээр таны хэлж байгааг бас хэлэлцүүлгийн үед бид хэд ярилцах бүрэн боломжтой байгаа. Дампуурал гэдэг үг маань өөрөө эргээд энэ төлбөрийн чадваргүйдлийн үйл ажиллагааны хамгийн эцсийн шат байгаад байгаа юм. Заавал энэ эцсийн шатаараа энэ одоо ажиллагааг нэрлэхээр бас хүмүүст өгч байгаа сэтгэгдэл нь ерөөсөө л хуулийн этгээдийг татан буулгах, байхгүй болох юм байна гэж ойлгоод байдаг. Наад талын тэр үе шатуудыг энэ нэр томъёоноос болоод мэдрэх гэдэг юм уу, оролцох энэ хандлагын асуудал бас гарч ирээд байна уу даа гэдэг ийм зүйл бас байгаа.

Хоёрдугаарт яах вэ, ер нь зүгээр компаниудтай бид нар ингээд уулзалт

энэ тэр хийхээр дампуурал гэхээр бас нэр хүндийн асуудал болчихоод байгаа юм. Яг энэ төлбөрийн чадваргүйдэл ч гэдэг юм уу, ингээд явахаар одоо хамаа алга, бас бизнесийн нэр хүндтэй ч юм уу, ингээд зөв ойлголт төрөх юм биш үү. Гэтэл одоо бүрэн дампуураагүй байж байхад наад уг нь нэр томъёог чинь хэрэглээд ирэхээр манай харилцагч ч гэдэг юм уу, эргээд бид нарын түншүүд бүр буруу сэтгэгдэл төрнө ч гэдэг юм уу ийм бас болгоомжлолууд бид нар бас байгаа учраас энэ нэр томъёог бид нар бас сонгож авч хэрэглэсэн гэдэг зүйлийг бас танд хэлье. Тэгэхдээ Улсын Их Хурлаас энэ хуулийн төслийг төлбөрийн одоо, энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдээд ажлын хэсэг гарвал бас таны яг ярьж байгаа зүйлийг бүрэн ингээд бас хэлэлцээд явах бас бололцоотой. Тэгээд мэдээж энэ ойлголтыг өргөжүүлж ойлгох, зөв хандлагаар ойлгох асуудлыг бид нар хийх ёстой. Энэ дээр бол тантай бүрэн санал нэг байна.

Хоёрдугаарт энэ яг одоогийн бас хуулийн дутагдал юу вэ гэхээр процессын үйл ажиллагааг тодорхой бичиж өгөөгүйгээс болоод энэ ажиллагаа ажиллахгүй байгаа. Нэгдүгээрт, энэ процессыг бид нар ингээд дэлгэрэнгүй нарийвчлаад хийгээд өгөхөөсөө гадна таны ярьж байгаа буюу энэ дээр ажиллах хүмүүсийн ур чадвар, мэргэшүүлэх асуудал туйлын чухал байгаа. Тэгэхээр энийг бид нар ШЕЗ болон одоо ингээд тал талын stakeholder-уудтай ярьж байж шийднэ. Үнэн ер нь зүгээр одоо шулуухан хэлэхэд би бас энийг хаалтан дотор хэлж байгаа гэдгээ хэлье. Бид хэдийн манай ер нь эрх зүйн тогтолцоо нэг тийм шарталтын байдалтай байгаа. Ялангуяа эдийн засаг, санхүүгийн эрх зүй.

Өөрөөр хэлэх юм бол социализмын үеийн тэр хандлага, чиг хандлага, зохицуулалтууд байгаад байдаг. Цаашидаа энэ асуудлаа бүр хадгалж үлдэх юм уу, үнэхээр тэр эрүүл болохын тулд тэр олон улсын чиг хандлага, стандарт,

шинэ норм нормативыг оруулж ирж хуульчлах юм уу гэдэг асуудал одоо бид нарын энэ зааг ялгаа дээр тулчхаад байгаа юм. Тэгэхээр энийгээ бид нар бас үе шаттайгаар ингээд шийдээд бас энэ зарим хуулиуд нь орж ирж байгаа нь энэ хууль. Бид хэд бас өмнө нь өргөн барьчихсан Хуульчийн эрх зүйн байдлын хууль байгаа. Тэгэхээр өнөөдөр ч гэсэн шинэ цагийн мөрдөгч нарыг бас эдийн засгийн агуулга, санхүүгийн мэдлэгтэй болгохгүй бол энэ одоо зохион байгуулалтын эдийн засгийн гэмт хэргүүдийг шийдэх ямар ч бололцоогүй болсон. Тэгэхээр бид хэд бас сүүлийн үед одоо хуульч бэлтгэх гэж байгаа эрх зүйч бэлтгэж байгаа сургуулиудад сонгох хичээл дээрээ хувийн эрх зүй зөндөө байгаад байдаг. Яг бодитой заадаггүй багш байдаггүй.

Тийм учраас одоо Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өргөн барьсан Хуульчийн эрх зүйн байдал дээр яг төгсөх гэж байгаа хүүхдүүдийн хувийн эрх зүйн хичээлийг заавал гучаас доошгүй хувь байж бай гэж байгаа юм. Тэр хувийн эрх зүй дотор нөгөө эдийн засаг, бизнес, гэрээний эрх зүйг үздэг юмыг нь тулхуу байхгүй бол боловсон хүчингүй болчихоод байгаа ийм байгаа. Тэгээд мэдээж энэ бодлогын өөрчлөлтүүдийг бас хийхийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зорьж байна. Хэрэг гүйцэтгэгчдийн асуудлыг ч гэсэн энэ хуулийн төслийн 27 дугаар зүйл дээр туйлын тодорхой зааж өгсөн. Эрх.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж асуулт асууна.

Б.Пүрэвдорж: 97 онд батлагдсан Дампуурлын тухай хууль ерөөсөө ажиллаагүй. Монгол газар гэдэг компани 3 удаа 3 шатны шүүхээр яваад өөрөө дампуурч чадаагүй. Тэгээд ер нь бол энэ дампуурлын асуудал үүсэхэд төлбөрийн чадваргүй болох дээр баруунд яадаг вэ гэхээр траст компаниуд ирээд, энэ бизнес ийм юм байна, тийм байна. Энийг

ингээд авраад үлдье, үйл ажиллагааг нь цаашаа явуулъя, эсвэл тэдэн хувиар одоо энэ бизнесийг аваад дампууруулаад тодорхой төлбөрийг нь төлье гэдэг ийм л зарчмаар л явагддаг юм л даа. Тэгтэл манай Монголд болохоор ерөөсөө Дампуурлын тухай хууль яасан бэ гэхээр сэхээн амьдруулах байхгүй, шууд чандарладаг ийм л системээр явчихсан. Тийм учраас энэ Дампуурлын тухай хуулийг шинэчилж найруулж байгаа нь бас зөв л гэж би харж байгаа.

Тэгэхээр жишээ нь одоо манай нэг 3 үсэгтэй компани санхүүгийн асуудалд ороод, тэгээд Хонг Конгоос нэлээн олон мэргэжилтнүүд, ингээд тэр одоо компанийн бүх салбар дээр группийн бүх салбар дээр ирж суугаад 8 сар ажиллаад, тэгээд энэ бизнесээ зар, энэ зардлаа тана, энэ юугаа одоо шинэчил гэдэг ийм байдлаар яасаар байгаад тэр амжилттай тэр компаниас одоо авсан зээлээ буцааж аваад ингээд л явчихсан байх жишээтэй. Тийм. Тэгэхээр ийм зүйл байгаад байгаа юм. Тэгэхээр одоо өнгөрсөн хугацаанд яасан бэ гэхээр одоо жишээ нь манайх бол үнэхээр одоо энэ Дампуурлын тухай хууль чинь эдийн засгийн хууль шүү дээ. Гэтэл энийг шууд эрүүжүүлэх байдлаар хандсан. Өөрөөр хэлбэл одоо хадгаламж, зээлийн хоршоо жагсаад гараад ирэнгүүт нь улс төрч нар айгаад наадхаа учрыг нь ол гэдэг. Тэгэнгүүт нь эрүүгийн хэрэг үүсгээд нөгөө компанийн хадгаламж зээлийн хоршооны захирлуудыг нь аваачаад шоронд хийдэг.

Баян-Өндөр сан гээд хоршоо байж байхад тэр хоршооны одоо гучин үнээтэй ферм байсан байгаа юм. Тэрийг нь очоод лацадсан. Гуч хоног, гуч хоногийн дараа очсон чинь нөгөө гучин үнээ нь харангадаад үхчихсэн, үнээ нь харангадаад үхчихсэн байх жишээтэй. Сэлбэгийн дэлгүүр лацаад орчихсон. Тэгэнгүүт 3 удаа хулгай ороод тэнд нь цаана нь бас нэг хурандаа байж байгаа шүү дээ. Тэрийгээ хулгайлуулаад бүх одоо сэлбэг нь дуусчихсан. 60000 долларын

үнэтэй машиныг аваачаад юуны шүүхийн шийдвэрийн хашианд явсан чинь 2 жилийн дараа ямар машин нь мэдэгдэхгүй болтлоо зэвэрчихсэн байх жишээтэй. Иймэрхүү байдлаар хүйтэн ханддаг ийм зүйл байгаад байгаа юм. Нэг залуу хадгаламж зээлийн хоршооны нэг эзэн нэг залууг аваад шоронд хийж байгаад, жаран ширхэг лиценз, Улаанбаатар хотын төвийн газруудын тийм газрын эрхүүдийг нь хураагаад авчихсан. Тэгээд тэр нь нөгөө нэг ийм ширээ шиг үнэлэгддэггүй болохлоор яах вэ үнэлэгддэггүй болохоор нөгөөдхийг нь нөгөө нэг цагдаагийн нөхдүүд болон албан тушаалтнууд бүгдээрээ хуйвалдаж байгаад аваад, нөгөөдхөө бүгдийг нь одоо тал талдаа хувааж аваад одоо өнөөдөр тэднийхээ эзэн болчихсон ингээд, нөгөө залуу нь ингээд хохироод үлдчихсэн. Ингээд сууж байгаа. Тэр жаран ширхэг лиценз, газрын эрхээ зарсан бол ямар ч асуудалгүй тэр төлбөрөөсөө гарчих боломжтой байхгүй юу даа.

Тэгээд өнгөрсөн хугацаанд яасан 70 ширхэг хохирогчтой, хадгаламж зээлийн хоршооны хохирогчтой байсан чинь гэнэтхэн 120 болчихсон. Чи 4 саяар хохирсон гээд орчих гээд л ингээд л тэр хэрэг бүртгэлийнхээ явцад ингээд л нэмсээр байгаад ийм байдалтай. Ер нь бол ингэж энэ бол эрүүжүүлэх маягаар энэ Дампуурлын хуулийг хэрэгжүүлээд явах юм бол ерөөсөө асуудал ерөөсөө шийдэгдэхгүй ийм нөхцөл байдалтай байгаа. Одоо ингээд би нэг жишээ асууя. Одоо ингээд 1750 байж байхад Монгол полиметийнхон Хөгжлийн банкнаас зээл аваад, тэгээд долларын зээл аваад тэрнийгээ одоо ингээд ашигтай явж байтал нөгөө одоо энэ Засгийн, Монголбанк эдийн засгийг буруу удирдсанаас болоод доллар 3600 болчихлоо. Тэгээд энэний хохирлыг нь тэгээд өнөөдрийн байдлаар бараг л монгол полиментийн тэр цементийн үйлдвэрийг нь хурааж авах нь холгүй л юм болж байна шүү дээ. Энэ нөхцөлд яах

юм бэ? Даргаа би 1 минутаа нэмээд авчихъя. Нэг мөсөн асуучихъя.

Т.Аюурсайхан: Пүрэвдорж гишүүнд микрофон нэмж өгье.

Б.Пүрэвдорж: Тэгээд төр засгийн буруутай үйл ажиллагаанаас болсон энэ одоо дампуурлын үйл ажиллагааг яаж зохицуулах юм бэ? Үгүй ээ, бас нэг ийм сонссоноо хэлэхэд байна шүү дээ, 1750 дээр тэр 8 шаргын зах дээр Ардын намынхан яваад л доллар дараад байна гэсэн чинь өнөөдөр 3600 болсон тэнд Ардын намынхан яваад л ингээд доллароо зараад байна гэсэн ийм сураг байгаад байгаа шүү. Тэгээд та нар болохоор нэгд болохоор ингээд ААН-ээ ингээд дампууртал нь долларын ханшийг өсгөж будаа болгодог. Нөгөө тал дээрээ ингээд мэдээллийнхээ давуу талыг ашиглаад өөрсдөө ингээд эдийн засгийг дампууруулж байгаад ашиг олдог ийм юмны чинь одоо яаж шийдэх юм бэ? Тэр ААН-ийг Монгол полиментийг яаж асуудлыг шийдэх юм, энэ тал дээр бас тодорхой хариу авъя.

Т.Аюурсайхан: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Баярлалаа, би Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт, Пүрэвдорж гишүүн уг нь их зоригтой хүн, Ардын намын яг хэн гэж гишүүн, ямар батлахтай дугаартай хүн яг тэр Найман шарга дээр явж байгаад шууд хэлэх хэрэгтэй нээрээ би одоо яг танд хэлье. Энэ чинь олон зуун мянган гишүүдийг ингээд хавсруулаад тэр энэ гэж ярьж байхаар аягүй тодорхой хэлмээр байна. Хоёрдугаарт, тэр 3 үсэгтэй компани гээд ямар компани гэдгийг бас хэлчихмээр байна. Би таныг ийм бөөрөнхий гэж бодоогүй, бас баруун Монгол нэлээн тийм зориг зүрхтэй хүн гэж боддог.

Хоёрдугаарт Пүрэвдорж гишүүний яг хэлж байгаа санаа зөв. Бид

нар энэ Дампуурлын тухай хуулиар яг л энэ тухайн бизнес төлбөрөө төлж чадахгүй, бусдад төлбөр төлбөл зохих төлбөрөө 3 сар буюу түүнээс дээш төлж чадахгүй болсон тохиолдолд тухайн энэ төлбөрийн чадваруудын харилцааг үүсгэе. Харилцаа үүсээд уг тухайн төсөл цаашаагаа үр өгөөжөө өгч, дахин бизнес нь хэвийн хэмжээнд очих боломжтой эсэхэд нь дандаа тийм санхүүгийн шинжээчид, экспертүүд дүгнэлт өгдөг, тэр траст компаниуд нь орж ирж дахин хөрөнгөжүүлдэг, дахин үйл ажиллагааг нь хэвийн байдалд нь оруулах ийм баг ажилладаг энэ чиглэл рүү л явмаар байгаа юм.

Хоёрдугаарт, манайд нэг ийм нийтлэг бизнесийн эрх зүйд хоцрогдсон нэг нийтлэг ойлголт байгаа. Энэ ХХК ч бай, ХК ч бай энэ бол бизнес, иргэний эрх зүйн харилцаанд эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж дуусгавар болгодог хууль зүйн факт бий болгох чадвар бүхий иргэний эрх зүйн оролцогч юм. Тэгэхээр манайхан юу гэж үзээд байдаг вэ гэвэл ерөөсөө компанийн захирал өмчлөгчийг ерөөсөө тухайн компанийн эзний хөрөнгө, эзний төсөл, эзний хөтөлбөр гэдэг агуулгаар ойлгодог. Өөрөөр хэлбэл тэр хүн тодорхой төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээд, иргэний эрх зүйн харилцаанд оролцоод, тэр төслөө бусдад танилцуулаад, түүнийхээ төлөө санхүүжилт аваад худалдан борлуулах үйл ажиллагаа хийж явахад доголдол үүсээд 6 сараас дээш хугацаанд асуудал үүссэн тохиолдолд төлбөрийн чадваргүйдлийн харилцаагаа үүсгээд, тэр менежментэд нь өөрчлөлт баг оруулах байдлаар энэ дампуурлаас нь урьдчилан сэргийлдэг энэ хэлбэр рүү явъя гээд өнөөдрийн энэ хуулийг оруулж ирж байгаа. Тэгээд та бол бас энэ тал дээр нэлээн ойлголттой байгаа учраас таныг би бас ажлын хэсэгт орж ажиллаасай гэж бодож байна. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Гишүүд асуулт асууж, харцулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье. Нямаагийн

Энхболд гишүүнээр тасаллаа. Гишүүд танхимдаа цуглараарай, санал хураалт явуулна. Одоо Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин үг хэлнэ.

Г.Амартүвшин: Баярлалаа. Энэ орж ирж байгаа Дампуурлын тухай хууль ингээж нэрлээд байгаа хуулийг бол дэмжиж байгаа юм. Ер нь бол уул нь манайд энэ хууль нь үйлчилж байгаа хэлбэрээрээ бол ямар нэгэн эдийн засгийн үр нөлөө ашигаа өгөхгүй байгаа. Яагаад юм бэ гэхээр одоо үйлчилж байгаа хуулиараа бол компаниуд төлбөрийн чадваргүй болох юм бол шууд дампуураад, тэр компанийг татан буулгадаг л процесс нь байдаг.

Гаднын, ялангуяа Америк, Америкийн дампуурлын хууль бол төгс дампуурлын хууль ингээж яригддаг. Яагаад гэвэл тэр Америкийн хуулиараа болохоор нэг бол компани өөрөө дампуурлаа зарлаад, дахин одоо бүтцийн өөрчлөлт хийж компанийнхаа амилуулах тийм боломж нь байдаг. Тэр нь бол Дампуурлын хуулийн II дүгээр зүйл, 7 дугаар зүйлээрээ бол компанийг татан буулгадаг. Одоо бид нарын сайн мэддэг том, том брэндүүд бол түүхэндээ бол дампуурч байсан тийм компаниуд байдаг. Жишээлбэл General motors, Chrysler, Delta airlines, ингээд л Marvel ингээд нөгөө Spider man кино хийдэг компани хүртэл дампуурч байсан түүхтэй. Одоо бол тэдэн тэрбум долларын үнэлгээтэй.

Тэгээд өөрөөр хэлбэл энэ Дампуурлын хуулиар компаниуд дахин бизнесээ амилуулах тийм боломж нь гарч байгаа нь бол маш хэрэгтэй юм. Яагаад гэвэл мэдээж хэрэг бизнес болгон бол эрсдэлтэй байдаг, буруу шийдвэр байдаг юм уу, эдийн засгийн гаднын нөлөөнөөс болоод компанийн үйл ажиллагаанд доголддог. Өмнө нь одоо бизнес орчин сайн байхад авсан зээлийнхээ үлдэгдлээ одоо дийлэхгүй даахгүй хэмжээнд хүрсэн компани бол хэцүү байгаа үед нь бол тийм боломжийг нь өгөх тийм одоо гарц

нь байгаа нь аягүй зөв байгаа. Тийм болохоор энэ хуулийг бол дэмжээд хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, харин ажлын хэсэг дээр бол нэлээн сайн ажиллах хэрэгтэй байна. Ялангуяа 84 дүгээр зүйл нөгөө нэхэмжлэлийн шаардлага хангах дараалал дээр аягүй сайн ажиллах хэрэгтэй. Яагаад гэвэл энэ бол бас л биш байна лээ л дээ. Жишээлбэл, одоо компани бүтцийн өөрчлөлт хийх үедээ, өөрөөр хэлбэл дампууруулж зарласны дараа авсан санхүүжилт нь бол эрэмбэ дарааллаараа дээгүүр орох ёстой юм. Яагаад гэвэл тэр санхүүжилт олгосон этгээд нь бол маш том эрсдэл хүлээсэн. Өөрөөр хэлбэл дампуурчихсан компанид нэмэлт санхүүжилт өгсөн тохиолдолд энэний эрэмбэ дараалал нь бол дээгүүр орох ёстой юм.

Хоёрдугаарт барьцаатай зээл өгсөн ч юм уу, санхүүжилт өгсөн этгээд нь мөн адил одоо дээгүүр орох шаардлагатай. Тийм болохоор энэ эрэмбэ дараалал дээр нь бол маш сайн ажиллах хэрэгтэй гэж бодож байна. Байнгын хорооны хурал дээр би бас нэг зүйлийг асуусан. Тэр нь юу вэ гэхээр компаниуд зарим одоо муу санаатай компанийн эзэд нь өөрийнх нь компани нь дампуурах гэж байгааг мэдсээр байж компанийнхаа үнэ цэнтэй үл хөдлөх юм уу, бусад активыг өөр компани руу шилжүүлэх, хэт одоо доор үнээр зарах, патент лиценз энэ тэрээ бусдад одоо бэлэглэх байдлаар бултуулдаг активуудаа. Тэр нь ямар одоо үр нөлөөтэй вэ гэхээр дампуурлын процесст нөгөө зээл өгсөн юм уу, санхүүжилт өгсөн этгээдүүд нь юу ч үгүй хоосон компанидаа үлддэг. Тэгэхээр энийг зохицуулдаг зүйл заалт бас орсон гэдэгт би орсон гэдгийг би ойлгосон. Тэгээд энийгээ тэгэхдээ маш сайн ажлын хэсэг дээрээ бас ажиллах хэрэгтэй юм байна лээ. 2 жил гэдэг чинь бусад орны жишигийг бодвол арай л урт удаан хугацаа байлаа шүү. Өөрөөр хэлбэл 2 жилийн өмнө юу болсныг одоо юу гэдэг юм, манай шүүхийнхэн юм уу, хууль

хүчнийхэн бол дураараа л мушгиж тийм тайлбарлах тохиолдол байдаг болохоор энийг бол эргээж харах нь зөв байх гэж харж байгаа.

Ер нь бол энэ санхүүгийн хүндрэлийн асуудлыг бол хууль хүчний шугамаар шийддэг биш, яг л одоо иргэний, одоо энэ хуулийн тохиолдолд бол яг ААН-ийн хүрээнд л одоо шийдэх ёстой асуудал. Тийм болохоор энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Тэгээд Нямбаатар сайд энэ хуулийг оруулж ирсэнд нь баяр хүргэе.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд үг хэлнэ.

Н.Энхболд: Түрүүн би энэ хуулийг хэлэлцүүлгийг нь дэмжинэ гэдгээ хэлсэн. Тэгээд энэ бол зүгээр нэг хэргийн тухай хууль биш юм байгаа юм. Өөрөө цаанаа эдийн засгийн маш том ач холбогдолтой, ялангуяа манайх шиг энэ өөрийн хуримтлал байхгүй, гадна дотнын хөрөнгө оруулалтуудаа татаж, бизнесийнхэнтэй зөв харьцаж сурахад бол үнэхээр том ач холбогдолтой. Энүүнийгээ бид нар ойлгохгүй явж ирснээс болоод эдийн засагт, бизнест маш том түгжээ гацаа, үл ойлголцол үүсгэж байсан энэ харилцааг зохицуулах гэж байгаа хууль гэж бодож байгаа юм.

Жишээ нь хөрөнгө оруулалттай холбоотой асуудал байна. Түрүүн бас манайхан ярьсан. Ер нь ч тэгдэг. Гаднаас Монголтой хамтарч ажиллая, хөрөнгө оруулъя гэж байгаа улсууд бол танай эрх зүйн орчин чинь ямар юм бэ, тийм ээ, зах зээлийн эдийн засгийн тухай ойлголт чинь ямар юм бэ, хуульдаа яаж туссан байдаг юм бэ, бидэнд ямар эрсдэлүүд учирч болох вэ гэдгийг л асууж орж ирж байгаа. Эхний ээлжид. Тэгээд ингээд шууд сая Пүрэвдорж гишүүний хэлсэн шиг нөгөө болоогүй байхад нь арай үхээгүй байхад нь оршуулчхаж байгаа юм шиг ийм байдлаар бизнесийн ажиллагаанд хандаж болохгүй л байдаг юм байна л даа. Энэ зах зээл хөгжсөн

орнуудад. Ийм учраас би түрүүн хэлээд байгаа энэ ялангуяа энэ үйл ажиллагаанд оролцдог хууль хяналтын байгууллагууд, төрийн ажилтнуудын энэ эдийн засгийн мэдлэг боловсрол, төрөлжүүлэлтийг сайжруулалт дээр онцгой анхаарах хэрэгтэй. Яагаад энэ хүн төрөлхтний түүхэнд энд ХХК гэдэг үзэгдэл бий болсон гэдгийг хамгийн эхэнд жишээ нь ойлгох хэрэгтэй байхгүй юу. Мөрдөж байгаа хүн, шүүж байгаа хүн, шийдвэр гаргаж байгаа хүн. Энэ чинь өөрөө маш энгийн мөртөө маш том ойлголт шүү дээ.

Манайханд одоо ингээд л нэг компанийн асуудал яригдаад л, асуудал нь хүндрэхээр шууд эзнийг нь юм уу, хүний нэр яриад л тэр нөхөр тэгсэн гэнэ ээ, энэ нөхөр ингэсэн гэнэ гээд ярьчихдаг. Гэтэл тэр компанийн хөрөнгө оруулсан хүн эхлүүлсэн хүмүүс тэр компани 2 чинь өөрөө 2 тусдаа ойлголт байхгүй юу. 2 өөр юм. 2 өөр юм байлгах гэж анхнаасаа энэ ХХК гэдэг ойлголтыг бий болгоод, энд нь тохирсон бизнесийн санхүүгийн системийг бий болгоод, хариуцлагын системийг бий болгоод одоо ингээд энэ зах зээлийн эдийн засаг гэдэг юм чинь 200-гаад жил болоод явж байгаа юм. Бид нар хэрэв нэгэнт л энэ тогтолцоог сонгож авъя гэсэн юм бол энэ суурь ойлголтоо жигдэлж аваад, үгүй ээ, ядаж хамгийн наад зах нь энэ мөрдөн байцаагч нар, прокурорынхон, шүүхийнхэнд ХХК гэдэг энэ ойлголт яагаад гарч ирсэн юм, ямар утгатай юм, энэнийг хэрэглэсний үр дагавар нь юу байх ёстой юм, хэнд нь ямар хариуцлага ногдох ёстой юм, компани юм уу, хүн нь юм уу гэдэг энэ юмыг хүртэл суурь ойлголтыг нь ойлгуулах тал дээр хэрэгтэй, хэрэгтэй байхгүй юу.

Тэгээд энэ талаас нь харсан ч гэсэн энэ хууль хууль өөрөө их чухал ач холбогдолтой хууль болно. Ийм болохоор би тэр зориуд мэргэжлийн талаас нь анхаарах, төрөлжүүлэх, мэргэшүүлэх энэ асуудлыг ярьж байгаа юм. Магадгүй хуулийг хэлэлцэх явцад энэ суурь заалтаа

энд оруулж үзээд, ийм асуудлуудыг заавал ийм мэргэжлийн, ийм сертификаттай үнэмлэхтэй, эдийн засгийн ойлголттой ийм хүмүүсээр шийдүүлж байна гэдэг заалтаа энэ хуульдаа оруулаад байгаа бол дараагийн юмнууд чинь их зөв болно шүү л гэдгийг дахин, дахин хэлээд байгаа нь энэ. Тэгээд хэлэлцүүлгийн явцад саналаа хэлнэ, дэмжинэ энийг.

Т.Аюурсайхан: Гишүүд асуулт авч, хариулт авч дууссан. Үг хэлж дууссан, одоо санал хураана. Санал хураахын өмнө зочин танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Дашидэмбэрэлийн Бат-Эрдэнийн урилгаар Монгол Улсын Төрийн соёрхолт, уран барималч Намдагийн Дашням Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ингээд танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс амжилт бүтээл, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Одоо санал хураалтыг явуулна, саналын томъёоллыг танилцуулъя. Байнгын хорооны саналаар төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн, 1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 3.Арбитрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 4.Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 5.Банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 6.Векселийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 7.Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 8.Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 9.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 10.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 11.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 12.Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 13.Кино урлагийг дэмжих тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай, 14.Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 15.Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 16.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 17.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 18.Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 19.Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 20.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 21.Санхүүгийн түрээс, лизингийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 22.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт орох оруулах тухай, 23.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 24.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 25.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, 26.Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 27.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 28.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 29.Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 30.ХЗХ-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 31.Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 32.Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 33.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 34.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 35.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 36.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 37.ХАҮТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай, 38.хууль хүчингүй болсонд тооцох тухай, 39.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 40.Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт

орлуулах тухай, 41.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 42.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 43.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, 44.Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна. Гишүүд байраа эзлээрэй. Санал хураалт явуулъя. 59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь гишүүдээ суудалтай, түр байж байгаарай. Хэлэлцэх нь зүйтэй гэж олонх нь үзсэн тул үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

12.09 цаг

Дараагийн асуудалд орно. Горимын саналыг Нямбаатар гишүүн гаргана.

Х.Нямбаатар: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.5-д зааснаар би горимын санал гаргаж байгаа юм дарга. Энэ хэлэлцэх асуудлын нэг дарааллыг өөрчилж өгөөч. Энэ Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг одоо энэ хэлэлцэх асуудлын дараалалд одоо хэлэлцэхээр шийдэж өгөх талаар горимын саналаар санал хурааж өгөөч гэсэн ийм санал гаргаж байна.

Т.Аюурсайхан: Өнөөдрийн нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлын дараалалд байгаа, одоо үргэлжлүүлээд хэлэлцэх горимын саналыг хураалгах боломжтой. Гишүүдийн олонх дэмжих юм бол үргэлжлүүлээд энэ асуудал явна. Тийм учраас Хишгээгийн Нямбаатар гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томьёолоор горимын

санал гаргая. Ажлын хэсэг нь бол бэлэн байгаа. Дэмжье. 2 гишүүний кноп ажилласангүй, горимын санал гаргах юм уу? Цогтбаатар гишүүн горимын санал гаргая. Цогтбаатар гишүүнд микрофон өгье. Юу нь ажиллахгүй байгаа төхөөрөмж нь. Төхөөрөмж нь ажиллахгүй байгаа юм уу.

Д.Цогтбаатар: Миний сая би дэмжсэн санал өгсөн боловч машин ажилласангүй. Тийм учраас энэ саналыг хүчингүй болгоод дахиж санал хураалгахыг хүсэж байна.

Т.Аюурсайхан: Горимын саналыг дэмжье гэсэн томьёолоор санал хураалт явуулъя гишүүдээ. 49 хувийн саналаар дэмжигдсэнгүй. Хэлэлцэх асуудал 3.

**Гурав.Мэргэжлийн болон
техникийн боловсрол, сургалтын
тухай хуулийн шинэчилсэн найруулгын
төсөл болон хамт өргөн мэдүүлсэн
хуулийн төслүүд /Засгийн газар
2022.08.30-ны өдөр өргөн
мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Энх-Амгалан: Монгол Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалт нь иргэдэд хөдөлмөр эрхлэх, бие даасан бизнес хийхэд шаардлагатай ур чадвар эзэмшихэд дэмжлэг үзүүлэх замаар улсын эдийн засаг, нийгмийн олон талт хэрэгцээг хангах үндсэн чиг үүрэгтэй бөгөөд тогтвортой нийгэм, ногоон эдийн засгийн хөгжилд хамгийн гол үүргийг

гүйцэтгэдэг. Бид Монгол Улсын ирээдүй болсон хүүхэд, залуучуудыг ирээдүйн ажил хөдөлмөрт бэлтгэхэд чиглэсэн, илүү шинэлэг стратеги, инновац бүхий мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх шаардлагатай нүүр тулж байна.

Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн зорилт дахь дэд бүтэц, бүтээн байгуулалт, үйл, үйлдвэрлэл, үйлчилгээ нь технологийн дэвшил хурдацтай нэвтэрч, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд тавигдах стандарт, шаардлага шинэчлэгдэн өөрчлөгдөж байна. Иргэд олон жилийн өмнө эзэмшсэн ур чадвараа ашиглан урт хугацаанд нэг ажлын байран дээр ажиллах боломжгүй болж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сургалт, үнэлгээ, судалгааны хүрээлэнгээс хийсэн судалгаагаар ажил хийж буй иргэдийн 77.4 хувь буюу 4 хувь нь 18-44 насны иргэд буюу хөдөлмөрийн хамгийн идэвхтэй иргэд байна. Ажиллах хүчний мэргэжил, ур чадварыг тасралтгүй сайжруулах, мэргэжлийн түвшин бүрээр боловсруулсан ажил мэргэжлийн стандартад суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах, салбарын инновац, судалгаа, шинжилгээний чадавхыг дээшлүүлэх, сургалтын агуулга, технологи цаг тухайд нь шинжлэх бодит, бодитой шаардлага үүсэж байна.

Салбарын үйл ажиллагаа, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийсэн судалгаа, тайлангаас үзэхэд зарим төгсөгчдийн чадамж хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчдын шаардлагад нийцэхгүй, багш бэлтгэх мэргэжлийн хөгжлийн тогтолцоо бүрдээгүй, ажил мэргэжлийн стандарт, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл хангалтгүй, энэ талаар ажил олгогч, мэргэжлийн холбоодын оролцоо дутмаг нөхцөл байдалтай байна. Хөдөлмөрийн зах зээлд шинэ технологи хурдацтай нэвтэрч, ажлын байр, ажилтны ур чадварт гарч байгаа өөрчлөлтүүд,

үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмжийн хувьсгал зэрэг нь ажиллах хүчний мэргэжил, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, салбарын инновац, судалгаа, шинжилгээний чадавхыг дээшлүүлэх бодитой хэрэгцээг бий болгож байна.

Мэргэжлийн боловсролын суралцагчид бүрэн дунд боловсролын хөтөлбөрийг судлах, түүнийг баталгаажуулах дэвшин эсвэл шатлан суралцахтай холбоотой тулгардаг бэрхшээл, тэгш бус боломжийг арилгах хэрэгцээ байгаагаас үүдэн амьдралын орчноос бие даан эзэмшсэн ур чадвар, чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх, хүлээн зөвшөөрөх, ахисан түвшинд дэвшин суралцах, боловсролын бусад түвшин хоорондын залгамж холбоог хангах, хөтөлбөрийн шатлал, хөтөлбөр хоорондын дүйцүүлэлтийг нарийвчлан зохицуулах, иргэнд мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх, тэгш, хүртээмжтэй, үр ашигтай, уян хатан тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна.

Дээрх асуудлууд нөхцөл байдлаас шалтгаалан Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг шинэчлэн боловсруулж 22 оны 7 сард Монгол Улсын Их Хуралд өргөн бариад байна. Салбарын анхны бие даасан хуулийг 2002 онд Монгол Улсын Их Хурлаар батлуулж, 2009 онд шинэчлэн найруулж, 2012, 2015, 2016 онуудад тухайн үеийн хөгжлийн бодлого, стратегитай уялдуулан тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг. Хуулийн төслийг иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан шинжлэх ухаан, технологийн хөгжил, боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх, мэргэшүүлэх, хөдөлмөрийн соёл төлөвшүүлэх зорилгыг удирдлага болгон боловсрууллаа.

Хуулийн төсөлд салбарт тулгамдаж буй дараах асуудлуудыг олон улсын чиг хандлага, сайн туршилагад үндэслэн шийдвэрлэхээр зорилоо. Үүнд, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн зорилт, хөдөлмөрийн зах зээлийн хувьсал, ажлын байрны ур чадвар, иргэдийн насан туршидаа суралцах хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсролын зорилго, зорилт, агуулгыг шинэчлэх, иргэд насан туршидаа суралцаж хөдөлмөр эрхлэх ур чадвар, чадамж эзэмших, хөгжүүлэх, ур чадвараа хөрвүүлэх, тэгш боломжоор хангах, мэргэжил эзэмших, давтан болон шатлан суралцах, сургалт, үйлдвэрлэл, ажил амьдралын орчинд эзэмшсэн мэдлэг, ур чадвараа үнэлүүлж баталгаажуулах боломжийг олгох, мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын засаглалыг боловсронгуй болгож, сургалтын байгууллагын хагас бие даасан байдлыг хангах.

Мэргэжлийн боловсролыг бүрэн дунд боловсролтой хослуулан 3 жилийн хугацаанд эзэмших, бүрэн дунд боловсролын агуулгыг бусад суралцагчтай адил тэгш байдлаар эзэмших, хөдөлмөрийн зах зээлд гаргах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн онцлог, хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний эрэлт, эдийн засгийн салбарын онцлог, улирлын ажлын нөхцөлтэй уялдуулан сургалтыг илүү уян хатан байдлаар эхлүүлэх, ажлын байран дахь сургалтыг зохион байгуулах, мэргэжлийн үндэсний шаталсан бүтцийн дагуу боловсролын түвшин хоорондын уялдааг хангасан дээд боловсролын сургалтын байгууллагад шатлан суралцах боломжийг олгох, багш хүний нөөцийн тасралтгүй хөгжлийг хангаж, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалин хөлсөөр хангагдах боломжийг олгох, өөрийн судалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний үр дүнд бий болсон бүтээл, бүтээгдэхүүний орлогоос хувь, ногдол ашиг хүртэх, эдийн засгийн

хөгжил, үйлдвэржилт, бүсчилсэн хөгжилтэй уялдуулан сургалтын байгууллагыг төрөлжүүлэх, цогцолбор хотхон, кампус хэлбэрээр буюу салбар дундын дадлагын бааз, чадамжийн төв хэлбэрээр хөгжүүлэх, суралцагчдад ажлын байран дээр шаардагдах практик ур чадвар эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулахад өртөгт суурилсан санхүүжилтийн схемийг нэвтрүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын түншлэлийг өргөжүүлэх, суралцагч эцэг эх, асран хамгаалагч, ажил олгогч, мэргэжлийн холбоод, бусад сургалтын байгууллагын эрх, үүргийг нэмэгдүүлж, суралцагч үйлдвэрлэлийн дадлага хийх, ажлын байранд суралцахдаа 3 талт гэрээ байгуулж, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажлын гүйцэтгэхэд тохирсон ажлын хөлс авах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан орчин нөхцөлд суралцах шаардлагатай үйлчилгээгээр хангагдах зэрэг өөрчлөлтүүдийг тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдэх, ажлын байрны шаардлагад нийцсэн ур чадвар, бүтээмжтэй иргэнийг насан туршид нь тасралтгүй хөгжүүлэх тэгш боломж бүрдэх бөгөөд энэ нь Монгол Улсын эдийн засгийн хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, нийлүүлэлтэд эерэг өөрчлөлт авчрах болно. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг, дэмжиж өгөхийг хүсье.

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Төв аймгийн Баянчандмань сумын ЕБС-ийн 8 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Төслийн талаарх БСШУС-

ын Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал танилцуулна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг БСШУС-ын Байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тогтолцоог бүтээн байгуулалтын томоохон зорилттой уялдуулах, чанар, үр дүн, гүйцэтгэлд суурилсан олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажлын байрны шаардлагад нийцсэн мэргэжилтэн бэлтгэхийн тулд сургалтын агуулга, хөтөлбөрт шинэчлэлт хийж, ажил олгогч, мэргэжлийн холбоодын оролцоог нэмэгдүүлснээр нийгмийн түншлэлийг бэхжүүлэх, сургалтын уян хатан хэлбэрийг хүлээн зөвшөөрөх зэрэг хэрэгцээ шаардлагын үүднээс хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Баярсайхан хуулийн заалт хоорондын уялдаа холбооны талаар бүх шатны боловсролын байгууллагын багш, ажилтны мөнгөн тэтгэмж ижил байгаа эсэх салбарын онцлогоос хамаарч хүүхэд хамгааллын талаарх зохицуулалтыг тусгасан эсэх, мэргэжлийн ёс зүйн асуудлыг хэрхэн тусгаж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа хуулийн

төсөлд ажил мэргэжлийн стандарт хэрхэн туссан, Дээд боловсролын тухай хуультай нэр томъёоны тодорхойлолт нийцэж байгаа эсэх, хувийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагыг хэрхэн дэмжиж байгаа болон суралцагчийн тэтгэлгийн талаар асуултыг асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Учрал, төрийн болон хувийн өмчийн ААН-үүдэд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага байгуулах эрх олгох, техник технологи, цахим хөгжлийн чиглэлээр дагнасан сургууль байгуулах талаар сургуулийн захиралд нарийвчилсан хатуу шаардлага тавилгүй нээлттэй, уян хатан байлгах талаар санал хэллээ. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Багийн хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах

тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх БСШУС-ын Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Ингээд БШУЯ-наас Энх-Амгалан сайд, Ганбаяр дэд сайд Оюунаа Пүрэвдоржийн Оюунаа, тус яамны Бодлого, боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Тамир тус яамны Дээд болон Мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын дарга, Хуягцогт мөн яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Түмэндэмбэрэл мөн яамны Мэргэжил боловсрол сургалтын хэлтсийн дарга, Жавзанжаргал мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Адилбиш мөн яамны Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн ахлах шинжээч, Баярмаа мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч, мөн түүнчлэн МҮХАҮТ-аас Түмэнжаргалын Дүүрэн танхимын гүйцэтгэх захирал, Ганбаатар МАОЭНХ-ны дэд ерөнхийлөгч, Баяртуяа Монголын МҮХАҮТ-ын Бодлого, стратегийн газрын дарга гэсэн ажлын хэсгийг танилцуулж байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүдийн нэрийг авъя. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг асуулт асууна.

С.Чинзориг: Би зүгээр асуулт асуухгүй, зүгээр санал хэлчихье. Саналаа л хэлчихье. Тэгэхээр энэ хуулийн төслийг боловсруулахдаа Энх-Амгалан сайдаа Хөдөлмөрийн яамны оролцоо, Эдийн засгийн хөгжлийн яамны оролцоо эд нарйг бас хангаагүй юм уу гэж ингэж бодоод байх юм. Энэ Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тухай хууль чинь бол ганц боловсролын

байгууллагын асуудал биш л дээ. Салбар дундын зохицуулалт шаардсан ийм ажил. Ялангуяа одоо Эдийн засгийн хөгжлийн яамтай болсон. Эдийн засаг, хөгжлийн яамны одоо оролцоо асар их байх ёстой. Хөдөлмөр, нийгмийн яамны оролцоо, үүрэг асар их байх ёстой. Тэгээд энэ хуулийг чинь харахаар бол дан ажлын хэсэг нь Боловсролын сайд дангаараа ажлын хэсэг байгуулаад, боловсролын байгууллагуудын ажилд төлөөлөл ороод л Эдийн засгийн хөгжлийн яам, Хөдөлмөрийн яамны төлөөлөл орохгүйгээр ингээд л хийчихсэн юм шиг л байгаа юм.

Доторх юмыг нь уншихаар энэ салбар дундын зохицуулалттай холбоотой асуудал бүрэн тусаагүй, үндсэндээ шулуухан хэлэхэд хатуудахгүй байх гэж би бодож байна. Боловсролын байгууллагын хууль шиг л юм хийчихсэн байна л даа. Тэгэхээр энэ одоо бидний өмнө тулгамдаж байгаа мэргэжилтэй, ур чадвартай ажилчин одоо бэлтгэнэ гээд байгаа энэ хөдөлмөрийн зах зээлтэйгээ энэ ажлаа уялдуулах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурласан мэргэжилтэй, ур чадвартай ажилтан одоо бэлтгэх энэ одоо ажил чинь тэгээд үр дүн гарах нь одоо их бүрхэг л юм шиг л байгаа юм. Тухайлбал, одоо энэ мэргэжилтэй ажилтан бэлтгэх асуудлыг нь эдийн засгийн хөгжилтэйгөө уялдвал яаж одоо тооцох юм, Эдийн засгийн яам нь яаж одоо оролцох юм, тэр хөдөлмөрийн зах зээлийнхээ эрэлтийг яаж тооцож тодорхойлж байх юм, ажлын байранд одоо зуучлах, төлөлтийн сангаас дэмжлэг үзүүлэх гээд энэ Хөдөлмөрийн яамны оролцоо, үүрэг нь одоо хаанаа байх юм, яаж одоо оролцох юм. Энэ боловсролын байгууллагын бэлдэж байгаа хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан бэлдэж байгаа энэ ажиллах хүчин, мэргэжилтэй ажиллах хүчний ур чадвар нь, чадамжид нь одоо хөндлөнгийн үнэлгээ хэн хийх юм. Би бол Хөдөлмөрийн яам тэр захиалагч нь

учраас хийх ёстой гэсэн байр суурьтай байдаг.

Та бүхний оруулж ирсэн хуулиар бол Боловсролын яам өөрөө сургаад л, өөрөө одоо хөндлөнгийн үнэлгээ хийх л юм шиг л байгаа юм. Ингээд салбар дундын зохицуулалт шаардсан ийм ажлыг ганцхан яам нэг өнцгөөс нь хараад, нэг л салбарын ажилчдыг оруулаад ирчихээр бидний нөгөө яриад байгаа энэ хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурласан мэргэжилтэй, ур чадвартай ажилчин одоо бэлтгэх энэ асуудал маань энэ эдийн засгийн хөгжилтэйгөө уялдах асуудал чинь ерөөсөө байхгүй л болчихоод байгаа юм л даа. Тийм учраас бол цаашидаа энэ хуулийг одоо ингээд дэмжээд хэлэлцэхээр бол тэр ажлын хэсэг хэсгийг нь байгуулаад тэр Эдийн засгийн хөгжлийн яамны оролцоог нь хангаад, Хөдөлмөрийн яамны оролцоог нь ажлын хэсэгт нь оруулаад, тэгээд нэг салбар дундын зохицуулалтыг нь шаардсан зохицуулалтыг нь нэлээн сайн хангаж өгч байж энэ асуудлыг хэлэлцмээр байна Мөнхцэцэг даргаа.

Зөвхөн одоо боловсролын байгууллага шиг ингээд ийм одоо нэг талаас нь харсан ийм одоо хууль хийгээд бол явахгүй шүү дээ. Тэр төр хувийн хувь төр, төр, хувийн хэвилийн түншилэл яаж одоо бэхжүүлэх гээд байгаа юм, эд нар гээд асар их одоо асуудлууд байна. Тийм учраас бол би яах вэ одоо ерөнхийд нь ингээд хууль ороод ирснийг нь одоо хүндэтгээд дэмжээд л одоо явъя даа. Тэгээд тэр ажлын хэсэг дээр нь нэлээн одоо орж ажиллаа. Нэлээн одоо өөрчлөлт хийж байж, нэлээн чамбайруулж байж, тэр талуудын уялдаа холбоог хангаж байж, салбар дундын зохицуулалтыг нь нэлээн сайн хангаж байж энэ хуулийг эцэслэн одоо батлах асуудал ярихгүй бол ийм чиглэлээр бол энэ хууль бол батлах ямар ч одоо боломжгүй л юм байна гэж би бодож байна.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Ёндонпэрэнлэй Баатарбилэг асуулт асууя.

Ё.Баатарбилэг: Энэ Мэргэжлийн боловсролын тухай хууль их чухал хууль орж ирж байна. Би орж ирж байгаа хуулийг хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа. Мэргэжлийн боловсролын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд, ер нь мэргэжлийн болгох, боловсрол олгохтой холбоотой нэлээн хэдэн зохицуулалтууд орж ирж байна гэж харж байгаа. Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллага, байгууллагын суралцагчдад олгох тэтгэлэг, тэтгэмжийн асуудлууд байна. Сургалтын байгууллагын суралцах хугацааны асуудлууд хөндөгдөж байгаа. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үнэлгээ, баталгаажуулалтын асуудлууд яригдана. Дээр нь сургалтын чиг үүрэг, харьяаллын асуудлууд яригдах юм байгаа юм.

Тэгэхээр энэ мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд бол боловсролын байгууллага. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, одоо курс дамжааны асуудал бол биш. Энийг бол би Боловсролын сайдаар ажиллаж байхдаа ч бас хэлж байсан. Энэ бол боловсролын байгууллага. Тийм болохоор энэ боловсролын одоо Монгол Улсын боловсролын тогтолцоо одоо ингээд мэргэжлийн боловсролын байгууллага Боловсролын яаманд харьяалагдсанаараа одоо нэг бүрэн гүйцэд цогц болж байгаа юм. Энэ нөгөө дунд сургууль төгсөөд эсвэл шууд дээд сургуульд ордог. Дунд нь тэр техниккумын техникийн боловсрол олгодог энэ тогтолцоо чинь өөр яам руу шилжчихээд ингээд нэг тийм гажиг үүсчхээд байсныг харин энэ Засгийн газар Энх-Амгалан сайд ингэж оруулж ирж, нэгтгэж цогц болгож байгаа нь бол маш чухал алхам болж байна гэж ингэж үзэж байгаа юм.

Зүгээр энэ дээр 2, 3 зүйл тодруулж бас асууя. Энэ мэргэжлийн

хугацааны хувьд болохоор яах вэ, зүгээр хоёр 2,5-3 жил гэж орж ирж байгаа. Энэ дээр бол ялгамжтай байгаа байх гэж харж байна. Нэг хэсэг нь 9 дүгээр анги төгсөөд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв буюу мэргэжлийн сургалтын байгууллагад суралцах, нэг нь 12 дугаар анги төгсөөд. Мэдээж 9 дүгээр анги төгсөөд орж байгаа хүүхдүүд бол нөгөө 12 дугаар ерөнхий боловсролынхоо суурь сургалтуудыг авахад бол нэг 3 жил хүртэл байна байх. Тэгж байтал 12 дугаар анги төгсөөд орж байгаа хүүхдүүд 1 жил, 1,5 жилд яг мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол олгох бүрэн боломжийг нь нэлээн сайн тусгаж өгөхгүй бол хэт богино хугацаатай нэг дамжаа маягийн болчих вий гэдэг ийм болгоомжлол байна. Энэ дээр ямархуу байр суурьтай байгаа вэ гэж.

Дараагийнх нь энэ насны асуудал байгаа юм. Нас одоо ингээд нэг ямар ч насны хүн ингэж сурч болно гэдэг маягаар явчхаад одоо энэ орон нутаг дахь энэ мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд, хувийн МСҮТ чинь одоо хувьсах зардал авах зорилгоор ямар ч хамаагүй ингээд баахан хүмүүс бүртгэгчхээд, ингээд яваад байна гэдэг ийм юм яригдаад байсан. Энэ дээр яг яамнаас одоо судалгаа хийсэн, хяналт шалгалт хийсэн юм байна уу, үгүй юу? Үнэхээр тийм, одоо хичээлдээ суудаггүй, зүгээр бүртгүүлчхээд сарын 200000 төгрөгийн тэтгэмж авахын тулд ингээд бүртгүүлчхээд яваад байдаг ийм юм байсан уу, үгүй юу? Хэрэв байгаа бол одоо энийг яаж засаж залруулах гэж байна вэ? Тэтгэмж сарын тэтгэмж авахын тулд одоо ингээд янз бүрийн хүмүүсийг ингэж хоморголон ингэж сургасан нэртэйгээр ингэж бизнес, хувийн бизнес болгосон ийм юмнууд бол сонсогдоод байсан. Энэ өөр яамны харьяанд байсан болохоор сайн мэдэхгүй юм. Тэгэхээр энэ дээр одоо ямар судалгаа байна вэ?

Ер нь цаашидаа мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцах

насны хязгаарыг тавивал яадаг юм бэ? Үндсэн хуулийн заалт яриад л, нас хүйс гээд яриад байдаг. Тэгж байтал аль ч улс оронд насны хязгаар тавьдаг шүү дээ. Сургуулиудад. Тэгээд нэг 40 хүртэл гэдэг юм уу ингээд нэг тийм насны хязгаар тавьж явахгүй бол хэтэрхий хавтгайрсан ийм халамжийн байгууллага шиг болчихоод байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр сайд ямар байр суурьтай байгаа юм, хуульдаа энэнийг тусгаж оруулж ирсэн үү, оруулж ирээгүй бол энийг ер нь энэ асуудлыг хөндвөл яадаг юм гэсэн ийм нэг асуулт байна.

Гурав дахь нь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн багш ажилтнуудын нийгмийн баталгаа, цалин хөлсний асуудлууд, мэргэжил боловсролоо дээшлүүлэх тал дээр ямархуу одоо асуудлуудыг хөндөж байна вэ? Энэ ер нь бол нэлээн хаягдчихаад байгаа юм л даа МСҮТ-ийн багш.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Баатарбилэг гишүүний асуултад хариулахаас өмнө түрүүн Чинзориг гишүүн бас буруу ойлголт өгөөд гараад явчихлаа л даа. Тэгээд ийм байдалтай, өөрөө салбарынх нь сайд байсан хүн бас ийм ойлголттой байхад их харамсаж байна. Тэгээд энэ Боловсролын яамнаас өргөн барьсан хууль биш л дээ. Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан хууль учраас бол үндсэндээ Эдийн засгийн хөгжлийн яам, Хөдөлмөрийн яам гээд салбар дундын зохицуулалтууд буюу цаашидаа бол бид нар энэ мэргэжлийн боловсролын тогтолцоо бол энэ түншлэлийн үндэслэл дээр суурилсан ийм тогтолцоо байх учраас бол энэ Аж үйлдвэрийн танхим, Ажил олгогчдын эздийн холбоонуудын оролцоог нэлээн сайн хангаж, яг энэ мэргэжлийн боловсролын үндэсний зөвлөлийнхөө бүрэлдэхүүн дээр ч гэсэн нэлээн ярилцаж байж ингэж хуулийн концепцууд гарч ирсэн юм байгаа юм.

Тэгээд нэг зүгээр шүүмжлэхийн тулд шүүмжилж болохгүй л дээ Чинзориг гишүүнээ. Тэгээд энийгээ бас их зөв ойлгож, бас нийгэмд зөв мэдээлэл өгч залруулах хэрэгтэй болов уу гэж бодож байна нэгд.

Хоёрдугаарт нь Баатарбилэг гишүүний асуултад энэ сургалтын хугацаа дээр нэлээн том зарчмын өөрчлөлтүүд гарч байгаа. 2.5 жил одоо 9 дүгээр ангийн хүүхдүүд ороод 2.5 жил сурч төгсөөд, тэгээд хөдөлмөрийн зах зээл дээр гарах гэхээр нөгөө нас нь хүрдэггүй, 6 сар, 1 жил хүлээдэг нэг ийм нөхцөл байдлууд нэгдүгээрт байсан.

Хоёрдугаар асуудал бол энэ мэргэжлийн боловсролын 2,5 жил бол Монгол Улсыг нөгөө 10 жилийн тогтолцоотой байхад хийсэн тогтолцоо юм байна лээ. Одоо бол Монгол Улс ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоотой болчихсон учраас одоо бид нар ингээд яг мэргэжлийн боловсролоо бол бүтэн болгож одоо 3, 2,5 жилийг одоо 3 жил болгож оруулж ирж байгаа энүүгээрээ нэлээн тийм онцлогтой. Яагаад гэвэл Монголын боловсролын тогтолцоо өөрөө ингээд бүтэн болж байгаа. Түвшин бүрийн одоо уялдаа сайжрах, түвшинээс нөгөө түвшинээс нөгөө түвшин рүүгээ одоо шилжиж суралцах шаталсан суралцах энэ боломжуудыг хангах ийм концепц орж ирсэн юм байгаа юм. Хамгийн гол асуудал бол ерөөсөө энэ мэргэжлийн боловсролын чиг хандлагуудыг харахад бол дэлхий нийтийн чиг хандлагуудыг харахад аль болохоор уян хатан л байх ёстой юм байна лээ. Яг тэр хүүхдийнхээ, оюутнуудынхаа эрэлт хэрэгцээ дээр суурилсан одоо нэг ийм уян хатан тогтолцоо байх ёстой гэж харж байгаа юм.

Бид нар зүгээр нэг зүйлийг одоо нэг бид нарын сэтгэлгээний одоо хоцрогдол гэх үү, энэ хууль хийхдээ дандаа нэг ийм байгууллагын хууль хийдэг, эсхүл нэг сургуульд зориулсан

хууль гэдэг нэг ийм нөхцөл байдлаас бид нар их өөр гарах ёстой юм байна. Одоо энэ Улсын Их Хурал дээр хэлэлцэгдэж байгаа Боловсролын ерөнхий хууль болон өнөөдрийн энэ оруулж ирж байгаа мэргэжлийн боловсролын хууль бол яг оюутан талаасаа, яг одоо мэргэжлийн боловсролд хүүхэд ороход яг яаж сургах юм, хүүхэд өөрөө яаж сурах юм, хөтөлбөр ямар байх юм, тэгээд эргээд нөгөө нэг хөдөлмөрийн зах зээл дээр гарахад тэр шаардлагатай ур чадваруудыг эзэмшиж чадаж байна уу гэсэн энэ тогтолцоо талаас нь яг оюутан талаасаа харахгүй бол бид нар дандаа ингээд нэг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт гэдэг ч юм уу, нэг ийм өнцгөөс харж хууль бичигдэх их буруу юм байна.

Тийм учраас бол энэ оюутнуудынхаа оюутнуудыг төв болгож, оюутнуудынхаа одоо эрэлт хэрэгцээг хангасан ийм хуулийн одоо концепцоор бичигдэж оруулж ирж өнөөдөр хэлэлцүүлэг хийж байгаа юм гэдгийг онцолж хэлье гэж бодож байна.

Тантай бол санал нэг байна. Энэ нөгөө нэг богино хугацааны сургалт дээр байгаа 1, 1.5 жил дээр байгаа насанд хүрсэн хүмүүсийн энэ сургалт бол үндсэндээ одоо жаахан халамжийн тогтолцоо болчихсон. Энэ 200000 төгрөг авахын тулд одоо баахан хүмүүсийн бүртгэл сургуульд байхгүй хүмүүсийн одоо бүртгэлд ашигладаг, эсхүл ЕБС дээр суралцаж байгаа хүүхдүүдийн бүртгэл ашиглаж хийдүүлдэг нэг ийм нөхцөл байдал их олон жил ужиг болсон юм байна лээ. Тийм учраас ингээд энэ боловсролын салбарт ирснээрээ одоо ямар ч байсан энэ боловсролын мэдээллийн тогтолцоонд одоо орж орсноороо бол энэ асуудлуудыг засаад залруулаад явчих ийм боломжууд нь байгаа болов уу гэж харж байна. Ер нь цаашдаа бид нар ер нь насны хязгаар гэдэг нэгдүгээр асуудал байгаа юм. Хоёрдугаарт, энэ насан туршийн боловсролын тогтолцоо. Хүн өөрөө нөгөө

3 жил тутамд одоо өөрийнх нь мэдлэг, ур чадварынх нь 30 хувь байхгүй болж байгаа энэ цаг үед амьдарч байгаа учраас ерөнхийдөө бид нарын одоо энэ ерөнхий боловсролын.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар, Төмөрбаатарын Аюурсайхан, Мөнхөөгийн Оюунчимэг нарын урилгаар нийслэлийн тавдугаар сургуулийн 8 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та нартаа сурлагын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүн Баатарбилэг асуултаа тодруулна.

Ё.Баатарбилэг: Энэ сая Энх-Амгалан сайд нэмээд хариулах байх. Энэ нөгөө насны юун дээр нэг дөч хүртэл гэдэг нэг ийм юм байгаад байгаа шүү дээ. Тэгээд энийгээ бол нэг эргээж харах байх гэж бодож байна. Энэ курс дамжаанууд байгаа шүү дээ энэ ажил мэргэжлийн нэг чиг баримжаа олгодог курс дамжаанууд энэ мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдээ түшиглэж байдаг. Энэ юмнуудаа яг Боловсролын яам хариуцах гэж байна уу, хуучнаараа Хөдөлмөрийн яам энэ ажил мэргэжлийн дадлага олгодог энэ курс дамжаануудынхаа асуудлыг яах гэж байна уу? Энэ бол уг нь бол Хөдөлмөрийн яамандаа явж байхад бол болохгүй юм байхгүй юм байгаа юм. Энэ дээрээ бол яг мэргэжлийн боловсрол гэдэг юмаа Боловсролын яаман дээр. Энэ зүгээр хуульд яаж орж ирсэн бэ гэдэг ийм нэг 2 зүйл дээр тодруулга өгөөч. Тэр дөч хүртэлх гэдгээр ингээд явж болж байна уу, үгүй юу? Хуульд юу гэж заасан бэ? Та нэг тодруулаад хэлээч.

Т.Аюурсайхан: Энх-Амгалан сайд гүйцээж хариулъя.

Л.Энх-Амгалан: Насны хязгаарын талаар бол яг тэдэн наснаас гээд ингээд хязгаарлаж байгаа асуудал дээр бид нар энэ хуулийн хэлэлцүүлгийн үе дээр нэлээн

нээлттэй ярилцах нь зүйтэй болов уу гэж би бодож байна. Ер нь тэгээд цаашидаа гол асуудал бол бид нар нэг зүйл дээр энэ насан туршийн боловсролын тогтолцоо гэдэг энэ концепц зарчмаа л ер нь авч явах ёстой юм байна. Хүн өөрийнхөө эрэлт хэрэгцээ, сонирхол одоо юун дээр тулгуурласан энэ сургалтуудыг хийдэг, тэр нь одоо баталгааждаг, заавал ч үгүй анги танхим буюу ингээд нэг мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв дээр ирж, эсвэл коллеж дээр ирж, одоо ингээд заавал ч үгүй ур чадвараа дээшлүүлэх энэ концепц бол их хуучирсан концепц байгаа юм. Тэгэхээр энийг одоо уян хатан тогтолцоонд шилжүүлэх нэг ийм эрх зүйн шинэчлэл хийж байгаа учраас энэ дээр бол одоо яг насны хязгаар дээр яг ямар байх вэ гэдэг дээр Оюунаа дарга нэлээн энэ дээр нэмэлт нэг хариулт өгчхөөрэй.

Хоёрдугаар асуудал бол таны тодруулж байгаа нөгөө богино хугацааны сургалтууд, мэргэжил чадамж олгож байгаа богино хугацааны сургалтууд бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээрээ явагдана. Энэ дээр бол одоо Боловсролын яам бол.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайхан асуулт асууна.

Б.Баярсайхан: Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн одоо сургалт Боловсролын яаман дээр ирсэнд бол их талархалтай байгаа. Дээрээс нь одоо энэ Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн төсөл орж ирж байгаад бас дэмжиж байгаа. Ер нь бол энэ мэргэжилтэй боловсон хүчнийг дэмжих их, дээд сургууль төгсөөд дипломгүй, ажилгүй байж байгаа энэ одоо цаг үеийг халж, илүү энэ нийгмийн хамгийн одоо чухал салбаруудад ажиллаж, яг тэр баялаг бүтээдэг ийм одоо боловсон хүчнийг бэлтгэдэг маш одоо том ийм улс орны

хүч болсон ийм одоо мэргэжилтнүүдийг бэлтгэдэг ийм одоо салбар юм.

Тэгэхээр би Энх-Амгалан сайдаас энэ өмнөх жилүүдэд хэрэгжиж байсан Хөдөлмөр, нийгмийн яам дээр Боловсролын яаман дээр хэрэгжиж байсан ажил мэргэжлийн чиг ба баримжаа олгох энэ АХБ-ны нэг төсөл хэрэгжиж байсан гэдгийг өмнө нь бас дурдаж байсан. Тэгээд би юу гэж хэлэх гээд байна гэхээр одоо яг хүүхдүүд маань 9 дүгээр анги гээд л мэргэжлээ ерөөсөө сонгож чадахгүй байна, маш их тулгаж, мэргэжил сонгож байна. 7 дугаар ангиас нь авхуулаад ажил мэргэжлийн чиг баримжаа яаж олгох юм, ямар мэргэжил сонгох юм гэдэг дээрээ бэлдэх энэ одоо хугацаа ерөөсөө байхгүй байгаад байгаа юм. Нэгэнт МСҮТ-өө одоо Боловсролын яам дээрээ авсных, энэ хүүхдүүдэд эрт ажил мэргэжлийн чиг баримжааг нь олгох, ямар чиглэлээр ямар мэргэжилтэй хүн болгох энэ дээр нь бэлдэхгүй бол энэ асуудал бас цэгцрэхгүй гэж харах гээд байна. Хоёрдугаарт энэ дээр бас та нэг саналаа хэлээч. Санаа оноогоо хэлээч.

Хоёрдугаарт нь энэ Норвегийн жишигээр мэргэжил болгон мэргэжил л эзэмшсэн л бол тэр бол одоо үнэ цэнтэй мэргэжилтэн юм гэдэг энэ бодлогыг бас Монгол Улсад хэрэгжүүлэхэд та бас туршилага судлаач гэж хэлэхийг хүсэж байна. Норвег Улсад яадаг вэ гэхээр ямар нэгэн одоо мэргэжлийн ялгаварлан гадуурхал гэж байдаггүй. Тухайн хүн 3 сард нь 3 сарын юм уу, 3 жилийн юм уу, 2 жилийн ямар нэгэн байдлаар тэр тухайн мэргэжлээ эзэмшихэд мэргэшсэн байх юм бол тэр мэргэжлийнх нь үнэлэмж өндөр байдаг. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй одоо нэг хүнийг хүртэл харах тийм мэргэжилтнээ бэлддэг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэн байлаа гэхэд тэр нь өөрөө одоо ажил олгогч болоод явчихдаг ийм одоо сайхан тогтолцоо байгаа. Тэгэхээр бид нар МСҮТ-өө боловсролынхоо яаман дээр аваад, одоо энд Боловсролын яаманд ирснээрээ энэ МСҮТ-д байгаа

хүүхдүүдийн хамгааллын асуудал, ёс зүйтэй мэргэжилтэн бэлтгэх асуудал, МСҮТ-өө төгсөөд төгсөгчид нь бүгд одоо ажлын байраар хангагддаг, эх орныхоо энэ одоо хэрэгцээт салбар болгон дээр ингээд ажиллах, энэ боловсон хүчин бэлтгэх гээд олон сайхан одоо энэ үр дүн гарна гэдэгт бол итгэлтэй байгаа.

Тэгээд хамгийн гол нь энэ ажил мэргэжлийн чиг баримжаа олгох асуудал өөрөө Боловсролын яаман дээрээ, өөрөөр хэлбэл дунд, ахлах ангийнхаа хүүхдүүд дээр хийгдэж чадахгүй байгаа нэг ийм асуудал байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр та бас нэг санаа оноогоо хэлээч. Энэ дээр ямар ажил хийгдэж байна вэ? Уул нь нэгэнт хэрэгжээд явчихсан энэ төслөө үр дүнтэй үргэлжлүүлээд, үр шимийг нь хүртээд явчихвал их зүгээр байгаа юм гэсэн ийм нэг санал байна. Тэгээд та энэ дээр байр сууриа илэрхийлнэ үү гэж хүсэж байна.

Т.Аюурсайхан: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Баярсайхан гишүүн их чухал асуудал хөндөж ярьж байна. Одоо манай ингээд энэ хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг ингээд харахаар нөгөө энэ боловсрол мэргэжлийн боловсролын тогтолцоо одоо ингээд харахаар ингээд нэг ийм гажуудал маш их том гажуудал үүсчихсэн нь ингээд харагдаж байгаа юм. Юу вэ гэхээр өнөөдөр Монгол Улсад ажиллах хүчний хомсдол бий болчихсон. Тэгсэн нөгөө талдаа болохоор одоо ажилгүй 110000 хүн байгаад байдаг. Гэтэл одоо яг энэ хөдөлмөрийн зах зээлийн тоо минь 21 онд гаргасан хөдөлмөрийн зах зээлийн тоймыг харахаар нөгөө талдаа 36000 хүний ажлын байр байгаад байдаг. 36000 хүний ажлын байр байгаад байдаг. Гэтэл тэнд л 110000 хүн ажилгүй байгаад байдаг. Тэгэхээр яг ингээд энэ хөдөлмөрийн зах зээлийн одоо нөгөө зах зээл дээр байгаа ажил олгогч нарын одоо чухалчилдаг ур

чадвар гэдэг нэг ийм, одоо эрэлт хэрэгцээ үүсэж байна. Нөгөө ур чадварын гаре үүсэж байгаа нэг ийм том хандлагууд их гарч ирж байгаа юм. Одоо их дээд сургуулиуд төгсөөд очиж байгаа хүүхдүүд ч адилхан, мэргэжлийн болон техникийн боловсролын төгсөөд очиж байгаа хүүхдүүд ч гэсэн адилхан яг нөгөө ажилчдын ажил олгож байгаа улсуудынхаа хүсэж хүлээж байгаа яг тэр нөгөө ур чадварыг эзэмшиж очиж чаддаггүй учраас өнөөдөр яг энэ ажилгүйдэл гэдэг асуудал хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн асуудал бол энэ ур чадварын зөрүү, ур чадварын гажуудал үүссэнээс болсон одоо ийм асуудал юм байна.

Тийм учраас энийг бид нар ерөнхийдөө яг энэ мэргэжлийн боловсрол болон техникийн боловсрол, цаашилаад төрөлжсөн ахлах сургуулиудынхаа энэ хөтөлбөрийн сургалтын хөтөлбөр дээр энэ асуудлуудыг зайлшгүйгээр хийж өгөх ёстой гэж. Өнөөдөр одоо ажил олгогчдын чухалчилдаг ур чадварын шаардлага гэхээр найдвартай, хариуцлагатай байдал, эерэг зөв хандлагатай байдал, цаг ашиглах чадвар, ачаалал даах чадвар, багаар ажиллах чадвар, ажлын ёс зүй гээд нөгөө ажил олгогчдын хүсэж хүлээж байгаа ур чадварууд их өөр болчихсон юм байна. Гэтэл тэр ур чадваруудыг бий болгодог нөгөө хөтөлбөрийн шинэчлэлүүд нь нөгөө боловсролынхоо түвшин бүр дээр хийгдэж чадаагүй учраас ингээд нэг ийм хөдөлмөрийн зах зээлийн болон ур чадваруудын одоо эрэлт нийлүүлэлт дээр ийм гажуудал үүссэн ийм тохиолдол байна. Энийг бид нар энэ хуулиараа бол засаж залруулахыг яг одоо оролдоно.

Яг таны одоо хөндөж тавьсан энэ яг багаас нь ажил мэргэжлийн чиг баримжаа энэ мэргэжлээ зөв сонгох дээр бид нар дэмждэг энэ тогтолцоо одоо яг манай энэ ерөнхий боловсролын тогтолцоо дээр бий болж чадаагүй. Энэ бол хамгийн сул ийм тогтолцоо байгаа юм. Яагаад би сул тогтолцоо гэж

хэлэхийг хүсэж байна вэ гэхээр хүүхэд өөрийнхөө ахлах анги руу ороод орж байгаа дуртай хичээлээ сонгож үзэх тэр бололцоог хүртэл өнөөдөр хязгаарлагдмал байгаа байхгүй юу. Тэгээд бүлэг бүрддэггүйгээс авхуулаад. Тэгэхээр зайлиггүйгээр одоо бид нар ингээд дунд болон одоо таны сая хөндөж тавьсан дунд бол ахлах анги дээр бид нар ингээд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох энэ хэлбэрүүдийг бол бид нар энэ хөтөлбөрийн шинэчлэлээрээ хийгээд, тэгээд түвшин хоорондын уялдааг хангах энэ боломжууд нь байгаа болов уу гэж бодож байгаа юм. Бид нарын яг хүсэж байгаа нөгөө мэдлэг чадвар төлөвшил буюу одоо цогц чадамжийг эзэмшсэн энэ чадамжуудыг дунд ангидаа ч, ахлах ангидаа ч үргэлжлүүлээд техникийн болон мэргэжлийн боловсрол дээр одоо.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Баярсайхан гишүүнд микрофон нэмж өгье.

Б.Баярсайхан: Баярлалаа, Энх-Амгалан сайдаа. Тэгээд өнөөдөр яг амьдрал дээр бол хамгийн сайн сантехникийн слесарь байна уу гэж одоо хамгийн их эрэлттэй, бие биеэсээ асуудаг. Хамгийн сайн үсчин хаана байна вэ, хамгийн сайн авто автын механикч хүн таних уу ч гэдэг юм уу тийм ээ, хамгийн их амьдралд хэрэгцээтэй ийм мэргэжилтнүүдийг бэлддэг ийм чухал ажил мэргэжил бэлтгэдэг ийм сайхан салбар байгаа. Тэгэхээр энэ таны саяын хэлж байгаа ёс зүйтэй, төлөвшилтэй, чадвартай хүмүүс бэлтгэх боловсон хүчин бэлтгэх гэдэг дээр одоо боловсролын салбарт танай салбар дээр одоо дөнгөж сая хийгдээд дуусчихсан, зан чанарын боловсрол олгох шаардлагатай юу гэдэг энэ судалгаа бас байж байгаа. Тэгээд энийг та бас нэг анхаараад, боловсролынхоо салбарт нэвтрүүлэх тал дээр. Мөн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, аль хэдийн тэр гарын авлага, тест юмнууд нь гарчихсан байгаа. Энийг нэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас аваад

ингээд энэ 2 ажлыг нийлүүлээд явах юм бол бидний ажилд бас нэлээн.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Үг хэллээ. Зочин танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийн урилгаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг биеийн тамир, спортын төрөлжсөн сургуулиудын захирлууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс нэгдүгээрт ажлын өндөр амжилт хүсье, мөн түүнчлэн энэ сайн тамирчид бэлтгэхийн зэрэгцээ хүмүүнлэг, эрүүл чийрэг, бүтээлч Монгол хүүхдийг төлөвшүүлэх нь чухал болохыг онцолж, энэ ажилд өндөр амжилт хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа асуулт асууна.

Х.Булгантуяа: Энэ их чухал хууль байгаа юм. Бид нар энийг төрийн бодлогоор мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийг дэмжих ёстой. Тэгж байж гадаадаас ажиллах хүчин авдаг, одоо ажилгүйдлийг бууруулах энэ бол том алхам бас болох ёстой юм. Тэгж байж гадаадаас бид нар ажиллах хүчээ авахаа багасгах ёстой, дотоодын ажилгүйдлийг бууруулах ёстой, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх ёстой гээд. Тэгээд бид нар 2017 оноос авхуулаад жил болгон МСҮТ-дэд суралцаж байгаа оюутнуудад 200000 төгрөгийн тэтгэлэг олгодог болсон. Гэтэл ингээд харахад хэрэгжилтийн явцад бас үнэнийг хэлэхэд их учир дутагдалтай зүйлүүд их байна. Жилд бараг бид нар жар гаруй тэрбум төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог байсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд гадаадаас ажиллах хүчин авч байгаа ААН болгон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 нугалж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд орлого оруулаад, тэрнээс нь бид нар

цаашаагаа энэ МСҮТ-д сурч байгаа оюутнуудад одоо зарцуулдаг байсан.

Гэтэл энэ ажил олгогч нар, холбоод, ноос ноолуурын холбоо, хүнсний холбоо, махны холбоо, сүүний холбоо байдаг юм уу, энэ дээрээс нь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв 2-ыг хооронд нь ерөөсөө уяж өгөөгүй юм байна лээ. Тэгээд зах зээл дээр зарим холбоод нь ерөөсөө ажилтан олддоггүй, одоо олигтой мах шулчих ч хүн олдохгүй байна гээд л, ноос ноолуурынх нь техник тоног төхөөрөмж дээр ажилладаг хүн ерөөсөө олдохгүй байна гээд ингээд байхад, нөгөө талдаа зах зээл дээр нэг их эрэлт хэрэгцээтэй биш баахан хүмүүсийг бэлтгээд байдаг. Зарим нь бүр МСҮТ дээр мэргэжсэн хүмүүс байдаг юм байна. Одоо гоо сайхан, үсчин гоо сайхнаар явж байгаад дуусаад араас нь тогоочид сураад, тэрүүний араас нь хүнд машин механизмын оператораар сураад гээд ингээд явчихдаг, бүр тэр нь ажил болчихсон юм шиг. Заримынх нь бүр нэг айлынх нь нэлээн хэдэн хүмүүс нь сурдаг, эхнэр нь, нөхөр нь, ээж нь, аав нь гээд ингээд сурдаг. Өрхийн орлогыг бүрдүүлдэг халамжийн тогтолцоо шиг бас ийм болчихсон юм байна лээ.

Тэгэхээр аль ч яаман дээр очсон одоо Энх-Амгалан сайдаас хүсэх хамгийн чухал зүйл бол үүнийг одоо энд манай Худалдаа аж үйлдвэрийн танхимаас ирсэн байна. Ажил олгогчидтой нь холбож өгөөч. Монгол Улс ноос ноолуурын дэлхийн 2 дахь том экспортлогч. Ноос ноолуурын холбоондоо хүмүүс бэлтгэж өгье, ноос, ноолуурын холбооныхон тэгээд тэгж байна лээ. Бид нар өөрсдөө дээрээс нь бүр шаардлагатай бол өөрсдийн тэтгэлэгт төлбөр гаргая, ахиад 200000-ыг бид нар нэмээд өгөхөд ч бэлэн байна. Тэнд сургагдаад бэлтгэгдээд ирвэл бид нарт ч гэсэн амар байна. Бид нар шууд дараа нь ажилд авна. Тэгэхдээ манай хөтөлбөр нь одоо манай шаардлагыг бас хангасан байх ёстой гээд. Хүнсний салбарынхан бас яг адилхан, барилгын салбарынхан

бас яг адилхан гээд. Тэгээд бид нар энэ ажил олгогч энэ 2-ыг одоо холбодог энэ тогтолцоог энэ хууль дээрээ хэрхэн яаж хийж өгч байгаа вэ? Нэгдүгээрт асуултын хувьд.

Хоёрдугаарт ингээд сурчхаад хэрэв нөгөө сурсан мэргэжлээрээ ажиллахгүй бол бас яах вэ? Одоо та бүхэн нөгөө сургалтын зээлийн сан сан шиг буцаж төвлөрүүлдэг ч байдаг юм уу ийм зүйл байх уу? Тийм зүйл байх уу? Хоёрдугаарт.

Гуравдугаарт энэ ажил олгогч нартайгаа одоо нар хажуу талдаа бас МСҮТ бид нар байгуулмаар байна гэсэн ийм хүсэлтийг бас тавьдаг юм байна лээ. Ийм хууль, эрх зүйн боломж бололцоо бас байгаа юу? Улсын МСҮТ яг хэд байгаа вэ? Хувийн МСҮТ яг хэд байгаа вэ? Хөдөө орон нутагт яг хэд байгаа вэ? Хотод яг хэд байгаа вэ? Төгссөнийх нь хэд нь ажлын байран дээр очиж байна, одоо яг голцуу ямар, ямар мэргэжлүүдээр бэлтгэгдэж байна вэ гэдэг талаар мэдээллээ та бүхэн маань өгөөч. Тэгээд одоо аль яаман дээр одоо Боловсролын яаман дээр очих нь бол зөв зүйтэй байх. Тэгээд хамгийн гол нь эндээс бид нарын зориод байгаа зүйл нь одоо өнгөрсөн 4, 5 жилийн хугацаанд бид нар 5 жилд бараг гурван зуун тэрбум төгрөг зарцуулсан байна. Тэгэхээр гурван зуун тэрбум төгрөг зарцуулаад бид нар хэчнээн хүнийг ажлын байраар өнгөрсөн 5 жилийн, 6 жилийн хугацаанд бэлдсэн бэ гэдэг ийм асуултуудыг гаргаж яг ажилд оруулж чадсан байна вэ гэдэг ийм асуултуудыг асуух гэсэн юм.

Т.Аюурсайхан: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Тэр ажлын байрны дараах төгсөлтийн хувь хэмжээ нийт хэчнээн одоо ажилтан бэлдсэн байна вэ гэдэг дээр Оюунаа дарга, Тамир дарга нэмээд мэдээллүүдийг өгчхөөрэй. Юуны 200000 төгрөгийн тэтгэлэг бий болсноор ерөнхийдөө яах вэ мэдээж энэ

мэргэжлийн болон техникийн боловсролд суралцагчдын бас хүсэл сонирхлыг одоо жаахан дэмжсэн ийм ажиллагаа болсон, ийм төрийн бодлого болсон. Гэхдээ нөгөө сайны хажуугаар саар гэдэг шиг яг энийг далимдуулж одоо энэ тэтгэлгийг ийм халамжийн хавтгайруулсан халамжийн нэг хэлбэр болгосон нэг ийм гашиун сургамж байна. Энийг бол бид нар үнэнээрээ хүлээн зөвшөөрөх ёстой. Тэгэхээр гол асуудал бол бид нар ерөөсөө энэ мэдээллийнхээ энэ дата баазуудыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам, Эдийн засгийн хөгжлийн яам гэдэг юм уу, энэ төрийн нөгөө ой санамж энэ мэдээллийнхээ баазуудыг их зөв бүрдүүлж байж энэ дээр нэг их тийм зөв төлөвлөлтүүд, зөв хэрэгжилтүүд, зөв хяналтууд тавихгүй бол нэг ийм сул тогтолцоо байсны одоо гажуудал энүүгээр одоо үүссэн гэдэгтэй би тантай санал нэг байна гэж ойлгож байна.

Хоёрдугаар асуудал бол бид нар ерөөсөө энэ хуулийн одоо амин сүнс нь ерөөсөө энэ түншлэлийн зарчим дээр л үндэслэх ёстой юм байна. Түншлэлийн зарчим гэдэг бол ерөөсөө ажил олгогч нар. Тийм учраас бол одоо цаашидаа Монгол Улсын энэ мэргэжлийн болон техникийн боловсролын тогтолцоо бол яг л ажил олгогчдын түншлэл дээр л явах ёстой. Бусад улс орнууд ч гэсэн ийм тогтолцоо байгаад байгаа юм. Тэгэхээр ерөөсөө яг энэ хууль дээр орж ирж байгаа энэ юу бол өмнө нь ерөөсөө энэ манай энэ мэргэжлийн болон техникийн боловсролын тогтолцоог төр өөр дээрээ авч явж байсан. Тэгээд нөгөө хөдөлмөрийнхөө зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээ тэр ур чадварын эрэлт, нийлүүлэлтээ, ажил олгогчдын эрэлт нийлүүлэлтээ бодлогоо нэгтгэж байсан энэ тогтолцоо ерөөсөө байхгүй байсан. Одоо Мэргэжлийн боловсролын үндэсний зөвлөл гэхэд дандаа яамнуудын төрийн төлөөллүүд орчихдог нэг ийм л сул тогтолцоо байсан. Одоо бол бид нарын шинэчилсэн энэ хуулиар сая шинэчилж байгуулсан энэ Мэргэжлийн үндэсний

зөвлөл дээр бол илүү Аж үйлдвэрийн танхим буюу Аж үйлдвэрийн танхимын доор байгаа мэргэжлийн холбоод оруулдаг, оролцоонуудыг хангаж өгдөг энэ тогтолцоо руу бид нар шилжих ёстой юм байна гэж.

Ажиллангаа сурах, сурангаа ажиллах хосмог тогтолцоо гэж ярьдаг Германы хосмог тогтолцоо гэж ярьдаг. Яг хүүхэд өөрөө ирээдүйн одоо ажил дээр, тэр ажлынхаа байран дээр ирээдүйн ажил олгогч нартайгаа ирээдүйн мастертайгаа ингээд хамт сураад, ингээд ажил мэргэжлээ дээшлүүлээд явчихдаг. Яг тэр нөгөө өнөөдөр томоохон үйлдвэр, томоохон төслүүд дээр ажиллаж байгаа технологийн төслүүд дээр ажиллаж байгаа мэргэжлийн ур чадвартай багш нар нь өнөөдөр яг ингээд энэ анги танхим дээр ирж, одоо мэргэжлийн ур чадварууд олгох нэг ийм хосмог тогтолцоо гэж ярьдаг юм байна лээ. Энэ хосмог тогтолцооны хамгийн гол зохицуулалтуудыг бол одоо бид нар энэ хуулиараа хийж өгсөн гэдгийг бас би танд онцолж хэлье гэж бодож байна. Тэгээд сүүлийн тэр асуултууд дээр яах вэ нийт Монгол Улсын хэмжээнд одоо нэг 76 МСУТ байгаа. Энэ дээр төрийн өмчийн 37, төрийн бус нэг 39. Энэ мэргэжлийн боловсролын одоо юу нь.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундром асуулт асууна.

Ч.Ундром: Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бол үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа юм. Хэд хэдэн асуудал байна. Өнөөдөр Монгол Улсад энэ ажилгүйдлийн түвшин өндөр байна. Өнгөрсөн хугацаанд Засгийн газраас тодорхой арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн ч гэсэн ажилгүйдлийн түвшин өндөр байгаад байгаа. Тэгээд түрүүн бас сайд хэлж байна л даа, энд

бас ур чадварын *gare* үүсчхээд байна гээд. Энэтэй бол үнэхээр санал нэг байна. Тэгэхээр энэ *gare*-ийг арилгахад бид нар мэргэжлийн холбоодтойгоо, мэргэжлийн энэ сургалтын төв бол маш ойрхон ажиллах ёстой. Яг ямар ур чадвар шаардлагатай байгаа юм бэ тэрийг нь энэ хөтөлбөртөө тусгаад ингээд явах ёстой.

Тэгэхээр энэ дээр засаглалын хувьд удирдах зөвлөлд нь түншилэгчдийг төлөөлөх 5 хүн гэж оруулсан байна. Яагаад түншилэгч гэж яг нэрлэсэн юм бэ? Шууд мэргэжлийн холбоод гээд тодорхой заагаад өгчхөж болоогүй юм уу гэдэг ийм асуулт байна. Тэгээд яг одоо Эдийн засгийн байнгын хороон дээр ХАҮТ-ын хууль хэлэлцэх гээд ороод ирсэн байгаа. Тэгэхээр энэ танхимын хуультай яг зэрэгцүүлж уялдуулах тал дээр та хэд маань ажилласан уу, үгүй юу гэдэг нэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт, энэ өнөөдөр Мэргэжлийн боловсролын сургалт үйлдвэрлэлийн төвд 35000 суралцагч байгаа. Эдгээрийн яг хэд нь техникийн чиглэлээр бүр болдог бол одоо уул уурхай, барилга ч гэдэг юм уу, яг хэд нь ийм чиглэлээр сурч байна гээд ийм статистик тооцоо та тоо та хэдэд байна уу, хэдэн хувь нь ч гэдэг юм уу тийм ээ. Энийг би бас нэг сонсох хэрэгтэй байна.

Дараагийнх нь Боловсролын багц хууль өргөн баригдаад одоо маш удаж байгаа. Ерөөсөө урагшлахгүй байгаа. Тэгээд энэ өргөн баригдсан хууль дээр ЕБС-ийг 12 дугаар анги хүртэл заавал сурах ёстой гээд ингээд төсөл дээр явж байдаг. Энэ хууль дээр чинь энэ чинь уялдаж байгаа юм уу, үгүй юу, яаж орж ирж байгаа юм бэ? Мэргэжлийн боловсрол эзэмшигчхээд дараа нь их сургуульд элсэж суръя гээд тухайн мэргэжлээрээ илүү гүнзгийрээд шат ахиад явъя гэх юм бол яаж их сургуульд элсэх юм бэ, энэ уялдаа холбоог хэрхэн хангаж байгаа юм бэ?

Дээрээс нь энэ Үндэсний зөвлөл гээд орон тооны бус нэг үндэсний зөвлөл байгуулах юм байна. Энэ Үндэсний зөвлөл чинь одоо орон тооны бус гэгчхээр заримдаа нэг их том зөвлөл байгуулчихдаг. Нөгөөдөхөд нь баахан хүмүүс ороод хуралдаж өгдөггүй, цуглаж өгдөггүй, ирэхээрээ янз бүрийн юм яриад өөр, өөр дэвэн дэлхийн юм хамж яриад шийдвэр гаргаж өгдөггүй ийм юм болчих вий дээ. Тэгэхээр энэний яг одоо чиг үүргийг хэрхэн тодорхой тусгаж өгсөн юм бэ?

Энэ судалгааны арга зүйн төв, бас дэд төв байгуулах гээд байх ишг байна. Заавал ийм дэд төв байгуулах ямар хэрэгцээ шаардлага байгаа юм бэ? Санхүүжилтийг нь бас хэрхэн тодорхой болгож байгаа юм бэ?

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтыг дэмжих сан гэж байгаа юм байна. Энэ сангийн үйл ажиллагааг хэрхэн сайжруулах юм бэ гэдэг асуулт байна.

Эцэст нь энэ хуулийн төслийн 9.1-д мэргэжлийн энэ боловсрол олгох байгууллагуудыг, техникийн боловсролын, мэргэжлийн боловсролын, мэргэжлийн сургалтын гэсэн 3 түвшинд хуваах гэж байгаа юм байна. Ингэж хуваах одоо ач холбогдол нь юу юм бэ?

Т.Аюурсайхан: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Аюурсайхан дарга энэ миний хариултын дараа бас хэд хэдэн гишүүд энэ салбарын статистикууд нэлээн асуугаад байна. Тэгэхээр манайхан энэ статистикуудаа бэлдээд яачих, Булгантуяа гишүүний хариулт, саяын Ундрам гишүүний хариулт дээр статистикуудаа хэлээд өгчхөөрэй.

Юуны хувьд яг энэ ажилгүйдлийн гэдэг дээр бид нар энэ Монгол Улсад

байгаа энэ ажилгүйдэл гэдэг дээр бид нэг ийм маш сайн суурь судалгаанууд хийж байж, маш сайн үнэлэлт дүгнэлтүүд хийж байж энэ дээр их тийм төрийн бодлого их зөв гаргах ёстой юм болов уу л гэж би ойлгоод байгаа юм. Тэгэхээр одоо нэг тийм сонин, сонин нэг ийм ойлгоход бэрх, одоо ингээд үзүүлэлтүүд байгаа байхгүй юу. Нэг талдаа болохоор 110000 хүн ажилгүй, нөгөө талдаа болохоор хөдөлмөрийн одоо ажлын байрны хомсдол бий болчихсон, дөчөөд мянган хүн ажлын байр сул байгаад байдаг. Хүн нь олддоггүй, ажиллах хүн олддоггүй. Тэгэхээр яг энэ юунаас болов, юунаас үүдэв гэдэг дээр бид нар их зөв анализ судалгаа хийж байж төлөвлөлтүүд, энэ алдаа дутагдлуудаа тогтолцооны алдаа дутагдлуудаа засах ийм зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа юм.

Бас нэг санаа зовоож байгаа зүйл бол энэ ажилгүйдлүүдийг ажилгүй хүмүүсийн дотор энэ 110000 хүмүүсийн дотор энэ залуу хүмүүс ажилгүй. Залуу хүмүүс дотроо мэргэжилтэй, дээд сургууль төгсчихсөн мөртлөө ажиллах сонирхолгүй. Мэргэжлийн боловсрол, одоо техникийн боловсрол төгссөн мөртөө ажиллах сонирхолгүй болчихсон нэг ийм сонин одоо гажуудал үүсчээд байгаа юм. Энэ дээр одоо жишээ нь яг ингээд энэ 21 оны нэгдүгээр улирлын байдлаар одоо 110000 хүний дотор бакалаврын боловсрол эзэмшсэн 29000 хүн одоо ажилгүй байж байгаа. 25000 одоо хүн бол нөгөө техникийн болон мэргэжлийн боловсрол төгссөн улсууд нь ингээд ажилгүй байж байх жишээтэй.

Тэгэхээр яг энэ нөгөө бид нарын дээд боловсролын тогтолцоо, энэ мэргэжлийн боловсролын тогтолцооны сул тал буюу гажуудлууд энэнээс үүсэж байна. Тэгэхээр энийг яг энэ боловсролын өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа Мэргэжлийн болон техникийн боловсролын хуулийнхаа шинэчлэл, тогтолцоогоор одоо засаж залруулахаас одоо өөр юу, гарц байхгүй гэж харж

байгаа юм. Ерөнхийдөө бид нар нөгөө нэг Ерөнхий боловсролынхоо тухай хууль дээр бид нар 12 жилийн заавал 12 жилийн тогтолцоонд шилжүүлж байгаа учраас энэтэйгээ уялдуулаад бид нар нөгөө 9 дүгээр анги төгсөөд 2.5 жил рүүгээ орчихдог, тэр нэг гажуудал үүсчихдэг. Хөдөлмөрийн зах зээл дээр ч гэсэн нас нь хүрэхгүй нэг 6-10 сарын гажуудал үүсдэг. Энэ асуудлууд нэгдүгээр асуудал.

2 дугаар асуудал бол 2.5 жилээр хүүхэд яг өөрийнхөө эзэмших ёстой бүрэн бус дунд боловсролыг авах ёстой агуулга мөн мэргэжлийн боловсролынхоо авах ёстой агуулгуудыг бүрэн авч чаддаггүй нэг ийм гажуудал байгаа учраас бид нар энэ техникийн боловсролынхоо мэргэжлийн боловсролынхоо суралцах хугацааг 2.5 жилийг бид нар 3 жил болгож засаж залруулж байгаа. Яг ингэснээрээ бид нар яг сая таны хөндөж тавьсан ахлах сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол дахиад дээшээгээ дээд боловсрол руугаа түвшин хоорондоо шилжээд, ахиад шатлаад ингээд кредитүүдээ тооцуулаад ингээд явчих энэ тогтолцоо дээр хамгийн зөв одоо тогтолцоог бид нар санал болгож оруулж ирж байгаа юм. Одоо бид нарын сул тал бол хүүхэд 12 дугаар ангиасаа төгсөөд дээд рүү орох, 12 дугаар анги.../минут дуусав/

Т.Аюурсайхан: 83 дугаар микрофон дээр нэмж хариулъя.

П.Оюунаа: Түрүүн Булгантуяа гишүүний асуусан асуултад хариулахад, одоогийн байдлаар энэ хичээлийн жилээс бол жилд бол 76 мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага ажиллаж байна. Энэ дээрээс бол төрийн өмчийн МСҮТ 16, төрийн өмчийн политехник коллеж 23, их дээд сургуулийн дэргэдэх одоо 4 МСҮТ ажиллаж байна. Харин хувийн МСҮТ, 8 политехник коллежууд одоогийн байдлаар ажиллаж байна.

Сүүлд Ундрал гишүүний асуусан статистикаас харах юм бол одоо энэ хичээлийн жилд нийт 45304 суралцагч суралцаж байгаа. Эдгээрийн 13.5 хувь буюу 6143 суралцагч нь Политехник коллежид, 84 хувь буюу 38098 суралцагч мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад юу, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж байна. Үлдсэн 8.5 хувь нь мэргэжлийн сургалт буюу түр сургалтын байгууллагуудад одоогоор суралцаж байна. Энэ хичээлийн жилээр авч үзэх юм бол ялангуяа элсэлтийн тооноос шалтгаалаад энд нийтдээ хэчнээн хүүхдүүд суралцаж байна вэ гэдгээс авч үзэхэд мянгаас дээш тооны суралцагчтай 10 одоо биш ээ 8 мэргэжил байна. Эдгээрт бол хамгийн эхэнд хамгийн олон одоо суралцагчтай мэргэжил нь тогооч, автомашины засварчин, гагнуурчин, барилгын цахилгаанчин, оёмол бүтээгдэхүүний оёдолчин, барилгын засал чимэглэлчин, үсчин, хэвлэлийн график дизайнер гэсэн энэ мэргэжлүүдээр бол хамгийн их суралцагчид суралцаж байна.

Харин 10-аас доош тооны суралцагч суралцаж байгаа цөөн хэдэн мэргэжил байна. Энэ бол гутлын үйлдвэрлэлийн технологийн ажилтан, гар утасны засварчин, массажчин, өргөх, зөөх механизмын техникч, өргөн тээвэрлэх тоног төхөөрөмжийн засварчин, Б ангиллын жолооч, уул уурхайн машин механизмын электрон төхөөрөмжийн техникч, Монгол зургийн зураач, кофе бэлтгэгч гэсэн энэ мэргэжлүүдээр бол суралцагчийн тоо маш хангалтгүй ийм байдалтай байна.

Т.Аюурсайхан: Ундрам гишүүн асуултаа тодруулъя.

Ч.Ундрам: Энэ санхүүжилттэй холбоотой түрүүн асуусан. Санхүүжилтийнхээ талаар тодруулга хийе.

Т.Аюурсайхан: Энх-Амгалан сайд нэмж хариулъя.

Л.Энх-Амгалан: Бид нар ерөнхийдөө энэ мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын санхүүжилтүүдийг бол олон эх үүсвэрээс санхүүждэг энэ тогтолцоо руу шилжих ёстой гэж ойлгож байгаа. Хамгийн гол санхүүжилт болж байгаа энэ нэг хүүхдийг сургаж байгаа хувьсах зардал байгаа юм. Одоо нэг 500-600 мянга орчим төгрөг байдаг юм байна лээ. Тэгээд энэ хувьсах зардлын одоо ингээд өртөгт ерөөсөө энэ суурилсан хувьсах зардал ерөөсөө биш. Тийм учраас цаашидаа бид нар энэ мэргэжлийн бодит өртөгт суурилсан энэ санхүүжилтийн тогтолцоо руу орж байж манай мэргэжлийн боловсрол, техникийн боловсролд өрсөлдөх чадвартай болно. Өрсөлдөх чадвартай болно. Бид нар яг үндсэндээ бол нэг ийм 2,5 сая, 6 сая, 3 сая хүрэхгүй хөрөнгө одоо хувьсах зардлаар хүүхэд сургачхаад, тэр нь ингээд ажлын байран дээр одоо өндөр ур чадвартай, өндөр цалин, өндөр бүтээмжтэй ийм ажлын байран дээр одоо ажиллах ийм хүн сургаж байна гэдэг одоо ингэж бие биеийгээ хуурч амьдарч ерөөсөө болохгүй.

Тийм учраас хамгийн гол асуудал бол энэ хувьсах зардал. Тэгээд цаашидаа бол одоо энд.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан асуулт асууна.

Б.Дэлгэрсайхан: Ингээд хүмүүс чинь одоо онол онолын гоё л юм ярьж байна л даа. Олон сайхан ч хууль хийж байна. Тэгээд одоо би одоо энэ өнгөрсөн юмыг хараад жосоохон гайхаад байгаа юм. Энэ нэг яахаараа ингээд 200000 төгрөг өгөөд, эндээ хяналт тавихгүй, тэгээд өнөөдөр энэ бэлдээд гарсан хүмүүс нь хөдөлмөрийн зах зээл дээр байхгүй, энийг тэр та нар яагаад эргэж харахгүй байгаа юм бэ? Мэдээж энэ Хөдөлмөрийн яамнаас танай яам руу шилжиж очсон. Тэгээд боловсрол талд нь анхаарч

байгааг бол дэмжиж байна. Тэгээд жишээлбэл, одоо энэ МСҮТ, коллеж хоёрын хооронд ер нь ямар ялгаа байна вэ? Одоо статусын хувьд ярьж байгаа шүү дээ.

Тэгээд Дорноговьд нэг МСҮТ байсан. Тэгээд сүүлд коллеж болгосон. Тэгээд Боловсролын яамнаас нэг ч очиж анхаараагүй. Би одоо сайдыг нь нэг очооч гэсэн, тэгээд газрын дарга ч очсонгүй. Очоод, очоод, байж байгаарай, байж бай. Би минутаа нөхөж авна шүү, ингээд хэрүүл хийгээд байх юм бол. Тэр би яагаад энийг яриад байгаа вэ гэхээр Дорноговь дээр байгаа МСҮТ бол нэг үсчин одоо юу гэдэг юм, тогооч гээд ингээд. Тэгээд очихоор нэг хоол хийгээд л угтдаг. Тэгээд хоолыг нь идчихээд яваад өгдөг. Ийм байдлаар сургууль байна гэж байж болохгүй. Би энэ одоо захиралд нь мөн ч олон удаа хэлсэн. Тэгээд статус нь өөрчлөгдсөн юм бол та нар энэ арга хэмжээ аваад тэр захирлыг нь соль л доо. 8, 9 жил л боллоо. Тэгээд л одоо хэлээд нэг хэдэн тогооч юу, үсчин 2-той л байна шүү дээ энэ сургууль чинь. Та нар энийгээ хяна л даа. Тэгээд л гоё хууль яриад байх юм.

Тэгээд яг тэр Дорноговь чинь одоо баяжуулах үйлдвэр гээд өчнөөн төчнөөн үйлдвэр босчихоод ажилчин байхгүй. Тэгээд бэлтгэе гэхээр одоо тэр сургууль нэг ийм бэлтгэхээр энэ талаар анги байхгүй. Аргаа ядаад одоо төмөр замын нэг 70 гаруй хүүхдийг одоо хувиараа бэлдлээ шүү дээ. Зүүнбаян Ханги мандалын төмөр зам ашиглалтад орж байгаатай холбогдуулан. Өөрсдөө мөнгөө гаргаж бэлдэж байна шүү дээ. Тэгээд одоо гоё юм яриад байдаг. Тэгээд би энэ та нар энэ МСШТ, энэ коллеж энэ тэрээ яг энэ уул уурхай, эсвэл тэр тухайн одоо орон нутагт нь байгаа үйлдвэр аж ахуйн газрыг нь түшиглэж байгуул л даа. Тэгэхгүйгээс болоод энэ орон нутагт чинь одоо тэгээд энэ орон Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулна, их дээд сургууль гаргана, тэгээд л энэ бусад сургуулиа гаргана гээд л яриад л байдаг,

яриад л байдаг. Тэгээд амьдрал дээр тэнд нэг гоё сургууль байгуулчихъя, их аятайхан болгочихъя гээд л ингээд л тойроод л баахан үйлдвэр байгуулагдаад л байдаг. Тэгээд нэг ч анхаарах юм анхаарахгүй шүү дээ та нар. Тэгээд энийгээ очоод цэгцлээд өг л дөө.

Тийм учраас энэ багш багшийг нь шийдээд аль нэгдүгээрт. Хоёрдугаарт, цаашидаа одоо ийм байдлаар би бол энд одоо хамгийн сайн хэрэгжиж байгаа нь энэ Германы хөрөнгө оруулалттай нэг коллеж байх шиг байгаа юм. Энэ арай үлгэр жишээ харагдаад байгаа юм. Тэгээд ийм маягаар одоо та нар энийг одоо ажиллуулмаар байх юм. Ялангуяа боловсрол гээд тэр ажил мэргэжил 2-ыг сурах хоёрыг хослуулна гэж байгаа чинь бол яг тэр үйлдвэр байгуулагдаж байгаа газар нь л энэ сургууль байх ёстой юм байна гэж би бодож байна. Тэгээд энэ жил төсөвт ямар нэгэн юм тавихгүй гээд байгаа. Тэгээд уул нь бол энэ Дорноговьд ирэх жил бол нэг аятайхан энэ коллежийн байр байшин, тэр сургалтын баазыг нь түшиглэн бэлэн байгаа юм чинь ингээд түшиглээд байгуулчихна гэсэн. Одоо тэр худлаа боллоо. Гэхдээ ядаж энэ нэг доторх багш, боловсон хүчин энэ тэрийг нь та нар нэг цэгцлээд өгөөч, очоод шалгаад өгөөч. Хүний хүүхдүүд нэг сурч байгаа ч юм уу, үгүй ч юм уу тэгээд нэг 200000 төгрөгийн төлөө нэг ингээд цаг нараа үрээд, тэгээд.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Дэлгэрсайхан гишүүнд микрофон нэмж өгье.

Б.Дэлгэрсайхан: Тийм учраас энэ ажилгүйчүүдийн их юу 110000 хүн ажилгүй байна, одоо энэ ингээд гайхаад байна гээд байх юм ерөөсөө байхгүй. Наана чинь бол зөвхөн 200000 төгрөг авах гэж сураад, авдгаа аваад л тэгээд одоо ажил хийхгүй, ингээд байж байгаа.

Дараагийн халамж юу бол гэж хүлээгээд. Тийм учраас энэ бүр насны хязгаар хязгаараа зааж өгөөд, ингээд

тодорхой болгохгүй бол тэгээд л энэ мөнгөний төлөө хэн ч хамаагүй очиж сураад ийм л юм болсон шүү дээ өнгөрсөн хугацаанд. Тэгээд одоо энийгээ яаж засаж залруулж, насыг нь хязгаарлаж заах юм бэ? Энийг одоо бас нэг хуульдаа юу тусгаж байгаа юм бэ? Тэгээд энэ хуулийн чинь амин сүнс нь одоо түншлэлийн зарчим дээр үндэслэх ёстой гээд сайд өөрөө ярилаа. Тэгэхээр цаашидаа бол би энэ олон уурхай дагаж, ялангуяа одоо энэ баяжуулах үйлдвэр дагаж, төмөр зам дагаж энэ сургууль чинь байгуулагдах юм байна гэж ойлгож байгаа. Дорноговь маш их төмөр замтай аймаг. Монгол Улсад хамгийн урт төмөр замтай аймаг Дорноговь. Дорноговь дээр.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Манай Дэлгэрсайхан гишүүн бол хамгийн том ажил олгогч, хамгийн том татвар төлөгч, хамгийн том бүтээн байгуулалтын ажлыг хийдэг, одоо ингээд хамгийн зовлонг нь мэддэг. Монгол Улсад мэргэжлийн болон техникийн боловсролын тогтолцоо яг ямар байх ёстой вэ гэдэг бараг дүр зургийг нь хамгийн сайн мэдэх хүний нэг учраас өнөөдрийн ийм жаахан бодитой зүйлүүдийг ярьж байна л даа. Тэгээд асуудал яг юундаа байна вэ гэхээр одоо онолын юм, онолын маргаан өрнөөд байгаа асуудал биш Дэлгэрсайхан гишүүнээ. Бид нар эрх зүйн шинэчлэл, энэ тогтолцоогоо цөмөөрөө нэг зөв болгохгүй бол ингээд нэг өдөр өргөс авсан юм шиг нэг ийм гоё болохгүй. Энэ чинь сүүлийн 30 жилийн тогтолцооны гажуудлуудыг л одоо зөв засах л ийм хэрэгцээ шаардлага өнөөдөр үүсээд байна шүү дээ.

Тэгээд яагаад одоо би ч гэсэн танд бас гайхаж байгаа, яг тантай адилхан. Яг нөгөө нэг мэргэжлийн боловсрол Боловсролын яаманд ирэхээс яг нэгхэн сарын өмнө бүх сургуулиудыг нь

коллеж болгочихсон юм байна лээ. Тэгээд ямар үндэслэлээр коллеж болгосон юм, тэгээд коллеж болгож яг яах гэж байгаа юм гэдэг асуудлууд. Ерөөсөө бүгдийг нь коллеж болгочихсон. Тэгэхээр ийм нөгөө нэг манай төрийн байгууллагуудын хоорондын нөгөө бодлогын уялдаа зохицуулалтууд алга байсан нэгд.

Хоёрт болохоор нөгөө мэргэжлийн боловсрол нь Хөдөлмөрийн яаманд 12 оноос хойш очсоны гажуудлууд л ингээж л өнөөдөр гарч ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ үүссэн энэ гажуудлуудыг ингээд цөм ямар ч байсан нэг ингээд засаад залруулаад авчихъя. Цаашидаа Монгол Улсад мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол, мэргэжлийн сургалт гэж байх юм бол яг ямар хэлбэртэй сургалтууд байх юм, мэргэжлийг гэж яг бид нар юуг ойлгох юм, мэргэжлийн үндсэн чадвар гэж бид нар яг юуг ойлгох юм, мэргэжлийн суурь чадвар гэж бид нар юуг ойлгох юм, энэ нь эргээд яг ямар тогтолцоогоороо аль, аль түвшиндээ бид нар аваад явах ёстой юм бэ гэдэг энэ зүйлүүдийг л бид нар их тодорхой ёстой болох ёстой юм байна лээ л гэж би харж байгаа юм.

Өнөөдрийн бид нарын бухимдаад, одоо ингээд нэг ийм шүүмжлээд ингээд байгаа гол асуудлууд бол бид нарын зовлон өнөөдөр юу вэ гэхээр ерөөсөө тэгээд л зөв тогтолцоонд шилжиж чадаагүй л бид нарын зовлон байхгүй юу. Бид нар ерөөсөө энэ мэргэжлийн боловсролынхоо тогтолцоог боловсролын нь нэг хэсгээс гаргаад хаячихсан. Тэгээд цаашидаа ерөөсөө л улс орнуудад байдаг энэ үндэсний мэргэжлийн шаталсан бүдүүвч гэдэг зүйлээ яг энэ боловсролын түвшин бүрд нь уяж чадаагүй нэг ийм л гажуудалтай байсан учраас өнөөдрийн ийм зовлон үүссэн болов уу л гэж бодож байгаа юм. Тэгээд одоо хамтраад ажиллана. Би бас Өмнөговь юу, Дорноговь аймагт 2 ч удаа таны үүрэг даалгавраар очиж ажилласан. Тэгээд нэг ганц нэг коллежийн захирлыг, нэг хүнийг

нөгөө хүнээр солих нь бид нарт чухал биш. Хамгийн гол нь тогтолцоогоо л зөв болгоё гэж байгаа юм.

Т.Аюурсайхан: Дэлгэрсайхан гишүүнд 1 минут нэмж өгье.

Б.Дэлгэрсайхан: Юу л даа сайдаа Боловсролын яамныхан энэ сургуулийг очоод та нар нэг яг хэдэн хүүхэд, юу сураад байгаа юм, ямар анги байгааг нэг очоод нэг үзээд өгөөч л гэж байгаа юм. Би одоо тэр захиралтай нь уулзсан, багш нартай уулзсан. Хэдэн тогооч, тэгээд нэг үсчин. Одоо энэ Дорноговь үсчин тогооч 2-оор бол хангалттай болсон. Зүгээр л би одоо энэ нэг тэр Дорноговьд баригдаж байгаа нэг баахан үйлдвэр, энэ урт төмөр замыг нэг эзэнтэй болгочих гээд л энийг яриад байгаа юм. Тэрнээс шүүмжлээд байгаа юм биш. Энэ та нарын хуулийг бол дэмжиж байна, зөв. Мэдээж боловсролтой мэргэжилтэй болгож байж гаргах хэрэгтэй. Тэгээд энэ сургууль одоо яг ямар нэртэй сургууль байхыг нь ядаж хэлээд аль. Би эсвэл төмөр замын дээд сургууль ч юм уу, коллеж болгоё гэж бодоод, хүсээд байгаа юм. Эсвэл уулын баяжуулах үйлдвэрийн коллеж ч гэдэг юм уу нэг ийм нэр устай болгохгүй бол зүгээр л коллеж. Яг ямар коллеж.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Үг хэллээ. Хариулт авах юм уу? Энх-Амгалан сайд хариулт өгье, 1 минут.

Л.Энх-Амгалан: Зөвөө зөв. Яг одоо ингээд Дэлгэрсайхан гишүүн яг одоо ингээд өөрийнхөө Дорноговь аймаг дээр байгаа энэ коллежийг яг бид нарын өнөөдрийн хийх гэж хүсэж байгаа тэр тогтолцоо руу хууль гарахаас өмнө ер нь шилжүүлээд өгье л гэж хэлээд байна шүү дээ, тийм ээ. Тийм учраас одоо ингээд энэ Дэлгэрсайхан гишүүний санал санаачилгыг бол бид нар хүлээж авч байна. Ингээд манай яамны одоо яг энэ холбогдох дээд боловсрол, техникийн боловсрол хариуцсан энэ бүх улсууд очиж ажиллана. Гэхдээ одоо Дэлгэрсайхан

гишүүнээ ийм шүү. Коллежийг яг ямар коллеж байх вэ гэдгийг төр шийдэх биш, тухайн орон нутаг нь, тухайн салбар нь шийддэг энэ тогтолцоо руу л оръё гэж байгаа юм. Энэ тогтолцоо руу тийм ээ.

Т.Аюурсайхан: Гишүүд асуулт асууж, Адьшаа гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье. Улсын Их Хурлын гишүүн 6 хүнээр шүү дээ. Ямар ч байсан Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн, Бейсен гишүүн байна. Ингээд 6 хүн одоо гишүүн үг хэлнэ. 13 цаг өнгөрч байна. Одоо Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл хуралдах учраас нэрсийг хадгалаад, ингээд чуулганы үдээс өмнөх хуралдааныг түр завсарлуулж байна.

13.16 цаг

2022 оны 10 дугаар сарын 14, Баасан гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 12 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Дөрөв.Улсын Их Хурлын гишүүн
М.Оюунчимэгээс Монгол Улсын
Ерөнхий сайдад хандаж “Эмийн
үйлдвэрлэл, чанар, хяналт,
хүртээмжийн зэрэг асуудал болон энэ
талаарх цаашидын бодлого, зорилтын
талаар”, Улсын Их Хурлын гишүүн
Ц.Туваанаас Эрүүл мэндийн сайдад
хандаж “Эм үйлдвэрлэл, эмийн үнийн
талаар” тус тус хандаж тавьсан
асуулгын хариуг сонсох**

Т.Аюурсайхан: Үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж Эмийн үйлдвэрлэл, чанар, хяналт, хүртээмжийн зэрэг асуудал болон энэ талаарх цаашидын бодлого, зорилтын талаар, мөн түүнчлэн Улсын

Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваанаас Эрүүл мэндийн сайдад хандаж Эм үйлдвэрлэл, эмийн үнийн талаар тус тус тавьсан асуулгын хариуг сонсоно.

Ажлын хэсгийг танхимд оруулаарай. Асуулгад Эрүүл мэндийн сайд Сэрээжавын Энхболд хариулна. Индэрт урьж байна. Ажлын хэсгийн нэр өгөөрэй.

С.Энхболд: Эрхэм хүндэт Их Хурлын дэд дарга болон эрхэм гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай холбоотой Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад 5 чиглэлээр, Улсын Их Хурлын гишүүн Туваан Эрүүл мэндийн сайд 4 чиглэлээр тус тус асуулга тавьсан. Зарим асуудлууд давхцаж байгаа учраас бид нар нэгтгээд товч мэдээллийг хүргэе.

Нэгдүгээрт, ЭМД-ын сангаас хөнгөлж байгаа эм болон бусад эмийн үнэ өндөр байгаа талаар эм, эмийн нэр төрлийн сонголт буруу, оновчгүй тогтоосон үнийн дээд хязгаар, хөнгөлж байгаа арга хэмжээ нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн хувьд хувиасаа төлөх төлбөрийн хэмжээг дорвитой бууруулж чадахгүй байгаа тухай асуулга байсан бөгөөд иргэдийг чанартай, боломжийн үнэтэй эмээр хүртээмжтэй хангах чиглэлээр ямар бодлого баримталж байгаа талаар. ЭМД-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.10 дахь заалтын дагуу ЭМД-ын Үндэсний зөвлөлийн тогтоолоор ЭМД-ын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг бол баталдаг.

Монгол Улсын хүн амын дунд зонхилон тохиолддог өвчин эмгэгийн үед хэрэглэх зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон ерөнхий нэршилйн 159

эм, худалдааны нэрийн 590 эмд үнийн дүнгээс хамааруулан 30, 50, 70, 100 хувийн хөнгөлөлттэй хөнгөлөлт олгохоор ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 22 оны 11 дүгээр тогтоолоор баталж, гэрээ бүхий 1800 гаруй эмийн сангаар дамжуулан иргэн, даатгуулагчдад хүргэж байна. Үүний дотор нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа болон удаан хугацаагаар тогтмол хэрэглэгддэг даатгуулагчийг санхүүгийн эрсдэлд оруулдаг эмүүд болон зүрх судасны өвчин, уналт таталтын эсрэг, чихрийн шижингийн эсрэг эмүүд болон зарим вирусийн эсрэг эмийг далаас зуун хувийн хөнгөлөлтийг үзүүлж байна.

Иргэнд очих эм, эмийн хэрэгслийн үнийг бууруулах, төсөвт хэмнэлт бий болгох зорилгоор бодлогын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд Ерөнхий гэрээгээр худалдан авах цахим дэлгүүрт байршуулан худалдан авах үйл ажиллагааг 21 онд 82 нэр төрлөөр, 22 онд 116 нэр төрлөөр хийж, 18.9 тэрбум төгрөгийн хэмнэлт хийсэн байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 132 дугаар тогтоолоор коронавируст халдварын үед хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйдлийн бодисыг 22 оны 1 сарын 1-ний өдөр хүртэл гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн бөгөөд 257 ААН-ийн 615 нэр төрлийн 1.1 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий бүтээгдэхүүн, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлөгдсөн байна. Энэ нь иргэнд очих эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг тав орчим хувиар бууруулсан.

Эмийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр, Новартис-н хүрээнд 15 нэр төрлийн 22 тун эмийг хамгийн бага үнийн өртгөөр нийлүүлэх ажлыг хэрэгжүүлж эхлээд байна. Өнөөдрийн байдлаар 22 нэр төрлийн эм нь Монгол Улсын гаалиар орж ирсэн байна. Ховор тохиолддог өвчин эмгэгийг эмчлэх зайлшгүй шаардлагатай эм, эм болон

нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, түүний дагалдах хэрэгслийн худалдан авалт, ханган нийлүүлэлт, нөөц болон нөөц бэлэн байдлын асуудал хариуцсан Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн төв УТҮГ-ыг байгуулахаар ажиллаж байна.

Хоёрдугаарт, эм, эмнэлгийн хэрэгслийн дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн чанартай холбоотой асуулга бөгөөд үйлдвэрүүдэд GMP хангуулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, цаашдын бодлого, зорилтын талаар.

2022 оны 10 дугаар сарын байдлаар эм эмнэлгийн хэрэгслийн 33 дугаар дотоодын үйлдвэрээс 7 эмийн үйлдвэр нь Монгол Улс, Монголын үндэсний эмийн үйлдвэрлэлийн зохистой дадал буюу GMP шаардлагыг хангасан. Нэг үйлдвэр Франц улсын хөндлөнгийн гэрч, үнэлгээний гэрчилгээ аваад байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтын дагуу үйлдвэрүүд өөрийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хариуцан ажилладаг. Монгол Улсын дотоодын эмийн үйлдвэрлэлд үйлдвэрлэгдэж буй бүтээгдэхүүний 92 хувийг эм үйлдвэрлэлийн зохистой дадал GMP хангасан, шаардлага хангасан буюу дээрх 7 үйлдвэрийн бүтээгдэхүүн, үлдсэн 8 хувийг эмийн үйлдвэрлэлийн зохистой дадал, үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлж байна.

Эдгээр үйлдвэрүүд нь эм үйлдвэрлэлийн зохистой дадал хангахад тулгамдаж байгаа асуудлыг судалж үзэхэд санхүүжилт, хөрөнгө оруулалт, хүний нөөцийн чадавхтай холбоотой асуудлууд байгаа. Бидний зүгээс эм үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага, MNS 2014 стандартыг ДЭМБ-ын удирдамжтай нэгийг харьцах нь нэг харьцаатай шинэчлэх, Монголбанкнаас хэрэгжүүлж буй репо санхүүжилтийн зээлд хамрагдуулах

түүхий эд, савлагааны материал, туслах материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль батлуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байна.

Улсын Их Хурлын гишүүн Тувааны асуулгатай холбоотой уламжлалт эмийн үйлдвэрлэлийн талаар дэлгэрүүлж танилцуулъя. Улсын хэмжээнд 1973 онд Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн УҮГ, 1990 онд Мамбадацан эмийн үйлдвэр, Монгэм эмийн үйлдвэр, 91 онд Уламжлалт анагаахын ухааны элэг судлалын клиник төв, эмийн үйлдвэр, 2003 онд 13 онд Одь Тан эмийн үйлдвэр, 2015 онд Мон интра эмийн үйлдвэр тус тус байгуулагдаж, өнөөдрийн байдлаар нийт 6 уламжлалт эмийн үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Эмийн чанар, аюулгүй байдал, эмийн үйлдвэрийг чадавхжуулах, GMP хангах сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулснаар Армон эмийн үйлдвэр нь Эмийн үйлдвэрлэлийн зохистой дадал буюу GMP гэрчилгээг 21 онд авсан.

Уламжлалт анагаах ухааны салбарын өнөөгийн байдал, хэтийн төлөв, асуудал, шийдэл, сэдэв, зөвлөгөөнийг 22 оны тавдугаар сард зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.

Гуравт эмийн чанар, үйлчилгээнд тавьж буй хяналт, цаашдын хяналтын тогтолцоог сайжруулах бодлогын талаар асуулга байсан бөгөөд импортын эмийн 6.1 хувь нь дотоодод үйлдвэрлэсэн эмийн 18.6 хувь нь чанарын шаардлага хангаагүй, эмийн гаж нөлөөг бүрэн бүртгэх, хянах, мэдээлэх тогтолцоо бүрдээгүй, эмийн бүртгэлд тусгай зөвшөөрөл олголт, үр дүнд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлэхэд хэрэгжүүлээгүй зэрэг асуудлууд багтана. Эмийн гаж нөлөөг бүрэн бүртгэх, хянах, мэдээлэх тогтолцооны хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/415 дугаар

тушаалаар батлагдсан Эмийн гаж нөлөө болон аюулгүй байдлын мэдээллийг бүртгэх, мэдээлэх журмын дагуу эмийн гаж нөлөөний мэдээллийг эрүүл мэндийн байгууллагаас эмийн аюулгүй байдлын тайланг эм хангамжийн байгууллагуудаас хүлээн авдаг.

Монгол Улс Олон улсын эмийн хяналтын төв Унпсала 149 дэх жинхэнэ гишүүнээр орноор 21 оны 10 дугаар сарын долооны өдөр элсэж, гишүүн орнуудтай эм, вакцины гаж нөлөө, эрсдэлийн мэдээллийг шуурхай харилцан солилцож, эмийн чанар, аюулгүй байдлын зохицуулалтыг олон улсын жишгээр хэрэгжүүлэх боломж бүрдсэн. Эмийн бүртгэлийн үйл ажиллагаа, зохицуулалтыг сайжруулах хүрээнд хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг чанартай, аюулгүй эмчилгээний идэвхтэй эмээр хангах зорилгоор эмийн бүртгэлийн үйл ажиллагааг 1994 оноос эхэлсэн. Эрүүл мэндийн сайдын 2019 оны 295 дугаар тушаалаар батлагдсан Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх журмын дагуу эм, эмийн түүхий эд, биологийн идэвх бүтээгдэхүүн, оношлуурын бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулж байна. Монгол Улсад бүртгэлтэй эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүн, оношлуурын худалдааны нэр, тун хэмжээ, хэлбэр үйлдвэрлэгч, улс, хэрэглэх заавар, анхдагч хоёрдогч савлагааны зэрэг мэдээллийг эмийн бүртгэлийн Лайсмед мэдээний санд тогтмол бүртгэн оруулж байна.

Тусгай зөвшөөрөл олголтын талаар тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг сайжруулах зорилгоор тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэлтийн явцыг ил тод, нээлттэй болгож байна. Тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын байршлын зураглалыг гаргаж, цахим системд оруулан хяналтыг хялбар болгож байгаа. Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотой салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт

оруулах, холбогдох журмуудыг шинэчлэх ажлууд хийгдэж байна. Эмийн чанар, үйлчилгээнд тавьж буй хяналт, цаашид хяналтын тогтолцоог сайжруулах бодлогын талаар түүний Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд 2002-2021 онуудад эм, био бэлдмэлийн хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлэн ажиллаж байсан. 21 онд 287 эм хангамжийн байгууллагыг хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд хамруулсан бөгөөд хяналт шалгалтын явцад эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, хадгалалтын дэглэм алдагдсан, давхардсан цоогоор 769 нэр төр, нэрийн эм, эм, эмнэлгийн хэрэгслийг илрүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ аваад байна.

22 оны нэгдүгээр улиралд коронавируст халдварын эмчилгээнд ӨЭМТ-өөс олгож буй эмийн багцын хадгалалт, зарцуулалт, эрүүл мэндийн байгууллагуудад хэрэглэгдэж байгаа болон эмийн санд худалдаалагдаж байгаа яаралтай тусламжийн вирусийн эсрэг эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд 5 удаагийн хяналт, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Дөрөвдүгээрт, хөдөө орон нутаг, алслагдсан сум, багт зайлиггүй шаардлагатай зарим нэр төрлийн эмийн хүртээмж хангалтгүй байгаагаас иргэд Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх эрхээ тэгш эдэлж чадахгүй байгааг хэрхэн шийдвэрлэх талаар.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн дэмжлэгтэй 1994-2008 онд 17 аймгийн 288 суманд, 2010 онд Төв аймгийн 26 суманд эмийн бүртгэлийн сан байгуулсан нь 18 аймгийн 311 сумын ард иргэдэд эмийн эргэлтийн сангаар дамжуулан зайлиггүй шаардлагатай эмээр хангах тогтолцоог бүрдүүлсэн.

Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор 21 онд 18 аймгийн 215 сумын иргэд болон эргэлтийн эмийн сангийн ажилтнуудаас эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа, эмийн хангамж, хүртээмжийн талаар асуумж судалгаа авч, судалгаагаар орон нутгийн өмчит аж ахуйн хэлбэрээр 130, хувийн 28, эрүүл мэндийн газрын харьяа 57 эмийн сан тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Эмийн эргэлтийн сангийн 67 хувь нь санхүү эдийн засгийн хувьд ашигтай, 33 нь ашиггүй гэсэн судалгааны дүн гарсан бөгөөд нийт эмийн эргэлтийн сангийн 66 хувь нь хувийн хэвшилд иилжүүлэх саналтай гэсэн байна. Иймд орон нутгийн хүн амын тоо, бүтцийн онцлогт тохирсон байдлаар эргэлтийн эмийн сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тухайлбал, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хэрэглэгдэхүүний тухай хуулийн төсөлд түсгах, холбогдох дүрэм журмыг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна.

Тавдугаарт, олон улсын хямралт нөхцөл байдлаас шалтгаалан зарим нэр төрлийн эмийн тасалдал үүсэж болзошгүй нөхцөлийг хэрхэн зохицуулах талаар.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А178 дугаар тушаалаар импортоор оруулж ирж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эд, тоног төхөөрөмж, лабораторийн урвалж оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бодисыг улсын хилээр нэвтрүүлэх, тээвэрлэлттэй холбоотой асуудлыг шуурхай зохион байгуулах ажлын хэсгийг байгуулагдан ажиллаж байна. Сүүлийн 2 сарын байдлаар эм, эмнэлгийн хэрэгсэл хянан нийлүүлэх 7 байгууллагын 69 нэхэмжлэлийг төлбөр болох 4 тэрбум 834 сая ам.доллар, 4 сая 39 евро, мянган евро, 15000 Оросын холбооны рубль, 89000 Японы иен буюу нийт хорин нэг

аравны 24,1 тэрбум төгрөгийн гүйлгээний хүсэлтийг Монголбанканд хүргүүлж, гүйлгээ 80 хувь хийгдсэн байна. ГХЯ, Зам, тээврийн хөгжлийн яам, УБТЗ тээвэрлэлтийн асуудал дээр хамтран ажиллаж байна.

Сүүлийн 2 сарын байдлаар 34 байгууллагын 77 чингэлэг ачаа татан авах ажлыг зохион байгуулсан. Мөн Эрүүл мэндийн сайдын 22 оны 425 дугаар тушаалаар өндөр үнийн өсөлттэй гол нэрийн Эм, эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа. Эмийн нөөц, тасалдал, валют гүйлгээ, тээвэрлэлт, үнийн өсөлтийн талаар Эдийн засаг, хөгжлийн яаманд тухай бүр хүргүүлж, Засгийн газрын хуралдаанд танилцуулагдаж байгаа. Зах зээлд өндөр хувь эзэлдэг гол нэрийн 75 эмийг сонгон судалгаа хийж үзэхэд гол нөлөөлөх хүчин зүйл нь түүхий эд, сав, баглаа боодлын үнийн өсөлт, ханишийн зөрүү, тээврийн зардлын нэмэгдэл байна. Монгол Улсын Засгийн газар, ЭМЯ-ны зүгээс одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд зайлшгүй шаардлагатай чанартай, хүртээмжтэй, боломжтой үнэтэй эм, эмнэлгийн хэрэгслийн эрүүл мэндийн байгууллагууд иргэдээ хангах, төр хувийн хэвшлийн байгууллагуудтай бүхий л талаар хамтран ажиллаж байгаа билээ.

Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн төслийг Засгийн газраас татан авсантай холбоотой Эрүүл мэндийн сайдын 2022 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 330 дугаар тушаалаар хуулийн төслийн зарим үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Товч танилцуулга хийж дууслаа.

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрэм, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Орхон сумын ЗДТГ-ын алба хаагчид Улсын Их

Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийг танилцуулъя. Сэрээжавын Энхболд Эрүүл мэндийн сайд, Эрдэнэбилэг ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Буянтогтох тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Нарангэрэл тус яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга, Мөнхцэцэг тус яамны Санхүү, даатгалын хэлтсийн дарга, Амаржаргал тус яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын ахлах шинжээч, Бямбасүрэн ЭМД-ын ерөнхий газрын дарга, Оюунцэцэг тус газрын Тусламж үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газрын дарга, Гантөмөр тус газрын Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, Баярболд тус газрын Тусламж үйлчилгээний багц зохицуулалтын хэлтсийн дарга, Цэнгэл Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газрын дарга, Номин тус газрын Чанарын хяналтын газрын дарга, Сэцэнсанаа тус газрын Эм хангамжийн газрын дарга, Энхзаяа тус газрын Эм шинжлэх лабораторийн дарга, Мөнхтуул тус газрын Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга, Бямбадорж тус газрын Эмийн үйлдвэрийн хэлтсийн дарга гэсэн ажлын хэсгийг танилцуулж байна.

Асуулгын хариулттай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүдийн нэрийг авъя. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал асуулт асууна. Улсын Их Хурал дээр Хүний эмийн чанарын хяналт шалгалтын түр хороог байгуулж ажиллаж байгаа. Тэгэхээр эмийн чанарын түр хороо дээр бас холбогдох мэдээллүүдийг сонссон. Өнгөрсөн чуулганаар бол бас Нийгмийн бодлогын байнгын хороон дээр бас энэ эмийн чанарын асуудлаар бас хэд хэдэн

удаагийн бас мэдээллүүдийг бол бид бас сонссон.

Аудитын байгууллага ч гэсэн тодорхой дүгнэлтийг хийсэн байгаа. Тэгээд бид бол тодорхой зорилтыг дэвшүүлж байгаа юм. Хүний эмийн чанарын хяналтын түр хороо бол яг нөхцөл байдлыг бодитойгоор дүгнэхийн төлөө л ажиллана. Тэгэхээр нөхцөл байдлыг бодитойгоор нь дүгнэхгүйгээр одоо бид нар чанаргүй эм хэрэглэж байна, одоо эрүүл мэндийн салбарт эмийн асуудал ийм өндөр түвшинд тавигдсан гэдэг ийм ерөнхий байдлаар дүгнэж, бас одоо эм ханган нийлүүлэх байгууллагууд, эмийн үйлдвэрлэл явуулж байгаа, зохистой үйлдвэрлэл явуулж байгаа байгууллагуудын тийм нэр хүндэд бас халдаж болохгүй.

Тийм учраас бодитойгоор асуудалд хандах ёстой. Үндэсний аудитын байгууллага бол тодорхой дүгнэлт гаргаад энэ GMP-ийн шаардлагыг хангаагүй буюу энэ үйлдвэрлэлийн стандартыг шаардлага хангаагүй эмүүд үйлдвэрлэгдээд байна гэсэн ийм дүгнэлтийг бол гаргасан байсан. Нийт тусгай зөвшөөрөлтэй энэ 38 эмийн үйлдвэр байгаагаас 7 үйлдвэр дотоодынх, нэг нь бол энэ Европын GMP шаардлагыг хангасан ийм одоо үйл ажиллагаа нь явагдаж байгаа. Тэгэхээр цаашидаа бол энэ асуудал юунаас болж үүсээд байгаа вэ гэдэг дээр дүгнэлт гаргахын тулд шинжилгээнийхээ лабораторид энэ эмүүдийг шалгуулъя гэхээр манай одоо тэр хуучин мэргэжлийн хяналт дээр байгуулагдсан шинжилгээний лабораторийн хүчин чадал, тоног төхөөрөмж өөрөө орчин үеийн чанар шаардлагатай стандарт хангахгүй байгаа. Тэгэхээр бид бол дараа 7 хоногт бол энэ лабораторийн үйл ажиллагаатай танилцаж дүгнэлт гаргая гэж зорьж байна.

Хоёрт бол олон улсын хэд хэдэн байгууллагууд руу энэ хамгийн өргөн хэрэглэгдэж байгаа эмүүдээс сонгож

аваад лабораторид шинжлүүлнэ. Ингээд дүгнэлтийг гаргаад үнэхээр концентрац нь муу байгаа, үйлдвэрлэлийн шаардлага хангаагүй эм үйлдвэрлэж байгаа, эсвэл одоо ханган нийлүүлж байгаа компаниуд байвал шаардлагатай арга хэмжээг авна. Ингээд ер нь бол цаашидаа эмийн жагсаалтаа шинэчлэх, дээрээс нь одоо энэ цахим эмийн бүртгэлийг хийж, орчин үеийн технологид суурилсан бүртгэлийг хийх гэсэн ийм хэд хэдэн зорилтыг дэвшүүлж байгаа. Тэгээд Эрүүл мэндийн сайдтай бол бас хамтраад бид бас энэ Эмийн түр хороогоор дамжуулж бас ажиллаж байна. Тэгэхээр цаашидаа одоо бид энэ ямар арга хэмжээ авбал бас зохистой байгаа вэ? Түр хороотойгоо гэдэг талаар бас ЭМЯ-ныхан хэлэх нь зөв байх.

Т.Аюурсайхан: Энхболд сайдад микрофон өгье. 81 дүгээр микрофон.

С.Энхболд: Учрал гишүүн, сайд бас зарим асуудлуудыг хэллээ. Эмийн чанар гэхэд маш олон хүчин зүйл нөлөөлдөг. Мэдээж судалгаа хөгжүүлэлтээс эхлээд эцсийн хэрэглэгч хүртэл маш олон хүчин зүйл бол эмийн чанарт нөлөөлдөг. Тийм учраас бид бүхэн бас энэ хадгалалт тээвэрлэлт, энэ дээр бол нэлээн зохицуулалтуудыг хийж байгаа. Ялангуяа манай улсын 79 орчим хувийг бол нийт зах зээлийнхээ эмийн 79 хувийг импортоор авдаг, үлдсэн 21 хувийг бол дотоодын одоо эм ханган нийлүүлэх үйлдвэрлэлүүд бол хангадаг. Тийм учраас бид нар ядаж гаднаас орж ирж байгаа эмийн энэ чанар шалгахын тулд эхний ээлжид бол лаборатори бол зайлшгүй олон улсын стандартад нийцсэн тийм лабораторитой байх ёстой.

Бид нар энэ лаборатори дээр бас судалгаа, ямар хэмжээний төсөв мөнгө шаардлагатай, ямар, ямар багаж, тоног төхөөрөмж шаардлагатай бүх судалгааг бол гаргасан. Нийтдээ энэ лабораторийг шинэчлэхийн тулд бол 5.3 тэрбум төгрөгийн төсөв шаардлагатай. Ингэсэн тохиолдолд бид нар одоо гаднаас орж

ирж байгаа, импортоор орж ирж байгаа эмийг бол өөрийн орны нөхцөлд, яг олон улсын түвшинд хяналтыг хийх ийм боломж бололцоо бүрдэнэ гэж үзэж байгаа юм. Энэ дээр бол бид нар Эмийн хяналтын түр хороон дээр бол энэ танилцуулгуудыг хийж бас дэлгэрэнгүй мэдээллүүдийг бол гишүүдэд бас зарим гишүүдэд өгсөн байгаа. Тийм учраас бид бүхэн эхний ээжид бол энэ лабораторийн чадавхыг дээшлүүлэх, дараа нь энэ хадгалалт тээвэрлэлттэй холбоотой стандарт дүрэм, дүрэм журмыг бол шинэчлэх ажлын хэсэг гарсан байгаа.

Мөн дээрээс нь, ялангуяа энэ манай улсад бүртгэлтэй байгаа 4310 эм олон улсын нэршилээр бүртгэлтэй байгаа. Энэ дээр одоо ер нь бүртгэлийн ажлыг бол цахимжуулах ажлыг бол бас дэд ажлын хэсэг гарсан. Энэ дээр бас энэ ажлын хэсгүүд маань бас үе шаттай ажлууд хийгдэж байгаа гэдгийг бас мэдээлэл өгье.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг асуулт асууна.

Ё.Баатарбилэг: ЭМЯ-ны удирдлагууд, холбогдох албан тушаалтнууд байгаа болохоор энэ ЭМД-ын сан, Эрүүл мэндийг дэмжих сантай холбоотой ганц 2 зүйл тодруулж асууя. ЭМД-ын сангаас энэ одоо иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх, нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамир гэдэг агуулгаар бас энэ бялдаржуулах клуб, фитнесээр хичээллэж байгаа хүмүүст ЭМД-аас хөнгөлөлт үзүүлэх энэ асуудал 2, 3 жил ингэж яригдаж байгаад ноднин жил Төсвийн хууль, төсөв дагасан хуулиар ингээд даатгалын сангаас бол санхүүжих боломжгүй гэдэг ийм юм явчихсан юм байгаа юм. Иргэд өөрсдийнхөө эрүүл мэндэд анхаараад ингээд ЭМД-аа төлөөд явж байгаа энэ дунд насны залуучууд, энэ дунд насны хүмүүс бол одоо маш их энэ фитнесээр хичээллэдэг юм байна, эрүүл мэнддээ анхаарч.

Тэгж байтал энэ дээр нь энэ ямар нэгэн хөнгөлөлт, урамшуулал байдаггүй. Ингээд 10, 20 жил ЭМД төлөөд яваад байдаг. Тэгж байтал эрүүл мэнддээ анхаараад ингээд яваад байгаа хүмүүсийнхээ энэ төрөөс одоо урамшууллын юм байдаггүй, дэмжлэг байдаггүй гэдэг юм л яригдаад байгаа юм л даа. Тэгээд тийм агуулгаар өмнө нь нэг тийм зохицуулалт хийчихсэн явж байгаад ингээд сая төсвийн тодотгол, хууль юмнуудаар ингээд цуцлагдчихсан. Тэгэхээр энэ хөдөө орон нутагт, ялангуяа энэ биеийн тамир спортоор хичээллэх гэж байгаа энэ бялдаржуулах клуб байдаг юм уу, энэ фитнес клубүүдэд хичээллэж байгаа иргэдэд эрүүл мэнддээ анхаарч байгаа энэ иргэдэд одоо энэ Эрүүл мэндийг дэмжих сангаасаа ер нь тодорхой хэмжээний энэ тэр клубүүдэд нь юм уу дэмжлэг урамшуулал өгөх талын юмнууд явбал яадаг юм бэ? Энэ дээр энэ Эрүүл мэндийг дэмжих сангийн тэр санхүүжүүлэх журам энэ тэрд нь өөрчлөлт оруулаад, ингэвэл явбал яадаг юм гэдэг ийм л юм, ийм л арга замыг хайж байна л даа бид нар.

Яагаад гэвэл энэ танай эрүүл мэндийг дэмжих сангийн одоо сүүлийн жилүүд дэх санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр юмнууд дотор чинь нийтийн биеийн тамир, нийтийн биеийн тамирыг дэмжсэн бялдаржуулах юу, тэр эрүүл мэнддээ анхаарсан, дасгал хөдөлгөөнийг ингэсэн гээд нэг ийм төслүүд хэрэгжүүлсэн юмнууд байгаа юм байна лээ. Нөгөө талаараа Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүү, хөрөнгө бүрдүүлэлт чинь бол энэ архи согтууруулах ундаа, тамхины онцгой албан татварын тодорхой хувиар санхүүжиж байгаа шүү дээ. Тэгэхээр энийг бол одоо онцгой албан татвар нэмэгдэж байгаа. Танай эрүүл мэндийн хөгжлийн сангийн санхүүжилт нэмэгдэнэ. Тэгэхээр энэний тодорхой хувийг нь одоо энэ Биеийн тамир, спорт хариуцсан сайдтай хамтраад Эрүүл мэндийн сайд, Спорт хариуцсан сайд 2

одоо нэг хамтарсан журмаар тодорхой хувийг нь энэ нийтийн биеийн тамир тал руу нь ингэж яах төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх тал руу нь ингэж журам, зохицуулалт хийгээд ингээд явбал яадаг юм гэдэг ийм зүйлийг одоо яамны удирдлагууд байгаа болохоор энэ тал дээр ямархуу байр суурьтай байна вэ? Нийгмийн эрүүл мэнд гээд, нийтийн биеийн тамир гэдэг тал дээр нь.

Т.Аюурсайхан: 81 дүгээр микрофон дээр Энхболд сайд хариулъя.

С.Энхболд: Баатарбилэг гишүүний асуултад хариулъя. Өмнө нь бол 20 оны 8 сараас өмнө бол энэ бол хуульд байсан. Энэ 20 оны 8 сарын 28-ны төсөв дагасан хуулиар бол хасагдсан. ЭМД-ын тухай хуульд ЭМД-ын санг эмнэлгийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байгууллагуудаас бид нар санхүүжилтийг олгоно гэж заасан байдаг. Тийм учраас бол энэ бол ямар нэгэн одоо биеийн тамир, бизнес клубт юун дээр бол тийм хуулиар бол байхгүй заалт. Мэдээж Эрүүл мэндийн дэмжих сан гэж байдаг. Жил болгон бол гурван тэрбум төгрөг төсөвлөгддөг. 23 оны төсөв дээр бол энэ төсөв бол бас тодорхой хувиар бас багасаж батлагдсан байгаа. Бид нар мэдээж, улс орны эдийн засгийн байдал энэтэй уялдаад бол, мэдээж энэ юуг бол эхний ээлжид бол бид нар энүүгээр орсон. Тэгэхдээ цаашид бол Эрүүл мэндийн дэмжих сангийн энэ төсвийг бол бид нар нэмэгдүүлэх ийм бодолтой байгаа. Ингэсэн тохиолдолд бид нар мэдээж энэ хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө одоо яг энэ нийтийн эрүүл мэндийн боловсрол олгох, энэ чиглэлээр хичээллэж байгаа, ялангуяа өөрийнхөө эрүүл мэндийн төлөө одоо өвдөхгүй байх энэ чиглэл рүү бол бид нар мэдээж энэ дэмжих санг бол зарцуулахад бол боломж бололцоо байна гэж харж байгаа.

Цаашид мэдээж энэ улс орны эдийн засгийн байдал бас сайжрах юм

бол бид нар мэдээж энэ чиглэл рүү бол хамтран ажиллаад, эндээс бас тодорхой хувийг бол зарцуулах тийм дүрэм журамд бол өөрчлөлт ороод зохицуулаад явах бүрэн бололцоо байгаа гэж үзэж байгаа.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа асуулт асууна.

Б.Жаргалмаа: Баярлалаа, өдрийн мэнд хүргэе. Сая бас Амарбаясгалан сайдын хамтаар хөгжлийн бэрхиээлтэй, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхиээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн төлөөлөлтэй уулзчихаад ирлээ. Эцэг эхчүүд болохоор маш олон зүйлийг шаардаж байна. Засгийн газрын тэмдэглэлд дурдсан ажлуудаас бас нэг 25 хувийн гүйцэтгэлтэй явж байна гэдэг ийм шүүмжлэлийг бас хэлж байна. Жишээ нь одоо седуксин гэдэг юм тасарчхаад байгаа. Хөгжлийн бэрхиээлтэй хүүхдүүд одоо болтол 70 хувийн хөнгөлөлтөөр эм олгогдож байгаа. Уг нь Засгийн газраас зуун хувийн хөнгөлөлтэй олгоё гэсэн ийм шийдвэр гарсан боловч өнөөдрийг хүртэл эм нь зуун хувиар олгогдохгүй, 70 хувиар олгогдож байна гэдэг ийм зүйлийг хэлж байна.

Эмд дасал болсон хүүхдүүд олон төрлийн эм уудаг. Эмүүд нь хангалттай биш байна. Нэг удаагийн лицензээр оруулж ирдэг ч улсын бүртгэлд бүртгэгдээгүй эмүүд маш ихээр байна. Одоо жишээ нь эпилепси гэдэг эм ашиг өгдөггүй учраас оруулж ирэхгүй гэдэг энэ эмийн компаниуд нь оруулж ирдэггүй гэдэг ийм шүүмжлэлүүд байна. Энэ бүхэн дээр ямар арга хэмжээ авах вэ, энэ асуудал дээр ЭМЯ тодорхой арга хэмжээ яаралтай авч өгөөч гэдэг энэ зүйлийг бас эцэг, эхчүүдийн маань төлөөлөл бас хэлж байна. Энэ дээр хариу өгөөч.

Нөгөөтээгүүр, эмийн чанарын асуудал, эмийн үнийн асуудал олон эмийн компаниудаас зөрүүтэй эм өгдөг. Одоо хөгжлийн бэрхиээлтэй хүүхдүүд

таталт уналтын эсрэг олон улсын нэршилээрээ 25, худалдааны нэртэй 76 төрлийн эмийг уг нь 70 хувийн хөнгөлөлт авах ёстой байдаг юм байна. Гэтэл одоо эмээ авч чадахаа больчихсон ийм зүйлийг хэлж байна. Бас нэг зүйл хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийн тоо өдрөөс жилээс жилд нэмэгдэж байгаа гэдэг ийм мэдээлэл байна. Зөвхөн СХД гэхэд өнөөдрийн байдлаар 1012 хүүхэд одоо хөгжлийн бэрхиээлтэй, саажилтай таталт уналттай гэдэг ийм тоон мэдээ байна. Хан-Уул дүүрэгт өнгөрсөн жил 20 оныг 21 онтой харьцуулсан юм надад ийм л тоо ирлээ л дээ. Нийтдээ 24, 34 хүүхдээр нэмэгдсэн ийм судалгаа байна. Ийм тархины саажилт, тархины эмгэг, шаралтаас үүдсэн тархины саажилт гэсэн ийм өвчлөлүүд ингээд нэмэгдээд байгаа энэ цаг чид бид ургийн шатанд нь энэ бүхнийг оношлох, илрүүлэх, оношилгоогоо нэмэгдүүлэх, эрчимжүүлэх зайлиггүй шаардлага үүсээд байна. Энэ дээр уг нь төсөв яригдахтай зэрэгцээд л хэлсэн. ЭХЭМҮТ дээр ганицхан ургийн оношилгоо хийгдэж байгаа. Энийг нэмэгдүүлэх тал дээр ямар арга хэмжээ авах вэ? Ядаж эцэг эхчүүд маань хэвлийдээ ураг тээсэн энэ цаг мөчөөсөө эхлүүлээд ургийн гажгийг оршуулах, энэ оношилгоонд оролцдог, ордог байх энэ боломжийг нээж өгөхийн тулд ер нь яах ёстой юм бэ? Энэ дээр ЭМЯ ямар бодлого барьж ажиллаж байна вэ гэдэг дээр мэдээлэл өгөөч.

Тоо нэмэгдээд байна, тийм ээ. Тэгэхээр энэ дээр. Төрсний дараа илрүүлэх биш. Бас Энэрэлийн туужаа ТББ, Швейцарын мэргэжилтнүүдтэй нийлээд оношилгоог эрт илрүүлэх аппликейшн бүтээсэн байна. Швейцар мэргэжилтнүүдийн зөвлөмжтэйгөөр, зөвлөгөөгөөр. Энэ аппликейшнийг зарим газарт ашиглаж байна өөрсдөө. Оношилгоо зөв явагдаж байна гэж байна, энийг амьдралд нэвтрүүлэх тэр боломж байхгүй юу? Энэ дээр ЭМЯ ямар арга хэмжээ авч байна вэ? Баярлалаа.

Т.Аюурсайхан: Энхболд сайд хариулъя 81 дээр.

С.Энхболд: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Би зарим мэдээлэл өгөөд манай холбогдох газрын мэргэжилтнүүд бас дарга нар зарим эмийн тасалдалтай холбоотой мэдээллүүдийг өгөх байх. Бид нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 0-18 насны хүүхдийн юмыг бол ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 7 дугаар сард болсон хуралдаанаар төрөөс зуун хувь даана гэдэг шийдвэрийг бол гаргасан. Таны саяын хэлдгээр нийтдээ 24 нэр төрлийн эм байгаа. Энэ эм дээр бид нар хамгийн гол нь бас манай улс эм бүртгэж авах тодорхой журмаар зохицуулагддаг. Бид нар ер нь ерөнхий нэршилээр нь бол бүх эмийг бол зуун хувь олгоно гээд заасан. Манай энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бас төлөөлөл, төрийн бус байгууллагууд бидэнтэй хэд хэдэн удаа уулзсан байгаа.

Тэр зарим эцэг эхчүүдээс өгч байгаа эм нь өөрөө Солонгос Улсын эмийг хэрэглэнэ гээд. Тэр нь хамгийн гол нь тэр эмийг бид нар манай улсын аль нэг эм ханган нийлүүлэх байгууллага заавал тэр Солонгос Улсад үйлдвэрлэгдсэн үйлдвэрийн газартай гэрээ хийгээд, манай улсад бүртгүүлэх ёстой. Энэ зохицуулалтыг нь бол бид нар нээлттэй орхиж байгаа юм. Энэ хамаа байхгүй одоо аль нэг эм ханган нийлүүлэх байгууллага оруулаад ирэх юм бол бид нар энийг нь бүртгээд өгье. Бусад өөр нэршилээрээ, олон улсынх нь нэршилээр энэ эмүүд нь бол манай улсад ороод ирчихсэн байгаа юм. Эдгээр эмүүд нь бол зуун хувь хөнгөлөгдөж байгаа.

Дараагийн тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн маань тавиад байгаа энэ бас нэг санал байгаа. Бид нар энэ тусламж үйлчилгээ дээр нь бас нэлээн дэвшилүүдийг гаргахаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа. Бид нар бас энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүүхдүүдийн бас

тэр ризотомид хагалгааг эхлүүлсэн. Сая эхний нэг 5 хүүхдэд бол хагалгаа хийгдсэн. Дараагийн ээлжид ингээд үе шаттай ирж, энэ хагалгаануудыг энэ ондоо бол бид нар нэг 15-20 хүүхдэд хийхээр төлөвлөсөн байгаа. Тэгээд дараагийн жилээс эхлээд манай улсын өөрсдийн эмч нар маань бас гадагшаа сургалтад хамрагдаж байгаа. Мөн энэ дотооддоо бас энэ эмч нарын багтай хамтарсан хагалгаануудыг хийж байгаа. Тийм учраас дараа жилээс бол манай улсын энэ мэдрэлийн мэсийн эмч нар бол энэ хагалгааг өөрсдөө өөрийн улсдаа хийхэд бол бүрэн боломж бололцоо нээгдсэн.

Дараагийн энэ яагаад энэ тархины саажилттай хүүхдүүд төрөөд байгаа энэ бол маш олон хүчин зүйл нөлөөлдөг. Мэдээж хамгийн эхний оношилгоо бол мэдээж эхийн хэвлийд байхад нь бид нар шинжлэх ёстой. Тийм ч учраас бид нар 21 оны бас төсвийн тодотголоор ЭМД эрүүл мэндийн салбарт бас тодотгол хийсэн. Энэ тодотголын хүрээнд бид нар бас энэ лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор 3 эмнэлэг дээр энэ лабораторийн тоног төхөөрөмжүүдийг бол авч суурилуулсан. Одоогийн байдлаар эрүүл мэндийн Эх хүүхэд, эрүүл мэндийн үндэсний төв дээр энчээ сургалт юу сургалтын ажлууд чадавхжуулах, ер нь хүний нөөцөө бэлтгэх ажлууд хийгдэж байна. Эх нярайн эмэгтэйчүүдийн үндэсний төв дээр энэ лабораторийн тоног төхөөрөмж бол эхнээсээ суурилагаад эхэлсэн. Мөн Хүрээ амаржих газар дээр бас энэ лабораторийн тоног төхөөрөмжүүд маань суурилагд эхэлчихсэн байгаа.

Тийм учраас бид нар энэ ондоо багтаагаад ямар ч байсан энэ ажлуудыг бол хийлгээд ганцхан Эх нялхсын үндэсний төв дээр хийх биш, өөр 3, 4 эмнэлэг дээр хийх ийм бололцоог бол хангачихсан байгаа. Тийм учраас энэ оношилгоо шинжилгээнүүд цаашаа

ингээд хийгдээд явна гэсэн. Тэр седуксин дээр Төрийн нарийн.

Т.Аюурсайхан: 80 дугаар микрофон өгье, ажлын хэсэг нэмж хариулъя.

Ц.Эрдэмбилэг: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Эрдэмбилэг. Седуксин буюу диазепам эмийн тасалдлын талаар эхлээд хариулъя. Монгол Улс бол ерөнхийдөө диазепам нийтдээ жилийн хэрэгцээ нь бол 120 орчим мянган ампул диазепам хэрэглэдэг. Үүнээс бол 50, 50 хувийг нь буюу одоо 61500 орчмыг нь бол манай Монголын Айвико үйлдвэр үлдсэн, одоо жар орчим мянган ампулыг нь бол Славений Кирка үйлдвэрээс Монос, МЕК, Азифарм импортолж оруулж ирдэг байгаа. Сая асуусан энэ тасалдалтай холбоотой асуудлын хувьд бол Айвико үйлдвэр энэ диазепам үйлдвэрлэдэг эмийнхээ түүхий эдийг бол 2021 оны 8 сард бүртгэлийнх нь хугацаа дууссан байсныг сунгуулаагүй байсан. Тэгээд энэнээс болоод бол үйлдвэрлэл түр одоо тасалдал үүсэх ийм болсон, эрсдэл гарсан. Энийг нь бол 2022 оны 10 сарын 07-ны өдөр Хүний нийгмийн зөвлөлийн 12 дугаар хурлаар энэ түүхий эдийнх нь бүртгэлийн хугацааг сунгасан. Ингээд сунгаснаар бол Айвико үйлдвэр маань бол диазепам үйлдвэрлээд эхэлсэн байна.

2022 оны 10 сарын 11-ний өдөр бол нийтдээ 32000 ампулыг үйлдвэрлээд, өнөөдрөөс эхлээд бол энэ хангалтууд нь бол явагдаж байна. Тэгэхээр энэ тасалдын асуудал бол бүрэн шийдэгдсэн байгаа. Ер нь энэ одоо уналт таталттай хүүхдүүдийн эм ч юм уу, эсвэл энэ Монгол Улсад энэ цөөн зарагддаг, ховор тохиолддог өвчин эмгэгийг эмчлэх энэ зайлшгүй шаардлагатай эмийн хувьд бол энэ эрүүл мэндийн ноцтой байдлын үед шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, түүний дагалдах хэрэгслийн худалдан авалт, ханган нийлүүлэлт бол

энэ гамшигийн үед бол их чухал гэдэг нь бол харагдаж байна. Манай эм ханган нийлүүлэх үйлдвэрүүд бол зуун хувь хувийн хэвшлийн.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен асуулт асууна.

Б.Бейсен: Би эмч хүний хувьд бас Эм, эмнэлгийн хэрэгслийг хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллаж байгаагийн хувьд хэд хэдэн асуулт тавья гэж бодож байна. Эм бол яах вэ онцгой бүтээгдэхүүн, бас улсын аюулгүй байдалтай ч холбоотой. Тийм учраас төрөөс эмийг маш сайн бүртгэлтэй байлгаж чадвал хяналт сайн тавих боломжтой л доо. Гэтэл манай улсын эмийг олон улсын нэршилээр бүртгэхгүй, худалдааны нэршилээр бүртгэж байгаа л даа. Тэгээд 10-20 төрлийн нэршилээр бүртгээд, тэгээд олон эм орж ирж байгаа юм шиг харагддаг. Энийг одоо олон улсын нэршилээр бүртгэхэд одоо ямар бэрхшээл байна вэ энэ талаар бас асууя.

Хоёр дахь асуудал энэ аудитын дүгнэлт, дүгнэлтийн талаар салбарын тогтвортой хөгжлийг хангасан систем бүрдээгүй, бодлогын хувьд залгамж чанар алдагдсанаас үүдэн төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаагүй, үр дүнг үнэлээгүй байна. Мөн хүн амыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр жигд хүртээмжтэй хангах, ил тод дүн шинжилгээнд суурилсан хяналтын тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна гэж Аудитын газраас дүгнэлт гарсан байдаг. Энэ та бүгд бас дүгнэлтэд очсон байх. Энэ талаар одоо ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ?

Гуравдугаарт энэ ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу эмийн зохицуулалтын байгууллагын чадамжид 2 жил тутам одоо үнэлгээ хийж байх ёстой баталгаажуулж, эмийн бүртгэлд тусгай

зөвшөөрөл олголтыг шалгаж байх ёстой. Энэ талаар ямар ажил хийж байна вэ?

Дараа нь энэ эмийн үнийн талаар асууя гэж бодож байна. Энэ хэрэглэгчээс үйлдвэрлэгчээс одоо хэрэглэгчид хүртэл одоо түрүүн би бас юундаа танилцуулсан. Сангийн сайд бас ойлгоогүй тэрэн дээр. Одоо тээврийн даатгал дээр 5-8 хувь, гаалийн НӨАТ дээр 15.5 хувь, ханган нийлүүлэлт барилгын нэмэгдэл 15-45 хувь, борлуулалтын НӨАТ 10 хувь, эмийн сангийн нэмэгдэл 25-35, борлуулалтын НӨАТ 10 хувь гээд ингээд Эм, эмнэлгийн хэрэгслийн газар түрүүн гаргаж өгсөн л дөө. Тэгэхээр чинь ийм олон НӨАТ тэгээд энэтэй холбоотой бас эмийн үнэ нэмэгдээд байна л даа. Энэ талаар одоо дүн шинжилгээ хийсэн үү? Аль эсвэл Эм, эмнэлгийн хэрэгслийн газар буруу юм гаргаж өгч байна уу? Энэ талаар асууя.

Эмийн үйлдвэрийн талаар асууя дараа нь. Дотоодын эм үйлдвэрийн нэмэгдэл 41-98 хувь, импортоос эмийн хувьд гарал үүсэл бас хамаарна, 60-238 хувь нэмэгдэж байна гэсэн ийм юм гаргаж өгсөн л дөө Эм, эмнэлгийн хэрэгслийн газар.../минут дуусав/

Т.Аюурсайхан: 80 дугаар микрофон дээр ажлын хэсэг хариулъя.

Ц.Эрдэмбилэг: Бейсен гишүүний асуултад хариулъя, ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга. Бүртгэлийн хувьд бол манай улс бол ер нь эмийн бүртгэлийн энэ хатуу зохицуулалттай, зохицуулалттай орны энэ жишгийн дагуу эмийн бүртгэлийн журам маань бол боловсруулагдсан байдаг. Бид бүхэн бас түрүүн хэлсэн, дотооддоо бас эмийн чанарыг төдийлөн одоо олон улсын түвшинд лаборатори, хүчин чадал маань одоо хэмжээнд очоогүй байгаа учраас бид бүхэн энэ гаднаас оруулж ирж бүртгүүлэхээр орж ирж байгаа эм дээр бол яг хатуу зохицуулалттай оронтой адилхнаар бүртгэлийн журмаа бол боловсруулан мөрдөн ажиллаж байгаа.

Энэ журмын дагуу бол эм ханган нийлүүлэх байгууллагууд маань өөрсдөө одоо бүртгүүлэхийг өөрсдөө хүссэн эмийг нь бол бид нар шинжээч нар томилуулаад бичиг баримт дээр нь анализ хийж ингэж бүртгэдэг ийм журамтай байгаа.

Тэгэхээр сая гишүүн асуулаа. Олон улсын нэршилээр гэж. Тэгэхээр тухайн эмийг нэг эмийг бол маш олон эмийн үйлдвэрүүд дээр олон янзын оронд үйлдвэрлэдэг байгаа. Тэгэхээр манай журмаар бол энэ эмийн үйлдвэр, улс орон болгоных нь онцлогт нь тус бүрээр нь бүртгэдэг ийм журамтай байгаа. Тэгэхээр ерөнхий нэршилээр бүртгэчихдэг, дараа нь одоо тухайн жишээлбэл Швейцарын Новартис компанийн үйлдвэрлэсэн эм гэх юм бол энэ бол яг энэ эмд энэ оронд үйлдвэрлэсэн гэдгээр нь бүртгэх ёстой, ийм журамтай байгаа. Тэгэхээр брэнд нэрээр хүсэлтээ тавих юм бол бид нар бас л брэнд нэрээр нь бүртгэдэг ийм журамтай байгаа. Тэгэхээр ерөнхий нэршилээр бүртгэчихээр дараа нь хил дээр брэнд буюу худалдааны нэршилээр орж ирэх юм бол энэ маань өөрөө манай улсад хэрэглэж болохгүй ийм одоо гаалийн татварын ийм зохицуулалттай байдаг байгаа.

Т.Аюурсайхан: Бейсен гишүүнд микрофон өгье.

Б.Бейсен: Энэ эмийн үйлдвэр гэхэд 7 эмийн үйлдвэр байна л даа. Дотоодын эмийн үйлдвэр 21 хувь хангаж байна, 79 хувийг одоо импортоор авч байна гээд. Энэ эмийн үйлдвэрийг одоо хүчин чадлыг нэмэгдүүлэх, дотооддоо эм үйлдвэрлэл ядахдаа нэг 50-иас дээш хувь хүрэх одоо стратеги төлөвлөгөө байна уу? Нөгөө талаар вакцины хүндрэл үү, эмийн хүндрэл үү, тэр өвчний юу байна уу залуу улсууд бол одоо эндэж байна. Одоо инфракт, цус харвалт энэ дээр одоо дүн шинжилгээ хийж судалгаа байна уу? Нөгөө талаар эмийн үйлдвэрийг хүчин чадлыг нэмэгдүүлэх, дотооддоо шинжилгээ хийх талаар

төлөвлөгөө, стратеги юу байна вэ? Энэ талаар асууя.

Т.Аюурсайхан: Ажлын хэсэг 80 дээр гүйцээж хариулъя.

Ц.Эрдэмбилэг: ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн Эрдэмбилэг. Бейсен гишүүний асуултад хариулъя. Эмийн GMP хангасан үйлдвэрүүдийн хувьд бол төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд бол бид бүхэн бол хамтарч ажиллаж байгаа. Бүхий л талаар энэ бол нээлттэй. Энэ Монгол Улсад GMP хангасан үйлдвэрийг аль болох олон болгох тал дээр бол бид бүхэн бол хамтарч ажиллаж байгаа. Энэ бол ямар нэгэн төр засгаас бол одоо саад тотгор бол байхгүй. Бид нар эм одоо үйлдвэрлэгч нартайгаа тогтмол уулзаж, тулгарч байгаа асуудлуудыг нь шуурхай, шуурхай шийдвэрлэж өнөөдрийг хүртэл явж байгаа.

Бид бүгдийн зорилго бол Монгол Улсад үйлдвэрлэж байгаа эмийн үйлдвэр болгоныг GMP олон улсын энэ стандартыг хангуулахын төлөө ажиллаж байгаа. Тийм.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адъяасүрэн асуулт асууна.

А.Адъяасүрэн: Туваан гишүүн маш тодорхой 4 асуултыг асууж гэж би харж байна. Гэтэл одоо хариу нь болохоор тэгж байна, ингэж байна гээд л баахан тоо баримт л одоо тавьж, тэгээд чухам юу хийж байгаа нь ч одоо бас тодорхой харагдахгүй байна. Ингээд би бас хэдэн асуултыг асууя. Хамгийн эхэнд нь энэ өнчин эм, уламжлалтын эм яагаад хөнгөлөлттэй эмийн жагсаалтад ордоггүй байгаа юм бэ?

Хоёрт нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хуралд өргөн барьж байсан шиг бас санагдах юм. Яагаад энэ хууль одоо ямархуу

түвшиндээ явж байна вэ? Энэ талаар тодруулга авах гэсэн юм.

Гуравдугаарт нь уламжлалт эмийн тухайд амьдралд тулгамдсан олон асуудлыг жагсаасан мөртөө ямар арга хэмжээгээ авч байгаа талаар юу ч дурдсангүй сая сайдын мэдээлэлд. Ер нь одоо энэ уламжлалт эмийн тухайд гэх юм бол Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яам гэсэн 3 яамны хараат ажиллаж байгаа. Төрөөс одоо ямар ч дэмжлэг байхгүй. Харин ч одоо хааж боосон баахан дүрэм журмаар дарамтлахаас цаашигүй байна гэж одоо хүмүүсээс нь гомдол ирдэг. Жишээлбэл ховор ховордсон эмийн ургамлыг тарималжуулах, байгалийн эмийн ургамлыг ашиглах, эмээ улсын бүртгэлд бүртгүүлэх сунгахад маш их хүнд болсон гэж байгаа юм. 2018 оноос хойш нэг эмийн бүртгэлийг сунгуулахад 250000 төгрөг төлдөг, одоо бол 300000 төгрөг болох гэж байна гээд л бас хүмүүсийн гомдлууд ирээд байдаг. Тэгэхээр одоо энэ Монголд одоо хашаандаа ховордсон эмийн ургамал тариалдаг зуу гаруй өрх айл байдаг гэсэн энэ мэдээлэл байна. Хэрэв нэг өрхийг 2 эмийн ургамлыг тарималжуул гээд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлчих юм бол 5 жилийн дараа 200 ховордсон эмийн ургамалтай болчих бололцоо байна гэж бас эмч судлаачид ярьж байна.

Тэгэхээр эдгээр асуудалд холбогдох яам ямар бодлого одоо баримталж ажиллаж байна вэ? Хамгийн сүүлд нь одоо дараагийн нэг чухал асуудал бол Хүнс, эмийн агентлагийн тухай асуудал байдаг. Энэ бол угаасаа дэлхийн жишиг. Тэгээд үүнийг 2008 оноос эхлээд одоо байгуулах тухай асуудлыг бол ярьж эхэлж байсан юм байна лээ. Тэгээд энэ 2-ыг нэг дор агентлаг болгоод нэг яам хариуцаад ажилладаг болчихвол бодлогын хувьд маш чухал ач холбогдолтой. Тэгээд үүн дээр бас ЭМЯ-наас ямар байр суурийг одоо баримталж ажиллаж байна вэ?

Энэ 4 асуултад бас тодорхой хариултыг авъя.

Т.Аюурсайхан: 82 дээр Бямбасүрэн дарга.

Л.Бямбасүрэн: Адъяасүрэн гишүүний асуултад хариулъя. Өнчин эм гэдэг маань олон улсын ангилал энэ байдаггүй. Яах вэ улс орнуудад цөөн тохиолддог өвчнүүдийн үед хэрэглэгддэг ийм эмүүд ордог. Энэ ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолд р... гэдэг нэг эм бол өнчин эмийн жагсаалтад энэ эм бол энэ хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орсон байгаа, 70 хувийн хөнгөлөлттэй явдаг. Хөнгөлөлттэй эмийн нэр төрлийг одоо тогтоохдоо бид нар олон улсын эмнэл зүйн удирдамжид заасан эмүүдийг оруулж хөнгөлөлт тогтоох аргачлалыг баталсан байдаг. Энэ дээр бол одоо иргэдийг удаан хугацаанд санхүүгийн эрсдэлд оруулдаг эсэхийг нь тодорхойлно. Амбулаториор эмчлэх боломжтой өвчин эмгэг эсэх, олон улсын эмнэл зүйн удирдамжид заасан нотолгоотой эсэх зэргийг одоо үндэслэж ийм аргачлалын дагуу хөнгөлөлттэй эмийн жагсаалтад оруулдаг.

Мөн Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн зайлиггүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон ийм эмүүдийг бол хөнгөлөлттэй эмийн жагсаалтад оруулдаг. Өнөөдрийн байдлаар уламжлалтын эмүүд бол одоо зайлиггүй шаардлагатай эмийн жагсаалтад ороогүй байгаа. Хараахан ороогүй байгаа. Нэгдүгээр асуултад хариуллаа.

Т.Аюурсайхан: 83 дугаар микрофон өгье.

Б.Буянтогтох: ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Буянтогтох. Адъяасүрэн гишүүний асуултад хариулъя. Эмийн хуулийн тухай асуудал. Эмийн хууль бол 2019 онд анх өргөн баригдсан. Тэр үед бол Засагт өргөн бариад, Засаг

дээр Их Хурал дээр бас ажлын хэсэг гараад ажилласан. Энэ хугацаанд бол анх өргөн барьсан үзэл баримтлал маань нэлээн өөрчлөгдөөд 33 хуудас саналын зөрүүтэй ийм томъёолол үүссэн. Ингээд Улсын Их Хурал дээр байсан ажлын хэсгийнхэнтэй ЭМЯ сайд маань ярилцаад эргээд одоо эргэн татаж авъя гээд татаж авсан байгаа. Тэгээд дахиад одоо бол ажлын хэсэг байгуулагдаад үзэл баримт, хуулийн одоо хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ дээрээ суугаад дуусан. Одоо үзэл баримтлалаа батлуулахаар шатандаа явж байна. Удахгүй бас Их Хурал руугаа орж ирнэ.

Гишүүний дараа нь эмийн ургамлын тарималжуулалтыг талаарх асуудлыг би бас мэдээлэл өгье. 2022 оны байдлаар 6 уламжлалт эмийн үйлдвэр яг 34 га газарт 51 нэр төрлийн түүхий эдийг тарималжуулж байгаа. Импортыг орлох мана эмийн ургамлыг сүүлийн 2 жилд энэ Монг-Эм ХК компани бол амжилттай тарималжуулж 3 тонн түүхий эдийг бас бэлтгэж байна. Нийтдээ бол Мамба дацан, Мон-Интра уламжлалт анагаах ухааны технологийн хүрээлэн, Монг-Эм гэх зэрэг одоо компаниуд нийтдээ 34 одоо га газарт бол тарималжуулж байна. 6 сард бол энэ салбар дундын оролцоотой 3 яамны оролцоотой уулзалт бол зохион байгуулсан. Эндээс гарсан санал санаачилгыг одоо шинээр өргөн барих, одоо Эмийн хууль дээрээ бид нар тусгахаар эмийг нь уламжлалт эмийн ажлын хэсэг бүр тусдаа байгуулагдаад, энэ дээр бол хуулийн төсөл дээр ороод ажиллаад явж байгаа гэдгийг хэлье.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан асуулт асууна.

Ц.Туваан: Асуулга асуусан, тэгээд хариултаа авлаа. Тэгээд нэг баахан юмнууд хольж хутгаад л уламжлалынхаа дагуу нэг юм хариулсан болоод л явж байна. Эмийнхээ асуудалд эхлээд оръё. Муу эм хэрэглэвэл бид нар 14 хоног

уугаад ч өвчин эдгэхгүй. Сайн эм хэрэглэвэл 3 хоногийн дотор ч бүрэн эдгэх боломжтой. Энэ бол бодитой асуудал шүү дээ. Монголд одоо анагаах ухааны салбарт зарцуулагдаж байгаа энэ маш их санхүүжилт чинь энэ эмнэлэгт 7 хоногоор хэвтдэг, чанаргүй эмийг удаан уугаад өвчин эдгэдэггүй, ужгирдаг, эдийн засгийн санхүүгийн маш олон асуудлууд чинь энэ муу эмээс болж байгаа шүү дээ. Энийг бид нар одоо ярих цаг нь болсон. Эмийн одоо чанарын асуудлаар түр хороо явж байгаа. Чанартай эм оруулж ирэх сонирхол яамныханд алга байна. Би шулуухан тэгж хэлье. Бүртгэл дээр нь маш өндөр хураамж авч байна.

Сая Адъяасүрэн гишүүд хэлж байна шүү дээ. 250 мянга, 300 мянга гээд. Эмийн хатуу зохицуулалттай орнуудаас оруулж ирж байгаа эмүүд чинь 300 мянгаас одоо бүртгэлийнх нь юм 300 мянга байгаа. Одоо бүр 1,6 сая болгоно гээд ингээд юмнууд явж байна. Энэ ямар учиртай, ямар бодлого юм бэ гэдэг дээр асуулт байна.

Эмийн хөнгөлөлт дээр 226 тэрбум төгрөг зарцуулсан гээд. Энэ аудитын дүгнэлт нь дотор байгаа. Дээрээс нь энэ бол маш их мөнгө. Дээрээс нь энэ орж ирсэн импортын эм чинь 10-82 хувийн өндөр, зарим төрлийн одоо даралт бууруулах эм гэхэд л одоо 5.4-15.6 дахин өндөр гэсэн дүгнэлт мэргэжлийн байгууллага нь гаргаж өгсөн. Энэ үнэн үү? Тэгээд ер нь бол эм одоо эмийн сул зохицуулалттай орнууд энэ зүүн өмнөд Азийн орнуудаас орж ирэх эмийн эм ихсээд байгаа. Хатуу зохицуулалттай эм бүртгүүлэх гэж маш олон хүсэлтүүд ирдэг. Бүртгэдэггүй. Ямар нэгэн журам зохицуулалт яриад л суугаад байдаг. Тэнд бол үнэхээр чанартай сайн юмнууд байдаг. Тухайлбал тэр *Sos medica* дээр хэрэглээ, хүмүүс гишүүнчлэлээрээ хэрэглээд л маш хурдан хугацаанд өвчнөө эдгээгээд гараад байгаа юм. Тэгэхээр энэ дээр чинь ямар бодлого юм бэ?

Тэр хуулийн төсөл. Одоо энэ чинь юу юм бэ? Бид нар Орос, Хятадтай юм уу, Япон, Америктай хэлэлцээр хийх гээгүй шүү дээ. Дотроо байгаа шүү дээ Засгийн газар. Энэ хуулиа хурдан дотор нь суу л даа ажлын хэсэг нь. Маш олон бүх хүний юун дээр гарч байна шүү дээ, энэ зохицуулалт чинь ингээд нэг оруулж ирээд тоглоомтой юм шиг Засаг руу оруулж ирлээ гэнэ, буцаад татлаа л гэнэ. Нэг ороод ирэхээрээ маш олон зарчмын зөрүүтэй саналтай хуулийн төслөрхүү юм оруулаад ирдэг. Тэгээд одоо энэ асуудлууд чинь хэзээ шийдэгдэх юм бэ? Хуулиа хурдан бариач. Нэгдсэн худалдан авалтын тогтолцооны асуудал чинь үнэхээр үр ашигтай шүү дээ. Тэгээд Ремдисивир дээр жишээ аваад л ярьж байсан. Тэр.../минут дуусав/

Т.Аюурсайхан: 80 дугаар микрофон ажлын хэсэг хариулъя.

Ц.Эрдэмбилэг: Туваан гишүүний асуултад хариулъя. ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Эрдэмбилэг. Эмийн бүртгэлийн хувьд бол манай улсад бол гадаад улсад одоо хатуу зохицуулалттай оронд бүртгэлтэй эмийг харин ч манайх бүртгэхдээ бол шууд бүртгэж бүртгэх ийм боломж бол байдаг. Өөрөөр хэлбэл яг тухайн үйлдвэрлэсэн орондоо бүртгэлтэй, тухайн үйлдвэрлэсэн орон нь өөрөө хатуу зохицуулалттай орны эм байх юм бол манай журмаар бол харин ч бүр хурдан бүртгэх ийм боломж бол зохицуулалт бол байгаа.

Хамгийн гол нь энэ бүртгэл дээр бол энэ тухайн одоо бүртгүүлэхээр материал ирүүлж байгаа эм ханган нийлүүлэх байгууллагууд маань өөрсдөө тухайн бүртгэлтэй холбоотой бичиг баримтуудыг нь бол дандаа дутуу байгаагаас л бүртгэл нь бол ингэж сунжирч байгаа юм. Түүнээс бол энэ дээр ямар нэгэн бүртгэхгүй байх тийм зүйл байхгүй. Гэхдээ ер нь бол манай улс маань өөрөө бас энэ лабораторийн хүчин чадал, олон улсын хэмжээний лабораторийн түвшин биш учраас бид

бүхэн бол энэ бичиг баримтын бүртгэл дээр бол гойд анхаарч байгаа. Цаашидаа ч ер нь манай үндэсний аюулгүй байдал учраас эм бол өөрөө та бас хэллээ. Муу эм хор. Тийм учраас чанаргүй эмийг оруулахгүй байхын төлөө бид нар энэ бүртгэлийнхээ журам дээрээ зохицуулалтуудыг нь улам чангаруулна л гэсэн ийм байр суурийг барьж явж байгаа.

Нэгдсэн худалдан авалтын хувьд бол яг одоо энэ асуудал, ялангуяа эм ханган нийлүүлэх байгууллагууд маань бүгд хувийн хэвшлийн байгууллагууд байгаа учраас одоо энэ өнчин эм юм уу, цөөн тоогоор шаардлагатай байдаг. Тэгээд компаниуд болохоор оруулж ирэхээр цөөхөн учраас ашиггүй байгаад байгаа энэ эмүүдийг бол энэ төр засгаас анхаарч, энэ эм ханган нийлүүлэх, худалдан авах ийм байгууллагыг бол бид нар бүхэн байгуулах ёстой юм байна. Тийм учраас одоо Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар ЭМЯ-наас санал оруулан энэ одоо төрөөс одоо ЭМЯ-ны дэргэдэх эм ханган нийлүүлэх ийм тусгай төв УТҮГ байгуулъя гэсэн хүсэлтийг Засгийн газрын хуралдаан дээр танилцуулаад, холбогдох судалгаа шинжилгээнүүдийг бүрдүүлж эргэж танилцуул гэсэн ийм одоо шийдвэрт хүрээд байгаа. Энэ тал дээр бид бүхэн бас судалгаагаа хийгээд явуулж байна.

Бид бүхэн бас ремдисивирийг бас нэгдсэн худалдан авалт хийж байгаад 161 мянган төгрөгийн үнэтэй байсан эмийг бол 38 мянга хүртэл буулгаж ирсэн ийм одоо сайн туршилага байгаа. Тийм учраас энэ чиглэлдээ бол 23 ондоо бид хүн ажиглана.

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн, Содномын Чинзориг, Гочоогийн Ганболд нарын урилгаар Өвөрхангай аймгийн Социал демократ МЗХ-ны тэргүүлэгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та нартаа

ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Туваан гишүүнд микрофон өгье.

Ц.Туваан: Тэр түр хороо дээр ахиж энэ асуудлыг ярина. Сайд ч хэлээд байгаа хатуу эмийн зохицуулалттай орныхыг шууд бүртгэчихдэг л гэнэ. Одоо боломж байгаа, байгаа л гээд байна, тэгээд худлаа яг газар дээрээ байхгүй. Наад чинь янз янзын журам цаас гаргаж ирээд бүртгэдэггүй шүү дээ, битгий ингэж худлаа ярьж бай.

Хоёрдугаарт тэр эмийн бүртгэлийн хураамжид авдаг мөнгөнүүдээ яагаад өсгөөд байгаа юм, юунд зарцуулдаг юм бэ? Энийгээ нэг тодорхой хэлээд өгчих. Тэр сайд хууль удаад байгаа дээр энэ Засгийн газар дотроо ингээд яагаад өдий болтол аль хэзээнээс хойш энэ хууль авлаа барилаа гэснээс хойш хагас жил өнгөрлөө. Яагаад энэ одоо ингээд удаад байгаа юм бэ?

Хоёрдугаарт тэр эцэст нь дээр энэ умайн хүзүүний хорт хавдар одоо сүүлийн үед пневмони буюу пневмококкийн халдвараар маш олон хүн нас барсан шүү дээ бид нар мэдэж байгаа. Сүүлийн 3 жилийн дотор. Энэ тоо бол бараг өндөр гарна шүү. Энэний вакцин гээд дэлхийн шилдэг вакцин.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Энхболд сайд хариулъя.

С.Энхболд: Туваан гишүүний асуултад хариулъя. Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хууль нэрээсээ авхуулаад бас энэ маань өөрчлөгдсөн. Энэ нэг хуулийг анх өргөн барихад Эм, эмнэлгийн хэрэгсэл, хяналт зохицуулалтын газрын агентлаг байгуулагдаагүй байсан нэг шалтгаан нь бас энэ. Дээрээс нь бид нар төрийн өмчит үйлдвэрлэлийн газрыг бас байгуулах саналыг бас оруулж ирж байна. Энэ дээр бас зохицуулалт хийх, хууль дээр бас нэлээн суух ийм ажлууд

байгаа. Бид нар орж энэ хуулийг бол нэг мөсөн бас дахин, дахин буцахааргүй нэг мөсөн бас ажлын хэсгүүдийг нэлээн сайн суулгаж байж нэгдсэн байдлаар аль болох санал, саналын зөрүү бага байхаар оруулж ирэхээр бол төлөвлөн ажиллаж байгаа. Тийм учраас уламжлалтын бүр эм, эмнэлгийн хэрэгслийнх нь тусдаа ажлын хэсэг гаргасан. Энэ мэтчилэн бол бид нар энэ хууль дээр бол нэлээн бас нухацтай хандаж байгаа гэсэн үг. Тийм учраас бид нар аль болох богино хугацаанд энэ ажлын хэсгүүдийг хуралдуулж.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг асуулт асууна.

М.Оюунчимэг: Би болоод мөн Туваан гишүүн бид нарын асуулга тавьсан гол шалтгаан бол энэ эрүүл мэндийн салбарт, тэр дундаа эмийн энэ зах зээлээ бид нар төрийн бодлогоо одоо авч хэрэгжүүлэх, өгсөн үүрэг даалгавруудыг хэрэгжүүлж, яг Монгол хүнээ эрүүл байлгах, тэгээд энд нь бодлогын арга хэмжээгээр тусламж дэмжлэг үзүүлээд ингээд шийдээд явчихъя гэсэн зорилгоор өгсөн. 2018 оноос хойш Монгол энэ Монголд төрийн бодлого эмийн зах зээл дээр байхгүй болчихсон. Бид алдчихсан. Тэгээд төрийн бодлогын энэ эмийн төр эмийн бодлогоо алдсан улмаас энэ зах зээлд мафижсан нэг хэсэг хүн зөвхөн бизнес хийх боломжийг олгоод, энэ өнөөдөр ямар сөрөг үр дүнд хүрснийг бид бүгдээрээ статистик үзүүлэлтийг бүгд яриад л хэлцээсэн.

Тийм учраас 18 онд нэн шаардлагатай бүх хуулийг, жишээ нь Улсын Их Хурал гаргаж өгсөн. Эрүүл мэндийн тухай хууль, ЭМД-ын тухай хууль, энэтэй холбоотой санхүүжилтийг нь хүртэл бид нэмж өгөөд Нийгмийн даатгалын сангаас ЭМД-ын санг хүртэл тусад нь гаргасан. Тэгээд өнөөдөр энд Энхболд сая хэлж байна л даа. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн

төслийг сая гишүүд асууж байхад бид дахин, дахин буцаад байхгүй чанартай юм хийхийн тулд нухацтай авч үзэж байна гэж ойлго гэж та яриад сууж байхаасаа одоо ичих хэрэгтэй л дээ. Энэ хууль дээр бид өмнөх жилүүд ч гэсэн ер нь 16 оноос хойш маш удаан ажилласан. Тэгээд тухайн сайд нар солигдох болгонд ингээд доторх өөрсдийнх нь сонирхол солигддог юм уу юм нь өөрчлөгдөөд байдаг. Эсвэл та биш, танай яам биш, харин энэ салбарт энэ нөгөө эмийн зах зээлийн 500 гаруй тэрбум дотор ингэж тоглолт хийгээд, бизнесийн зорилгоор илүү ашиглаад сурчихсан компаниудын нөлөөлөл байгаад байна уу? Та яг өнөөдөр энэ дээр бодит хариулт өгөөч.

Энэ үнэхээр, бид маш сайн мэдэж байгаа шүү дээ. Бид ажлын хэсэгт нь орж байна, дэд ажлын хэсэгт нь байж байна. Чинбүрэн гишүүнээр ахлуулаад ингээд явж байна, нөхцөл байдал ямар байгааг хүмүүстэй уулзаад сонсож байна. Бид мэдээлэл маш өндөр түвшинд байгаа учраас та өнөөдөр бодит мэдээлэл өгөөч. Энэ нь ЭМЯ одоо зайлиггүй дахиад нөхцөл байдалтай уялдуулж, тийм, тийм заалтыг нь өөрчлөх гээд ингэж байгаа юм уу? Эсвэл та бүхэн энэ зах зээл дээр бүр ингээд ноёрхсон компаниудынхаа эрх ашгийг дийлэхгүй байна уу? Энэ эм энэ одоо хуулийн төсөл ер нь явах нь уу, явахгүй нь уу? Нэгдүгээрт энэ дээр маш тодорхой хариулт өгөхийг танаас хүсэж байна.

Хоёр дахь зүйл нь бид үнэхээр одоо олон зүйл дээр боломж олгосон. Одоо манай Бямбасүрэн дарга маань ч мэдэж байгаа. Төсөв хэлэлцэх болгонд эрүүл мэндийн төсөв яагаад ингээд доошоо байгаа юм бэ, ингэж болохгүй. Тийм учраас ДНБ-д эзлэх эрүүл мэндийн санхүүжилтийг нэмье гээд бид өнөөдөр дөрвөөс тав болгож, таны одоо санхүүжилтийг 1.8 их наяд хүртэл хүргэсэн. Энэ дотор эмд зарцуулах, иргэддээ хөнгөлөлттэй чанартай үнээр одоо ингээд хангах. Гэхдээ эм нь өөрөө чанартай байх учраас эмийг хоол шиг

хэрэглэдэггүй байх, зөв зохистой эмийн хэрэглээг бий болгох энэ зорилгоор бид нар маш олон ажлууд хийсэн, боломжийг олгосон. Гэхдээ энэ маш удаан хэрэгжээд байна. Өнөөдөр Новартистай та бүхэн гэрээгээ хийх шатандаа явж байна гээд л ярьж байна л шүү дээ.

Т.Аюурсайхан: Энхболд сайд хариулъя.

С.Энхболд: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Эмийн тухай хууль дээр бол бид нар ямар нэгэн эм ханган нийлүүлэх байгууллагуудын нөлөөллийг бол оруулаагүй. Нөлөөлөл орох ч үгүй, би энийг бол сайдын хувьд ба бас танд хэлье. Энэ дээр хамгийн гол нь бид нар бас зарим зохицуулалтын ажлууд байгаа. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын агентлаг, цаашид бид нар бас энэ төрийн өмчит үйлдвэрлэлийн газрыг байгуулах дээр энэ тогтолцоо маань яаж цаашид явах юм, хамгийн гол нь энэ төрийн өмчит үйлдвэрлэлийн газрыг байгуулах гээд байгаа шалтгаан нь өөрөө бид нар энэ Засгийн газар шууд тухайн чанартай улсын одоо нэр бүхий компаниудтай шууд Засгийн газрын түвшинд худалдан авах гэрээ хийх, энэ маань өөрөө энэ иргэдэд чанартай, хямд үнэтэй эмийг оруулж ирэх бололцоог бүрдүүлэх, энэ дээр бас тухайн одоо тарифын юун дээр ямар зохицуулалтууд хийх вэ гэх мэтчилэн энэ хуульд тусгагдах бас нэлээн хэд хэдэн заалтууд байгаа. Энэ дээр бид нар юу хийж байгаа, судалгаануудыг хийгээд сууж байна.

Бид нар ЭМД-ын сан дээр 20 онд бол 30 тэрбум байсан хөнгөлөлттэй эм. 22 он дээр бол 67 тэрбум болгож өсгөсөн, 23 он дээр 90 тэрбум болгож өсгөсөн байгаа юм. Энэ болгон бол бид нар энэ ард иргэддээ ялангуяа энэ бас эрсдэлтэй бүлэгт байгаа хүмүүст бид нар эмийг аль болох чанартай, хүртээмжтэй, санхүүгийн дарамтгүй байдлаар үзүүлэхийг зорьж байгаа учраас жил болгон энэ төсвийг бол нэмж

тавьж байгаа. Энэ маань өөрөө иргэдэд аль болох тэр 500 нэр төрлийн маань санхүүгийн дарамтгүй, одоо амьдралын чанарыг уртасгах, энэ зонхилон тохиолдож байгаа өвчнөөсөө сэргийлэх, урт хугацаанд амьдралын чанарыг хадгалах, энэ үүднээс бид нар жил болгон одоо төр засгаас авч байгаа энэ бол нэг том бодлого гэж харж байгаа.

Тийм учраас бид нар энэ жор бичиж байгаа эмч нарынх нь бүх түвшинд бичдэг болгосон. Дээрээс нь эмийн сангуудаар олгогдох эрхийг нь бол одоо өнөөдрийн байдлаар 800 байсан эмийн санг бид нар 1800 эмийн санд олгодог эрхийг нь өгсөн. Энэ мэтчилэн бол аль болох л бид нар иргэд рүүгээ энэ эрсдэлтэй бүлгийн, ялангуяа энэ одоо байнга эмийн хэрэглээтэй иргэд рүүгээ чиглэсэн энэ арга хэмжээ бол энчээ явж байгаа. Новартисийн эм дээр бол бид нар гэрээгээ хийчихсэн. Би түрүүн хэлсэн 22 нэр төрлийн эм бол манай улсын гаалиар ороод ирчихсэн. Одоо энэ дээр хамгийн гол нь бид нар 16 эм дээр нь тухайн улсын тэр био.э...-ээр тэр чанарыг үзүүлсэн тэр чанарын гэрчилгээнийх нь юуг авчихсан байна. Ингэснээрээ бид нар Хүний эмийн зөвлөлд оруулж бүртгүүлчих юм бол энэ маань одоо маргаашаас эхлээд шууд эмийн сангуудаар тараагдахад бэлэн болчихсон байгаа. Энэ ажлууд маань ингээд тодорхой үе шаттай, мэдээж зарим нэг ажлууд нь жоохон процедурын ажлууд байна. Тэрэн дээр бол жоохон хугацаа алдаж байгаа. Гэхдээ бид нар аль болох л хурдан иргэддээ хүрэх зорилгоор энэ эмийг бол бүх түвшинд нь уулзалтуудыг хийгээд одоо 16 эм бол бэлэн болчихсон. Одоо нэмж бид нар 6 эм дээр авах юм бол Хүний эмийн зөвлөлийг бичиг ирсэн өдөр нь шууд хуралдуулаад бүртгэж аваад, иргэддээ тараахад бол бэлэн болсон байгаа.

Т.Аюурсайхан: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнд микрофон өгье.

М.Оюунчимэг: Энхболд сайд маань сая бид нарын хийсэн юмыг л ярьж байна л даа. 30 тэрбумыг 67 тэрбум болгох, 67-г 90 тэрбум болгох ажлыг Улсын Их Хурал Нийгмийн бодлогын байнгын хороон дээр хийсэн л дээ. Энэ мөнгө нь танагдаад унаад ороод ирчихсэн Бид ингэж болохгүй, ингээд энэ 67 тэрбумыг суулга. Ер нь энэ, энэ эмийн шаардлагатай байгаа. 500 нэр төрлийн эм, дээрээс нь ковид цар тахлын энэ амаргүй үед ингэх ёстой байна гэдгийг манай эрүүл мэндийн салбарынхан маань Их Хурлын гишүүддээ маш сайн ойлгуулж, ярилцаад бид хамтдаа энэ санхүүжилтийг тусгасан. Харамсалтай нь энэний үр дүн одоо менежер та өөрөө бас нэг сайн менежмент хийгээд ингээд явж чадахгүй байгаагаас болоод яг эзэндээ очихдоо бид нарын хүрсэн үр дүнд хүрэхгүй байна л даа.

Үнэхээр ЭМД-ын сангаас бид маш олон эмүүдийг хөнгөлсөн. Сая таны хэлж байгаа Эм, эмнэлгийн хэрэгслийн агентлаг бол зайлшгүй хэрэгтэй юм байна гэдгийг бид хоорондоо ярилцаад 18 онд шүү дээ, энэ ийм агентлагтай болъё гээд тэгээд агентлагийг бий болгох ёстой, тус эрх зүйн орчныг нь бүрдүүлсэн. ЭМД-ын сан, даатгалын ажилтнууд.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Энх-Амгалан гишүүн алга байна. Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа, би нэг товчхон зүйл асууя. Тэгэхээр энэ эмийн хэрэглээ талаасаа манайх ер нь ямар түвшинд байдаг юм бол? Эмийн зохистой хэрэглээ. Ялангуяа энэ сүүлийн үед дэлхийн нэлээн олон улс орнуудад хамгийн хурцаар тавигдаж байгаа юм бол эмийн зохисгүй хэрэглээ. Одоо антибиотикийн буруу хэрэглээ, түүнийг дагасан хүндрэлүүд олон асуудал байна шүү дээ. Энэ дээр ер нь тооцоо судалгаа хийсэн зүйл байна уу?

Дараагийнх нь бол эмийн чанар байдлын асуудал байгаа юм. Яг одоо чанартай эмийн үйлдвэрүүдээс ханган нийлүүлэлт хийж чадаж байна уу? Нөгөө талдаа эмийн үнийн асуудал. Энэ эм, эмийн үнийн хэт өсөлтийн асуудал юунаас шалтгаалаад байна гэсэн нэг ийм 3 зүйл.

Ингээд үргэлжлүүлээд хэлэх юм бол бид нар энэ ер нь хүн амынхаа эрүүл мэндийн асуудлыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, энэ далайцтай ажлыг зохион байгуулах ийм шаардлага байгаа. Эрүүл мэндийн сайд бол Энхболд сайд бол их санаачилгатай ажиллаж байгаа. Түрүүн Баатарбилэг гишүүний асуулт дээр ч одоо тодорхой хэлж байна лээ. Тэгэхээс өөр арга байхгүй. Эрүүл мэндийн салбарын одоо гол бодлогын 2 тулгуур багана бол хамгийн түрүүнд нийгмийн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх ажил байх ёстой. Тийм ээ. Нөгөө талд нь мэдээж эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмчилгээ эмнэлгүүдийн асуудал. Тэгэхээр бид нар хамгийн эхнийхээ гол асуудлыг ингээд хайхрахгүй хаячхаад байх юм бол тэгээд л одоо эмнэлэг бариад байдаг, бариад байдаг эмийн хэрэглээ, эмийн хангалт, эмийн хэрэглээ нь яваад байдаг. Тэгээд энэ чинь бол эцсийн дүндээ улс орны хөгжлийн асуудал, хүний хөгжлийн асуудал, хөдөлмөрийн зах зээл, бүтээмж энэ бүх асуудлуудтай уялдах учраас бид нарын тавиад байгаа асуудал бол энэ нийгмийн эрүүл мэнд, хүн ардыг эрүүл, идэвхтэй энэ амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёс, зөв дадал хэвшил энэ рүү оруулах юман дээр одоо ЭМЯ, Боловсролын яам, Соёлын яам, энэ салбар дундын одоо зохицуулалтаар ингээд биеийн тамирын салбартайгаа хамтарч энэ ажлыг одоо их далайцтай зохион байгуулах ийм шаардлагатай байна. Тэгээд бид нар ЭМД-аасаа.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Энхболд сайд хариулъя 81.

С.Энхболд: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Эмийн чанар би бас түрүүн хэлсэн. Нэлээн олон хүчин зүйл нөлөөлдөг. Эрүүл мэндийн салбар сүүлийн 30 жилийн хугацаанд манай улс төр, хувийн хэвшил энийг бол хамтран зохион авч яваа. Нэг ч улсын үйлдвэрийн газар байхгүй эмийн. Энэ өнгөрсөн 30 жилийн хугацаанд 400 гаруй эм ханган нийлүүлэх байгууллагууд эмийн үйлдвэрлэл болон импортын энэ оруулж ирэх эм дээр бол зохицуулалт хийж, ингээд төр засагтайгаа хамтран ажиллаж байгаа. Ялангуяа энэ антибиотикийн зөв зохистой хэрэглээ дээр эд нар бол үе шаттай ажлууд хийгдээд явж байгаа юм. Энэ одоо ингээд нэг шийдвэр тушаал гаргаад ингээд шууд хэрэгжээд, маргааш нь хэвийн байдалд орчих эд бол биш. Энэ бас нэлээн тийм судалгаа шинжилгээтэй, бас нэг хэдэн жил харж зарцуулагдах ажил. Ялангуяа энэ дээр бид нар эмийг жороор бичдэг болгосон. Шат шатны ялангуяа антибиотикийг бол жороор олгодог болсон энэ бол нэг зохицуулалт байсан. Өмнө нь бол ерөөсөө энэ маань ингээд дурын хүн очоод ханиад хүрлээ гэхэд захын эмийн сангаас эмээ бичүүлээд авчихдаг байдалтай байсан бол энэ нь ингээд зохицуулагдаж байгаа.

Дээрээс нь бид нар бас энэ олон улсын жишигийг судлаад А, В, С, D гэдэг ангилал гаргасан. Энэ маань өөрөө бас яг энэ эмийн зохицуулалт дээр хяналт тавьж байгаа нэг хэлбэр гэсэн үг. Энэ мэтчилэн бид нар ингээд үе шаттайгаар энэ эмийн зохистой хэрэглээ тал руугаа бол үйл ажлуудыг хийж явж байна. Яалт ч үгүй мэдээж эмийн чанар бол эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 50-60 хувийг бол эзэлдэг. Үр дүн нь нөлөө гарахад. Тийм учраас бид нар энэ үндэсний аюулгүй байдал, энэ эмийн чанар дээр бол онцгой анхаарч ажиллаж байгаа. Тийм учраас бид нар энэ лабораторийн чадавхыг сайжруулъя, бэхжүүлъя, хүний нөөцийг чадавхжуулж бэлдье гээд энэ үе шаттай ажлуудыг бас тодорхой үе шаттайгаар, бас энэ дээд удирдах байгууллагуудад бас тавиад явж

байгаа. Энэ маань бас ингээд үр дүнгээ өгнө гэж бол харж байгаа.

Дээрээс нь мэдээж хүн өвдөхгүйн тулд одоо Монгол Улс улсын урт хугацааны бодлогын бичиг 20-50 дээр бас тусгагдсан байгаа. Эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, жил болгон урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаг болох гээд. Энэ ажлуудыг бол бид нар бол эхлүүлээд явж байна. Ингээд үе шаттай хийж байна. Өнөөдөр гэхэд бас бид нар эерэг хандлага, эрүүл оюутан гээд энэ оюутан залуучуудыг бас эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн боловсрол олгох гээд энэ ажлуудыг бол ингээд үе шаттай хийж байгаа. Мэдээж урьдчилан сэргийлэх үзлэгийг 5 сарын 1-нээс эхэлсэн. Өнөөдрийн байдлаар 400000 орчим хүн хамрагдаад явж байна. Манай ард иргэд маань идэвхтэй хамрагдаж байна. Нэлээн олон өвчлөл бүртгэгдэж байна. Ийм учраас бид нар нийтийн эрүүл мэндийн боловсрол олгох тал руу бол илүү түлхүү анхаарч, цаашидын бас бодлогын бичиг баримтаа тусгаад Боловсрол, шинжлэх ухааныхаа яамтай хамтраад, мөн Спорт, олимп хариуцсан Бат-Эрдэнэ сайдтайгаа бас энэ ажлуудыг бас ярилцаад үе шаттай явж байгаа.

Тийм учраас энэ дээр бас бодлогын томоохон бичиг баримтууд дээр бид нар тусгаад цаашид явна. Тийм учраас мэдээж бид нар өвчлөхөөс нь биш өвчлөхөөс сэргийлэх тал руугаа илүү бол ард иргэддээ эрүүл мэндийн боловсрол олгох тэр чиглэл рүү нь илүү түлхүү ажлуудыг хийнэ гэж бодож байгаа юм. Тэгээд дараагийн асуултад.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Эрдэмбилэг дарга үргэлжлүүлээд нэмээд хариулъя 80.

Ц.Эрдэмбилэг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Эрдэмбилэг. Эмийн үнийн асуудал, үнийн өсөлтийн шалтгааны хувьд бол 2022 онд

Эрүүл мэндийн сайдын 425 дугаар тушаал бол батлагдсан. Энүүгээр бол өндөр үнийн одоо өсөлттэй гол эмийн одоо эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхээр энэ ажлын хэсэг байгуулагдсан. Бид бүхэн бол зах зээлд өндөр хувь эзэлж байгаа гол нэрийн 75 эмийн үнийн судалгаа хийж үзсэн байгаа. Энэ судалгаагаар бол эмийн өсөлтөд гол нөлөөлж байгаа хүчин зүйл нь бол одоо түүхий эд, сав баглаа боодлын үнэ өсөлт, ханшийн зөрүү, тээврийн зардал гэсэн энэ 4 шалтгаан бол эмийн одоо үнийн өсөлтөд гол нөлөө үзүүлж байна гэсэн ийм дүн байгаа.

Эмийн үнэтэй холбогдуулаад бас түрүүн Туваан гишүүн асуусан. Энэ бүртгэлийн хураамжийн хувьд. Бүртгэлийн хураамжийн хувьд бол бид нар 295 дугаар тушаалаар бол энэ бүртгэлийн хураамжийг зохицуулж байгаа. Энэ нь бол өмнөх мөрдөж байсан хураамжаасаа бол үнийг нь арай жоохон бууруулсан байгаа. Тэгэхдээ энэ бүртгэлийн хураамж бол хэдийгээр өндөр юм шиг санагдаж байвч энэ бүртгэлийн хураамжийг одоо журмын дагуу эмийн зах зээл дээр гарсны дараа энэ бүртгэлийн үйлдвэрлэгч бүртгэлийн одоо төлбөрийг 5 жилийн хугацаанд нэг л удаа төлдөг байгаа. Өөрөөр хэлбэл бүртгүүлэхдээ төлөөд, 5 жилийн дараа дахиж төлдөг ийм байгаа. Тэгэхээр энэ 5 жилийн хугацаанд оруулж ирж байгаа тэр эмийн импорт энэ тэртэйгээ харьцуулахад бол бүртгэлийн хураамж нь бол төдийлөн нэг их биш бол байгаа.

Т.Аюурсайхан: 88 дээр нэмж хариулах уу.

П.Цэцгээ: Хяналт зохицуулалтын газрын Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газрын дарга Цэцгээ байна. Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмж хариульа тодруулга. Эмийн зохистой хэрэглээний чиглэлээр бол манай агентлагаас ер нь цогц арга хэмжээг хэрэгжүүлж байгаа. Ер нь эмийн

зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд эмч нарт зориулсан эм хангамжийн байгууллагад зориулсан иргэдэд зориулсан гэсэн 3 чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлж байж эмийн зохистой хэрэглээ төлөвшдөг. Эмч нарт зориулсан үйл ажиллагаанаас бол манайх клиник, клиник эм зүйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр журмууд гаргаад хэрэгжүүлээд явж байгаа. Иргэдэд зориулаад бол эмийн зохистой хэрэглээний аянууд зохион байгуулдаг. Хамгийн одоо сүүлийн үед хамгийн чухал хийгдсэн үйл ажиллагаа гэвэл бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх, салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөөг 2022-25 онд хэрэгжүүлэх энэ төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байгаа. Энийг 2 сайдын тушаалаар батлуулсан. Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлуулсан. Хүний болон малын эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр одоо энэ зуугаад арга хэмжээг төлөвлөөд хэрэгжүүлээд эхэлсэн байгаа.

Одоо манайх бол Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа яг санал нийлж байна. Одоо манайх нянгийн эсрэг эмийнхээ хэрэглээгээр азидаа бол бараг манайх нэгдүгээрт орж байгаа. Одоо тэгэхээр бид нар бол бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулаад ажиллаж байгаа. Би түрүүн нэг гишүүний юун дээр хатуу зохицуулалттай улс орны бүртгэл гэдэг дээр нэмээд нэг тоо баримтаа нэмээд хэлчихье. Нийт бүртгэлтэй байгаа 4300 нэрийн эмээс 41 хувь нь одоо хатуу зохицуулалттай улс орноос бүртгэлтэй, үлдсэн нь бусад улс орноос бүртгэлтэй байгаа. Ер нь бүртгэл бол энгийн болон түргэвчилсэн гэж явдаг. Хатуу зохицуулалттай улс орноос бүртгэхдээ бага цөөхөн материал шаардаад, түргэн хугацаанд бүртгэдэг. Яг тэр үнийнх нь асуудал дээр.../минут дуусах/

Т.Аюурсайхан: Бат-Эрдэнэ гишүүн нэг минут Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би түрүүнд цаг багтаагүй учраас би тодруулаад хэлье. Улсын Их Хурал 2, 3 бүрэн парламентын бүрэн эрхийн хугацаанд манай биеийн тамирыг дэмжих лобби бүлэг бол нэлээн идэвхтэй ажиллаж байж энэ ЭМД-аасаа иргэд маань энэ өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах, бэхжүүлэх, энэ үйл ажиллагаандаа тодорхой хэмжээний санхүүжилт авдаг ийм тогтолцоог бий болгосон юм. Харамсалтай нь одоо энийгээ ухраад хүчингүй болчихсон ийм нөхцөл байдалтай байгаа. Иргэд өөрсдийнхөө одоо хөдөлмөрийн хөлс цалингаасаа ЭМД-д мөнгө төлж байгаа. Заавал өвчилсөн хойноо, заавал эмнэлгийн тусламж, заавал эм авах энэ тохиолдолд нөгөө мөнгөө ашигладаг. Бусад үед нь ашиглаж чадахгүй тохиолдол их гарч байна шүү дээ. Тийм учраас энэ фитнес, эрүүл мэндээ хамгаалах энэ үйл ажиллагаанд ЭМД-аас авдаг энэ тогтолцоог бий болгосон юм. Тэгээд одоо энэ нь эргэж сэргээх бололцоо байхгүй бол тэр Эрүүл мэндийг дэмжих сангаасаа одоо энд зарцуулах.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Энхболд сайд гүйцээгээд хариулъя 81.

С.Энхболд: Энэ хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулж байж Бат-Эрдэнэ гишүүнээ энэ шийдэгдэх ёстой асуудал байгаа. Энэ ЭМД-ын сангаас санхүүжих бүх юмыг одоо ЭМД-ын сангаас санхүүжүүлнэ гэх юм бол энэ сан маань өөрөө тусламж үйлчилгээндээ хүрэлцэхгүй. Одоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бас зарим асуудлууд даатгалын сан руу яригдаж байна. Энэ болгоныг бас бид нар удаан хугацаанд ихэвчлэн эмчлүүлдэг, асрах энэ үйлчилгээтэй юуг бол ЭМД-ын сангаас зохицуулах бас боломж байхгүй өнөөдрийн хувьд.

Мэдээж бид нар энэ архи тамхины хууль дээр татвараа дэмжих сан руугаа төвлөрүүлж чадвал бид нар эндээс энэ биеийн тамир, спорт энэ ялангуяа энэ фитнесээр хичээллэх, иргэдийнхээ энэ урамшуулал олгох зарчмаар энийг хэрэгжүүлээд зохицуулалтыг хийх бүрэн бололцоотой. Дэмжих сангаар дамжуулаад гэсэн үг. Тэгэхдээ архи, тамхины хуулийн одоо тэр ирэх ёстой хувийг дэмжих санд төвлөрүүлсэн цагт энийг.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг, Цэвэгдоржийн Туваан нар үг хэлнэ. Тус бүр 5 минутын үг өгье.

М.Оюунчимэг: Намрын чуулганы яг эхэн дээр яг бидний асуулгаар хүн амын эрүүл мэндэд нэн чухал асуудал энэ эмийн асуудлаарх асуулгад маань хариулт өгч байгаад баярлалаа. Тэгээд хамгийн гол нь бид яагаад энэ асуудлыг хөндөөд байна гэхээр Үндэсний статистикийн газрын хамгийн сүүлийн судалгаагаар хүн амын 42.2 хувь нь ядуу бөгөөд ядуу болоход ядууралд ойрхон өртөхөд бэлэн болчихсон байна гэсэн судалгаа гарсан. Энд нөлөөлж байгаа зүйл юу байна гэсэн чинь нэгдүгээрт эм тариа, эрүүл мэндийн салбарт үзүүлж байгаа энэ эмчилгээнд хамаг зардал явж байна гэсэн нэгд. Хоёрт нь өргөн хэрэглээний бараа, гуравт нь бусад зардал гэсэн байгаа.

Тэгэхээр эндээс яг үзэхэд ДЭМБ-ын судалгаа, манай Нийгмийн бодлогын байнгын хороо, АХБ банкаар хийсэн судалгаануудаас аваад үзэхэд энэ дэлхийн стандартаар өрхийн эмийн хэрэглээнд зарцуулж байгаа зардал нь дээд тал нь жишгээр 15 хувь хүрэхтэй үгүйтэй байх ёстой байтал манайд яг одоо дөч орчим хувьтай байна. Тэгэхээр энэ өөрөө аргагүй нөгөө айл өрхийг ядууралд

хүрэхэд маш том ийм нөлөө үзүүлж байгаа нь эндээс харагдаж байгаа юм. Бид нар ганцхан жишээг одоо та бүхэн маань мэдэж байгаа байх. Уналт, таталтын эсрэг эм байнга хэрэглэдэг гэр бүл, ээжүүд ордны гадаа бидэнд юу гэж хэлж байлаа. Маш урт хугацаанд энэ эмийг хэрэглэд үнэ нь өндөр, олдоц муутай, тэгээд бид зүгээр эдийн засгаараа үнэхээр сэтгэл санаа, эрүүл мэнд, эдийн засгаараа хохироод бид өнөөдөр ядуурлын эгнээ рүү орох гээд байж байна гээд нулимс дуслаа ярьж байсан. Энэ ганцхан жишээ л байна л даа.

Өнөөдөр та бүхэн маань хараад үз, ахмадуудын доод тэтгэвэр 500000 төгрөг байгаа. Энэний бараг тавиас илүү хувь нь эм тариа, нөгөө давхар найрлагатай даралтын эмээ хэд дахин авсаар байгаад яваад дуусаж байна гээд. Тэгээд тэтгэврийн зээлдээ, тэгээд энэ өндөр үнэ ханшитай нөгөө талх тариандаа хүрэхтэй үгүйтэй болоод энэ нь нөлөөлж байна. Өнөөдөр та нар маань хүйтрээгүй байхад л хүүхдийн эмнэлгүүд тэр чигээрээ өнөөдөр энэ амьсгалын замын өвчин, томуу, томуу төст өвчин гээд бүх хүүхдийн эмнэлгүүд ачааллаа дийлэхээ байлаа байж байна шүү дээ. Бид уржигдраас ингээд хүүхдийн эмнэлгүүдээр явж байна. Энэ жил бүр эрт байна гээд байна. Тэгээд энэ нь юу байна вэ.

Сая бас нэг гишүүдийн яриад байгаа нийгмийн эрүүл мэндээ бид анхаарч чадахгүй, Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулиа оруулаад ирээч гэж 2 жил та бүхнээс хүсч, шахаж шаардаж байлаа. Орж ирсэнгүй өнөөдрийг хүртэл. Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн төслөө оруулаад ир, бид энийг батлаад, хамтраад бүр ажлын хэсэг гаргаад ингээд явсан, өнөөдөр алга. Та бүхэн маань мэдэж байгаа хавдрын өвчлөлөөр өнөөдөр Монгол Улс дэлхийд 3-т бичигдэж байна шүү дээ. Бид энийг ярилцаад хамтдаа ЭМЯ-ныхантайгаа,

Байнгын хороо, Улсын Их Хурал нь шийдээд, ЭМД-ын сангаас хавдрын өвчлөл, химийн тариа, эмчилгээнд нь зуун хувь санхүүжүүлэх энийг бид авч шийдэж байгаа ч гэсэн өвчлөл буурахгүй, бүр нас баралт нь нэмэгдээд байна шүү дээ. Одоо 2040 он гэхэд хорт хавдрын шинэ тохиолдлын тоо манайх 12000-д хүрэх ийм тооцоо гараад байна. Энэ юу нь мэдэж ганц ЭМЯ биш агаар, хөрсний бохирдол, бусад хоол хүнс гээд асуудлууд байгаад байгаа. Тэгээд энийг цогцоор нь шийдье гээд.

Төр эмийн зах зээлээ хяналтад аваад эхлээд эрх зүйн таатай орчныг нь бүрдүүлэх гээд хууль хяналт, хууль, эрх зүйг нь бүрдүүлж өгөөд, та бүхний шаардлагатай ийм санхүүжилтүүд хэрэгтэй байна гээд тооцоо оруулаад ирэхэд бид бас эхнээс нь боломжоороо шийдэж өгөөд байхад үр дүн гарахгүй байгаад байна. Дунд, доод шатандаа. Энэ нь юу вэ гэхээр эмч, эмнэлгийн ажилтнууд маань бол үнэхээр тултал ажиллаж байгаа. Гэтэл тэд нар маань өөрсдөө яриад байна шүү дээ. Бид зүгээр хэдхэн бизнесийн компанийн тэр дамжин өнгөрөх бааз болчихоод байна гээд бид нар ажлын хэсгийг очиход ярьсан. Энэнийг нотлох нэг жишээ байгаа юм. Тусгай зөвшөөрөлтэй 256 эм ханган нийлүүлэх байгууллагын 101 нь л үйл ажиллагаа явуулж байгаа. Үүний 10 нь зах зээлийн наян хувийг, үүнээс гуравхан компанийн 57 хувийг эзэлж байна гэсэн асуудал.

Тэгээд энэ нь өөрөө дэлхийн зах зээлд байхгүй 18 хувиар илүү үнэтэй эм оруулж ирж байна. Бүр нэн ховор эмийг 540 хувиар илүү үнэтэй байна Дэлхийн зах зээлээс гээд Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн тайлан дээр ингээд гарчихсан байгаад байдаг. Мэдээж хувийн хэвшлийнхэн маань эм ханган нийлүүлэлт оруулж ирж байгаа нь маш сайн хэрэг. Гэхдээ төр байна, салбарын яам нь байна, агентлаг бий болгоод өглөө. Энэ эм дэлхийн зах зээл дээр ийм үнэтэй байна, долларын ханшаар тооцоод үзэхэд энэ орж ирэхдээ жишээ

нь нэг нугалж л орж ирэх юм байна. Энэ бол 50 доллароор орж ирэх ёстой юм байна гэх юмыг өнөөдөр 500 доллароор зарж байхад хэн ч хяналт тавьж чадахгүй байна. Хүний эмийн зөвлөл эрх, үүргээ биелүүлж чадахгүй байгаад байна. Энд л бид санаа зовоод өнөөдөр энэ асуудлуудыг хамтдаа шийдье, бид та нарт хугацаатай үүрэг даалгавар өгсөн Нийгмийн бодлогын байнгын хорооноос.

Дээрээс нь энэ гүйцэтгэлийн аудитаар Засгийн газарт 5, Эрүүл мэндийн сайдад 5 зөвлөмж өгсөн. Сая таны бидэнд өгсөн энэ тайлбараас энэ зөвлөмжийн бүгд нь ажиллаж байна, энийг анхаарч байна, хэрэгжих явах шатандаа байна гэсэн хариултууд авч байна л даа. Удаан байна сайдаа. Өчигдөр нөгөө ковидын үед бид нар яалаа, ганц лаборатори нь ажиллахгүй болоод байсан. Тэгэхээр энэ бүгддээ маш онцгой анхаарч ажиллах хэрэгтэй байна. Түр хороо энэ дээр онцгой анхаарах болно шүү гэдгийг хэлье гэж бодож байна. Хамгийн гол нь бид нарын өнөөдрийн асуулгын гол үр дүн, хамтдаа энэ ядахдаа эм тариагаа энэ үед ханган нийлүүлэлт дээр нь онцгой анхаарчихъя. Төсөв.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан үг хэлнэ.

Ц.Туваан: Хууль хэрэгжихгүй байна. 2020 оны 8 дугаар сард баталсан Эрүүл мэндийн тухай, ЭМД-ын тухай хууль дээр орсон эрүүл мэндийн салбарын бодлогын санхүүжилтийн бодлого өөрчлөгдсөн, энэ гүйцэтгэлийн санхүүжилт гэдэг юм чинь огт хэрэгжихгүй байна. Яагаад Эрүүл мэндийн сайд хамт олон хууль хэрэгжүүлэхгүй байна вэ. Өнөөдөр орон нутагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.7 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж Төв аймгийн бүх сумуудад нэгдсэн эмнэлэгт гардуулж өгсөн. Сайд руу залгаад утсаа авдаггүй, Төрийн нарийн бичгийн дарга руу яриад

хүн гаргаж өгдөггүй, газрын даргатай нь яриад ажилтай хэлтсийн даргатай нь яриад өвчтэй. Энэ чинь ганцхан миний асуудал биш. Энэ яамны асуудал. Яагаад та хэд энэ анхан шат руугаа орж ажилладаггүй юм бэ.

Тэнд чинь маш их асуудал байна шүү дээ. Гүйцэтгэлийн санхүүжилтийн программ өнөөдрийг хүртэл байхгүй байна. Программ нь байхгүй, компьютер нь байхгүй, өнөөдөр энэ асуудал чинь явж байна. 7, 8, 9 сарын санхүүжилтээ авч чадаагүй байна. Хэрэв та бүхэн эрхэм дарга нар өнөөдөр надтай цуг очсон бол тэнд цугларсан анхан шатанд гардан орж байгаа эрүүл мэндийн сумын эрүүл мэндийн дарга нараас энэ асуудлыг газар дээр нь сонсох байлаа. Харамсалтай нь та бүхэн томоохон энэ хурал зөвлөгөөн чуулгандаа оролцоод энэ асуудлыг тоохгүй юм байна.

Тэнд юу болж байна гэхээр би нэгхэн жишиг хэлье. Архуст сумын ЭМТ-ийн дарга одоо би сум руугаа яаж очих юм бэ гээд зогсож байна. Жолоочоо тав хоног ажиллуулчихаад цалинг нь тавьж чадахгүй, цалингүй амрааж байна, үйлчилгээний ажилтнаа мөн тав хоног ажиллуулчихаад амрааж байна. Яагаад гэхээр төсөв нь хүрдэггүй. Бид нарын бодлогоор өөрчилсөн энэ эрүүл мэндийнхээ эмч нараа энэ юу даатгалын санхүү, төсөв бүрдүүлэгч болохгүй гээд үзсэн, энэ юм яг хэвээрээ байна. Ерөөсөө яг хэвээрээ байна. Ингээд хууль ерөөсөө хэрэгжихгүй байна. Энэ хүмүүс чинь ирж байгаа төсөв чинь хүрэхгүй байна, цалингаа тавьж ирэхгүй байна гэдэг асуудлыг хурцаар тавьж байна.

Өнөөдөр эрүүл мэндийнхээ одоо газар руу, яам руу бичгүүдээ явуулж байгаа гэсэн. Тусгай зориулалтын шилжүүлгийг арай гэж алга болгосон чинь эрүүл мэндийн одоо юун дээр хаана юм эрх нээлгэдэг гэдэг асуудал. Эрхээ нээлгэх хүсэлтээ тавиад 2 сар таг алга болдог, санхүүжилт байхгүй ийм асуудлыг анхан шатан дээр ярьж байна.

Тэр программ дээр арай гэж нэг ehealth программ гээд л ингээд явж байсан, дахиад бүрэн одоо шалгуурыг нь шалгаж аваагүй туршилтын шатандаа явж байгаа ehospital гэдэг маш их алдаатай программаар эрүүл мэндийн гүйцэтгэлийг авч байна. Хариулт нь байхгүй. Эндээс энэ хүмүүс чинь санхүүжилтээ авч чадахгүй байна.

Хоёрдугаарт, яам яагаад энэ Сангийн яамтай ажиллаж энэ Засгийн газар кабинет дотроо ажиллаж энэ нэг иргэнийг 2 дахин санхүүжүүлсэн, энэ мөнгийг хөөцөлдөхгүй байна вэ. Сангийн яамнаас би таарах болгондоо асуудаг, миний амыг тагличхаад байна. Уг нь хариуцаад хөөцөлдөөд мэдээллээ аваад явах ёстой хүмүүс нь эрхэм дарга нар та нар. Энэ ажлаа яагаад хийхгүй байгаа юм бэ? Бид нар бол ковидын үе гээд зөндөө толгой илсэн. Би ч хүртэл салбарын юм гээд одоо бас зөндөө асуудал байгаа гээд явсан удаан хугацаанд. Одоо арай дэндлээ. Засгийн газраас Их Хурлаас энэ бодлогын асуудлуудыг бүгдийг нь маш хурдан шийдэж өгсөн. Засгийн газар дээр санхүүжилтийг маш өндөр тавьж өгсөн. Энэний үр дүн чинь ерөөсөө гарахгүй байна. Одоо та бүхэн маань ажлаа хий. Хүн халах, эмнэлгийн дарга солихоос өөр зөндөө ажил наад хөрсөн дээр чинь байна шүү. Энийгээ та бүхэн бодож ажлаа хийгээрэй.

Эмийн үнээ бод л доо. Сая одоо Оюунчимэг гишүүн хэлж байна. Энэ долларын үнэ, инфляц, хил гаалиас чинь болоод хамаг мөнгөө эмдээ л өгч байна. Тэгээд би тэр Новартис гээд яриад байгаа юмыг жилийн өмнө л Байнгын хороон дээр ярьж байсан, өнөөдөр бүртгэх юм яриад л сууж байна. Бүртгэдэг зүйл чинь та нарын доор байгаа шүү дээ. Эсхүл өөр энэ өөр яаманд байгаа юм уу. Хурд дутаад байна гэж хэлээд байгаа энэ үнэн. Тэгээд тэр түрүүн уламжлалт эм энэ тэр гээд л зөндөө ярьсан. Тэгээд энэ Эм, эмнэлгийн агентлаг, наян хүнтэй агентлаг

ажиллаж л байна. Энд уламжлалт эм хариуцсан хүн мэргэжлийн хүн байдаг ч юм уу, үгүй ч юм уу.

Өнөөдөр энэ Монгол Улсад үйлдвэрлэж байгаа эмийг чинь 60-65 хувийг нь муу сайн хэлүүлдэг, хөнгөлөлт авдаггүй энэ уламжлалтын эмийнхэн чинь гаргаж өгдөг шүү. Ковидын үеэр бид нар яасан Мана 4 Норов 7 бичээд л өгөөд л уулгасан. Тэгээд ямартаа болохоор энэ бодлогын гадуур энэ эмүүд нь яваад, ямартаа нөгөөдүүл нь ороод явчихдаг юм. Тэгэхээр ажил дээрээ онцгой сайн анхаарч ажилла гэдэг зүйлийг.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад, Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваанаас Эрүүл мэндийн сайдад тус тус тавьсан асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар сонслоо. Ажлын хэсэгт баярлалаа. Дараагийн асуудалдаа орно.

15.41 цаг

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал үргэлжлэв.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх асуудал эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо уг хэлэх гишүүдийн нэрийг авсан байна. Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням уг хэлнэ.

Г.Дамдинням: Мэргэжлийн боловсролын салбарын тухай хууль удаж, удаж бас орж ирж байна. Монгол Улсын Засгийн газраас Боловсролын тухай багц

хуулиудыг одоо 2 ч удаа өргөн бариад нэг удаа Засгийн газраас буцааж татаад, засаж янзлаад буцаагаад оруулж ирээд одоо ингээд Их Хурал дээр орж ирчихсэн байж байна. Энэ хууль бол нэн даруй яаралтай парламентаар орж ирж хэлэлцэгдэж батлагдах зайлиггүй шаардлагатай байгаа. Хуулийн төслүүд бол өнгөрсөн 4 дүгээр сар гэхэд үндсэндээ бэлтгэл ажил хангагдаад бэлэн болчихсон байж байгаа.

Энд харин нэг дутаад хүлээгдээд байсан хууль нь бол энэ Мэргэжлийн боловсролын хууль. Мэргэжлийн боловсролын хууль дээр ямар асуудал орж ирсэн байдаг вэ гэхээр түрүүн бас гишүүд ярьж байх шиг байна. Энэ салбар өөрөө Халамжийн яаманд очоод боловсролын биш мэргэжилтэй ажилтан ажиллах боловсон хүчин бэлддэг биш, халамж олгодог салбар болоод хувирчихсан байсан. Халамж олгодог салбар болгоод хувиргачихсаны бодит жишээ нь юун дээр байдаг вэ гэхээр түрүүн энэ Боловсролын сайд ярьж байна. Асар олон хүн төгсөөд байна гэсэн статистик байгаад байгаа мөртөөсөө нөгөө талд нь асар олон хүн ажилгүйдээд байна гэсэн ийм л статистик бид нар өнөөдөр хараад сууж байгаа юм.

Тэгээд ямар хүмүүс бэлдээд, юу хийгээд байгаа юм бэ гээд энэ салбарыг Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яаманд байхад нь шалгаад харахаар зэрэг Боловсролын яам руу шилжээд ирснийх нь дараа ямар асуудал үүссэн бэ гэхээр суралцагчдынх нь тоо эцэслэж гардаггүй. Өөрөөр хэлбэл Боловсролын яам нэг тоотой, Статистикийн хороо нэг тоотой, Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам нэг тоотой. Хүмүүсийнх нь нэр нь зөрдөг. Энэний цаана юу байгаа вэ гэхээр 200000 төгрөгийг зүгээр гоожуулаад идээд ууцагачихсан ийм л юм яваа байхгүй юу. Энийгээ алдахгүй гэж асар их тэмцэл болсон шүү дээ энд.

Энийг бол одоо Боловсролын яам хүлээж авахдаа шалгах хэрэгтэй. Засгийн газар энэ дээр анхаарал тавиад, төсвийн мөнгийг ингэж идэж уусан байгаа бол тодорхой гаргаж ирж зарлах хэрэгтэй. Энэ салбарыг цэгцэд нь оруулахын тулд энэ алдаанаас нь эхлэх ёстой юм байгаа юм түрүүн гишүүд хэлж байна лээ. Эргээд яагаад харахгүй байгаа юм гээд Дэлгэрсайхан гишүүн бол хэлээд байна лээ. Үнэн шүү дээ. Энэ нэг юмаа шалгах хэрэгтэй. Уялдаа холбоо байхгүй болчихсон байгаа одоо. Би зүгээр жишээ хэлье. Дархан-Уул аймагт 3 Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв байна. 3-уулаа үсчний ангитай, 3-уулаа тогоочийн ангитай, 3-уулаа гагнуурчны ангитай. Аль ч анги нь дүүрдэггүй, тэгээд гурвуулан дээр нь гагнуурчны тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт орно, үсчний хэрэгслийн хөрөнгө оруулалт орно, бүгд дээр нь багш байна, бүгд дээр нь сургалтын лаборатори байна. Ямар ч үргүй зардал байхгүй юу, тийм.

Үнэхээр энэ одоо энэ яамандаа үнэхээр бодлого байсан юм бол энийг ингэж яагаад хайран зардал гаргаад яваад байсан юм бэ. Тэгэхээр одоо энэ шинэ орж ирж байгаа хууль дээр бол бид нар энийг бас онцгой анхаарч янзлах хэрэгтэй. Түрүүн тэр ярьж байна лээ. Бас салбарт нь өгнө гээд Боловсролын сайд яриад байна лээ. Тэр бол бас жоохон учир дутагдалтай шүү. Төр өөрөө энэ дээр бодлогоо хийх хэрэгтэй. Аль газар юуг дэмжих ёстой юм. Тэгэхгүй бол бас энэ хаана хамаагүй явуулаад байж болохгүй. Ажлын байран дээрээ дадлага хийгээд ингээд сурчихсан хүмүүс байдаг. Энэ хүмүүсийг зүгээр шалгалтаа өгөөд үнэмлэхээ аваад зэрэг цолоо ахиулаад явдаг энэ боломжоор нь хангадаг зохицуулалтыг хийх хэрэгтэй.

Насан дээр хязгаар тавья гээд түрүүн дуугараад байна лээ. Нас, хүйс дээр хязгаар тавих гэхээсээ илүүтэй тухайн мэргэжил дээр нь одоо харж үзэж, өөрчлөлтүүдийг зохион байгуулж

хийж болох ёстой байх. Түүнээс биш жигдэлж бол насны хязгаар тавина гэж бол болохгүй. Эцэст нь хэлэхэд бол энэ салбар 10 жил тэнэж явж, явж өөрийнхөө өнгө төрх, үндсэн зорилгоо алдсаны эцэст арай гэж нэг юм боловсролынхоо салбарт буцаж ирлээ. Энэ салбарын одоо үндсэн ажил бол хөдөлмөрийн зах зээл дээр уялдсан ийм бодлого хэрэгжүүлэх ёстой. Манай зарим гишүүд хэлж байгаа. Энэ Эдийн засгийн яам, Боловсролын яам 2 бол хамтарч ажиллах ёстой гэдэг утгаар ярьж байна лээ. Энэ нь бол зөв.

Тэгээд би одоо энэ боловсролын багц хууль дээр ажиллаад явж байгаа, энийг бас Байнгын хорооны дарга хийж байх үедээ ингэж бэлдэж явж байсан гишүүний хувьд бол энэ дээр нэлээн хичээл чармайлт гаргаж ажиллана. Боловсролын багц хуулийнхаа хүрээнд энийг хэлэлцээд батлах нь зөв. Тийм болохоор өнөөдөр хэлэлцэх эсэхийг нь шийдээд ажлын хэсэг дээрээ энэ саяын яригдаад байгаа, гишүүдийн хэлээд байгаа асуудлуудыг янзалж цэгцлээд, дээд боловсрол болон бас ерөнхий боловсролтойгоо хэрхэн уялдах юм, үе шаттайгаар бас ингээд нэг дор тасралтгүй сураад, үргэлжлээд явах гэхээсээ илүүтэй тодорхой хугацаанд сураад, ажил дээр гараад, буцаад тодорхой хугацаанд сураад, ингээд өөрийгөө сайжруулаад явдаг энэ боломжоор нь хангах зэрэг асуудлуудыг бид нар ажлын хэсэг дээрээ ярьж шийдэх ёстой юм байгаа юм. Тэгээд энэ хуулийг хэлэлцэх эсэхийг дэмжиж байна.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг үг хэлнэ.

Ё.Баатарбилэг: Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа. Мэдээж түрүүн миний хэлсэн энэ мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад байгууллагын суралцагчдад олгох тэтгэлгийн асуудал, энэ тэтгэлгийн хэмжээ, хамрах хүрээ,

энэ суралцагчдын насны хязгаар, тэгээд суралцах хугацаа, дээр нь одоо энэ сургалтын үнэлгээ, баталгаажуулалт, сургалтын чиг үүрэг гээд маш олон юмнуудын зохицуулалтууд энүүгээр орж ирнэ.

Нөгөө талаараа энэ мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн багш, ажилтан албан хаагчдын нийгмийн баталгаа, мэргэжил боловсролоо дээшлүүлэхтэй холбоотой ямар дэмжлэг туслалцаа урамшуулал юмнууд байх юм бэ гэдгийг бас нэлээн сайн харах нь зүйтэй байх. Яагаад гэвэл энэ орхигдчихсон. Боловсролын салбар, багш нарын асуудал гэж ингээд яваад байсан. Тэгж байтал яг энэ Хөдөлмөрийн яамны харьяанд байсан 10 жилийн хугацаанд МСҮТ-н багш нарын асуудал орхигдчихсон байхгүй юу. Тэгэхээр энэ бол одоо ингээд салбартаа ороод ирсэн учраас яг жишиг бусад багш нарын одоо ямар дэмжлэг, урамшуулал, нийгмийн баталгааны юм байдаг юм тэрийгээ бол одоо хамрагдаад явах тал руугаа явах байх гэж бодож байгаа.

Хөрөнгө оруулалтын асуудлууд одоо ямархуу байгаа вэ гэдгийг одоо сайд хүлээж авч байгаа учраас нэг удахгүй мэдээлэл юмнууд авах байх. Яагаад гэвэл МСҮТ-н бас хөрөнгө оруулалтын юмнууд гээд яг улсын төсөвт МСҮТ байж байна, хувийн МСҮТ байгаа. Тэрний нөгөө барилга байшин, нөгөө материаллаг бааз, техник тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн энэ тэр нь ямар байгааг одоо бид үндсэндээ бол мэдээлэл алга байна. Тэгэхээр энэ бол үндсэндээ орхигдчихсон байгаа учраас энэ дээрээ бол бас сайд анхаарах байх.

Би Гадаад хэргийн сайдаас асууж асуулга авч материал авсан. Ноднин жил гадаадад элчин сайдаар томилогдож байгаа сайд нарт би нэг зүйл хэлсэн юм. Энэ гадаадад элчин сайдаар томилогдож байгаа хүмүүс энэ боловсролын салбарын хамтын ажиллагаа, ялангуяа гадаадад энэ өндөр хөгжилтэй Англи, Герман

хэлтэй орнуудад сууж байгаа элчин сайдууд Монголынхоо залуучуудыг энэ гадаад орнуудын янз бүрийн тэр тэтгэлэгт шугамаар сургах боломжуудыг их нээж өгөх тал дээр хамтарч ажиллаач, нэлээн сайн идэвх гаргамаар байна. Ялангуяа Их Британи, Англи, Герман, Австрали зэрэг улсуудын юмыг нэг та нар нэг жаахан судлаадхаач. Америк. Тэгээд надад ирүүлсэн мэдээллээр нэг энэ 4 улсын 43 чиглэлээр ажилласан гэсэн ажлын юм ирж байна. Энэ дотор хамгийн сайн ажилласан нь бол Австрали ажилласан юм байна гэж харж байна. 23 чиглэлээр яг энэ боловсролын хамтын ажиллагааг ярьсан байна.

Боловсролын хамтын ажиллагаа дотор энэ жишээ хэлэхэд Шинэ Өмнөд Вэйс муж техник мэргэжлийн боловсролын байгууллагын харилцааны гадаад харилцааныхантай яриад манайхаас мэргэжлийн боловсролын түвшинд холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоож, Монгол оюутнуудад чиглэсэн төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллая гэдэг байр суурь илэрхийлсэн гэж МСҮТ-тэй холбоотой жишээ хэлэхэд. Энийг яагаад яриад байгаа юм гэхээр Засгийн газар дээрээ Боловсролын сайд өөрөө энэ гадаадад суугаа элчин сайдуудтай энэ боловсролын хамтын ажиллагаа, өөр өөрсдийн суугаа орнуудад ямар боломжуудыг нээж байна гэдэг тал дээр бол Гадаад хэргийн сайдаар энэ элчин сайдуудад нь бас чиглэл өгүүлж, энэ тал руу нэг жаахан хумьж ажилламаар санагдаад байгаа юм.

Гадаадад очоод томилогдоод суучихдаг. Тэгээд тухайн оронд нь очсон Монголчууд өөрсдөө ингээд шалгаж шүлэг өгөөд тэнд нь очоод ажил төрөл хийгээд, өөрсдөө төлбөрөө төлөөд л ингээд ажил юу мэргэжил боловсрол эзэмшээд орж ирж байгаа юм. Тэгж байтал яг одоо төр засгийн шугамаар ингээд хөөцөлдөх юм бол маш олон боломжууд байдаг. Манай залуучууд

заавал ч үгүй тэр ажил хөдөлмөр хийж олсон хэдэн төгрөгөөрөө тэр төлбөрийг нь төлж, ингэж сурах шаардлагагүйгээр тэтгэлэгт хөтөлбөрүүд маш их байдаг. Энийг нь манай элчин сайдууд суугаа суугаа орныхоо тэр засаг төрийн байгууллагуудтай хамтраад, их дээд сургуулиудтай нь хамтраад ингээд боломжуудыг нь нээж өгөх тал дээр ажилламаар байгаа байхгүй юу.

Энэ дээр бол одоо яг тэр элчин сайдуудаас ирсэн материал дээр бол Герман, Америк энэ тэр бол жаахан хангалтгүй л байна. Зүгээр нэг ийм санал солилцоо, солилцоо гэсэн 5, 6 юм л байна. Хамгийн их идэвхтэй ажилласан, бүр санамж зурсан хүн түрүүч оюутнууд нь очоод сурч байгаа гээд нэг одоо Австралид жишээлэхэд ингээд 9 сарын 1-ний байдлаар зуун залуу Австралид очсон, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаад ингээд суралцаад байж байна гэх зэргээр ийм бодит үр дүнтэй улсууд байж байна. Тэгэхээр энэ тал руу бол Боловсролын сайд, Гадаад хэргийн сайдтайгаа хамтраад энийг нэг элчин сайдуудыг нэг жаахан боловсролын хамтын ажиллагаа тал руугаа боломжуудыг нээж өгөх тал руугаа нэг жаахан идэвхтэй ажиллаасай гэж хүсэж байна. Энэ дээр мэргэжлийн боловсролын асуудал ч боломжтой юм байна гэдэг нь саяын Австралийн нэг жишээгээр бол харагдаж л байна л даа. Тэгэхээр ийм нэг хэдэн саналууд байна. Тэгээд Мэргэжлийн боловсролын хуулиа одоо яаралтай хэлэлцээд, нөгөө Боловсролын ерөнхий хууль, багц хуулийнхаа.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Батжаргал гишүүн алга байна уу. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг үг хэлнэ.

М.Оюунчимэг: Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв энэ коллежтой холбоотой хуулийн төслийг хэлэлцэх эсэх орж ирж байна. Энийг бол маш удаан хүлээсэн. Бас Их Хурлаар орж ирээд одоо хэлэлцэх гэж байгаад бол үнэхээр бол баярлаж байна. Тэгээд энэ

хамгийн гол нь нэг ярьж байгаа хүмүүс нь яам хоорондын хэрүүл юм шиг, эсвэл нэг тэр сард өгч байгаа тэтгэлэгтэй нь холбоотой юм шиг ингээж жишгээр бас асуудалд хандаж болохгүй л дээ. Бид харж байгаа дээр үед тэр ТМС гээд явж байхад яг нэн хэрэгцээтэй мэргэжлээр хэдэн зуугаар нь гадаадад хүртэл сургаад, өнөөдөр Монголын бүтээн байгуулалтыг босгоход гол үүрэг гүйцэтгэсэн хүмүүс чинь тухайн үеийн тэр ТМС төгссөн хүмүүс шүү дээ.

Энд юу вэ гэхээр зүгээр л төр засгийн бодлогын уялдаа холбоо маш сайн байсан. Би анх Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга болчиход энэ бүх коллеж, МСҮТ-н захирлуудыг Улаанбаатар хотод авчраад бүгдээрээ суугаад уулзаад бүх ажил олгогчдын төлөөлөл оролцоход 33000 ажлын байр бидэнд хэрэгтэй байна. Ингэхдээ яг энэ, энэ чиглэлээр судалгаагаар гарсан гээд. Одоо жишээлбэл уул уурхай, хүнс, үйлчилгээ ч гэдэг юм уу ингээд гарч байсан. Бид салбарын сайдад нь бас энийг өгч байсан. Одоо үр дүн нь гарсан, гараагүйг би мэдэхгүй байна л даа. Тэгэхээр өнөөдөр нэг л МСҮТ-ийг Боловсролын яаман дээр авчирчхаад бүх юм сайхан болчих юм шиг асуудал бол биш л дээ.

Дээрээс нь Энх-Амгалан сайд бас анзаарч мэдэж байгаа байх. Өчигдөр тэр Ражив Гандийн нэрэмжит коллежийн захирал ярьж байна лээ л дээ. Энэ сар бүр 200000 төгрөгийг өгөхөө байсан. Төгсөхөд нь өгнө гэж хэлсэн ч манай элсэлт огт буураагүй, зуу хувьтай байгаа. Ингэхээр энэ 200000 төгрөгийн тэтгэлэг гол нь биш. Харин хүмүүс яг эрэлт хэрэгцээтэй юм уу, сонирхсон мэргэжлээр, эсвэл үнэхээр сайн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, коллежид сурах хүсэл сонирхол байна гэдгийг хэлж байна. Тэгээд одоо их дээд сургууль төгссөн 30 хүн тутмын нэг нь л арай хийж ажилтай болж байхад Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, коллеж төгссөн 6 хүн тутмын нэг нь

шууд ажилтай болж байгаа, захиалга ч нэмэгдэж байгаа. Тэгэхээр асуудал нь энэ тэтгэлэг ч юм уу, энэ нэг яам хооронд бол биш гэдгийг мэргэжлийн хүмүүс нь судалгаагаар тайлбарлаад, тэр салбарын эрдэмтэд, мэргэд нь хэлээд байна л даа.

Тэгэхээр бид өнөөдөр Улсын Их Хурал дээр энэ хуулийн төслийг хэлэлцэхдээ энд бол маш сайн анхаарах хэрэгтэй. Өнөөдөр орон нутагт малчид байхгүй болчихлоо, туслах малчид гээд л байна. Хамгийн сүүлийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар бол Монгол Улсад хамгийн нэн эрэлт хэрэгцээтэй мэргэжил юу байна гэхээр сувилагч, бага ангийн багш, ИТ технологи гээд л энэ яг гараад ирж байна шүү дээ. Тэгвэл энэ чиглэлийн мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүд, коллежуудаа илүү бодлогоор дэмжих, тэнд суралцагчдыг нь харин ч тэтгэлгийг нь сар бүр нь ч юм уу ер нь өгөөд явчих ч гэдэг юм уу ингээж асуудлыг томоор хараад, хөдөлмөрийн зах зээлтэйгээ уяж энэ асуудлыг шийдэх нь өөрөө маш чухал байгаа юм. Би энэ хуулийг нэг нэг уншсан, бас энэ хууль дээр ажиллаж байгаа хүмүүстэй ч ингээд уулзаж байхад бид нарт бас засаж залруулах зүйлүүд их байна.

Ялангуяа зохион байгуулалт, бүтэц. Нөгөө их дээд сургуулиудыг магадлан итгэмжлэгдсэн гэдгээр үнэхээр сайн сургуулиудыг нь дэмжээд тэр явчихдаг, таарууг нь тэгээд лиценз асуудалтай нь ярьдаг шиг мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүд, тэр коллеж дээр стандартын шаардлага хангахгүй байгаа, тэр зүгээр 200 дээр нь тоглолт хийж байгаа энэ тэрийг амархан шүү дээ. Судалгаа шинжилгээ, шалгалтууд явуулаад тэр Боловсролын хяналтын газар нь юм уу, тэгж байгаад л энэ МСҮТ үнэхээр чухал байна, энийг бодлогоор дэмжье гээд тэгээд явж байх бололцоо энэ цөөхөн газар бол маш боломжтой асуудал байхгүй юу. Энэ нэг их толгой өвдөөд, санаа зовоод байгаа зүйл шаардлагагүй шүү дээ. Одоо үнэхээр ингээд орон нутагт, тойргууд дээр

хүртэл бид нар ажиллаад явж байхад би өнөөдөр Герман, Монголын техникийн институтэд суралцмаар байна. Би тэндээс маш сайн гагнуурчин ч юм уу, маш сайн хүнд даацын жолооч болоод гармаар байна. Түүнээс би их дээд сургуулийг сонирхохгүй байна гэж байна шүү дээ.

Тэгж байгаа тохиолдолд жишээлбэл заавал малчин болох хүсэлтэй, үнэхээр мундаг тогооч болох хүсэлтэй хүнийг 12 жил тэнд сургуульд сургаад, тийм ерөнхий боловсролын бүх мэдлэгийг эзэмшүүлээд явах шаардлага байна уу үгүй гэдэг. Өнөөдөр бидэнд юу хэрэгтэй байна вэ гэхээр хамгийн гол нь ажлын байр. Яг энэ мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, энэ их дээд сургууль төгсөж байгаа хүмүүс хөдөлмөрийн зах зээл дээр гараад шууд ажилтай болох дээр л төр бодлогоор дэмжиж, тийм үнэхээр боловсон хүчин бэлдэж байгаа мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг нь, тэд нарыг нь одоо бид нар санхүүжилтийг нь шийдээд явчих хэрэгтэй байна л даа. Тэгж асуудал дээр ингэж хөрсөн дээр нь бууж хандах хэрэгтэй байна.

Бид нар 2008-12 онд жишээлбэл, тухайн үед одоо би Засгийн газрын Хэвлэл, мэдээллийн албаны даргаар ажиллаж байх үед том, том уурхайнууд, том ААН-үүдийн хажууд МСҮТ-ийг ажиллуулаад, тэгээд тэдний захиалгаар хүмүүсийг нь сургаад, гарч ирэнгүүт нь шууд тухайн ААН-үүдэд ажил руу ороод ингээд явж байсан. Өнөөдөр Оюу толгойд ажиллаж байгаа хүмүүсийн дийлэнх нь эд нар байгаа л даа. Тэгэхээр нөгөө нэг яаж уях вэ, ААН-үүдтэйгээ уях, ажил олгогчтойгоо уях, тэгээд мэдээж яг боловсролд нь ямар мэргэжлийг тэр мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, коллежид түлхүү заах уу, энийг санхүүжилтийн бодлогоор яаж дэмжих вэ гэдэг нь өөрөө маш чухал байгаа. Энэ дээр бол яамд хоорондын уялдаа холбоо бол маш чухал. Ганц Боловсрол, шинжлэх ухааны яам биш ганц Хөдөлмөр,

нийгмийн хамгааллын яам биш. Түүрүүн гишүүд хэлж байна Гадаад харилцааны яам, Эдийн засгийн яам.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Чинбүрэн гишүүн алга байна. Улсын Их Хурлын гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан үг хэлнэ.

Б.Дэлгэрсайхан: Ингээд энэ мэргэжил сургалтын төв мөн одоо мэргэжил боловсрол олгох энэ хуулийн төслийг бол зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Тэгээд манай Боловсролын сайд маань сууж байгаад одоо энд сууж байгаад талархаж байна. Тэгээд хэдэн асуудлыг одоо бас захиж хэлье гэж бодоод байгаа юм.

Юуны өмнө энэ МСҮТ коллежуудад сурч байгаа хүүхдүүд энэ авч байгаа тэтгэмж, энэ бүх зүйл бол энэ дандаа энэ компаниудын татвараар, татвар төлөгчдөд бидний мөнгөөр санхүүжигдэж байгаа. Тийм учраас энэ компаниудаас захиалга авдаг ийм юм руу нь оруулах хэрэгтэй. Ер нь бол бараг хуульдаа ч энийг тэгж тусгах нь зөв болов уу гэж бодож байгаа юм. Тэрнээс биш зүгээр нэг одоо хүүхдээ нэг ингээд нэг энэ ч дээ одоо ер нь явахгүй нь дээ гэнгүүт нь аваачаад МСҮТ рүү оруулчихдаг нэг ийм юм. Үгүй ээ, одоо бид нарын үед ч гэсэн ялгаагүй л ийм л байсан л даа ер нь бол одоо. Тэгээд ийм биш, бас энэ чинь одоо хүн л юм чинь бас ийм юу байдлаар хүүхдүүдийг өөрийнх нь урам бий болгох талд нь бас анхаарч, энэ компани захиалгаа өгөөд, тэгээд компани өөрөө энэ хүүхдийг бид сургаж авъя гэдэг ч юм уу, ийм юмыг оруулах нь зөв болов уу гэж бодож байгаа.

Хоёрдугаарт, багш нарын чадавх маш муу байгаа юм. Энх-Амгалан сайдаа энэ багш нарыг бэлтгэх асуудал дээр онцгой анхаарч өгөх ёстой. Ялангуяа МСҮТ, коллежид энэ мэргэжлийн сургалт хийж байгаа жишээлбэл, энэ техникийг хэрхэн жолоодох барих, дээр нь энэ баяжуулах үйлдвэрт гар хөлөө хавчуулчихгүй яаж ажиллах, тэгээд энэ

өөрөөр хэлбэл наад зах нь л уурхайнуудад энэ аюулгүй ажиллагааны ажилтан хүртэл ингээд хэрэгтэй байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм мэтийн юман дээр нь онцгой анхаарч өгөөч. Тэгээд энэ өгч байгаа 200 мянгийн тэтгэлгээ сурч байгаа тэр кредит цаг, хичээлдээ сууж байгаа байдал, мөн энэ дадлага хийсэн байдал энэ тэр зэрэгтэй нь холбож олговол яасан юм бэ? Тэгж байж одоо нэг ийм юу нь би, одоо би нөгөө 200000 төгрөгийнхөө тэтгэлгийг бол яг ингэж авах юм байна гэдэг ийм юутай болно. Ойлголттой болно. Тэгэхгүй зүгээр нэг ирж бүртгүүлээд, тэгээд алга болж, болж нэг эцэст нь нэг хавтас авна, авахын төлөө ингээд мөнгө аваад байгаад нь үнэхээр харамсаж байна. Хайран ч мөнгө яг үнэндээ бол.

Хамгийн сүүлд нь хэлэхэд бол энэ 2050 одоо хөгжлийн бодлоготойгоо уялдуулаад энэ орон нутгийг зааглаж ялгах хэрэгтэй байгаа юм. Яагаад вэ гэхээр нөгөө уул уурхай хөгжиж байгаа аймгуудад нь энэ чиглэлийн МСҮТ, коллежоо байгуулах. Энэ хөдөө аж ахуй хөгжиж байгаад нь бас энэ чиглэлийнх нь МСҮТ, коллежийг нь байгуулна гэдэг ийм зааглаж ялгаж одоо бүсчлэхгүй бол тэгээд хаана хамаагүй тэгээд үсчин, тогооч гээд л яваад байвал одоо энэ чинь тэгээд Монголоор дүүрэн үсчин, тогооч боллоо шүү дээ. Тийм учраас энийг бас хуульдаа бас ингэж оруулах нь хаашаа юм, зүгээр манай Боловсролын яам энэ дээр бас журмаа гаргахдаа ингэж гаргавал зүгээр юм уу гэсэн ийм санал хэлж байгаа юм шүү. Тэгээд энийг одоо бас манай Энх-Амгалан сайд бас хүндэтгэлтэй хүлээж авах байх гэж итгэж байна. Тэгээд хуулийг бол одоо дэмжиж байгаа. Тийм учраас бол энэ хууль хийх бол одоо нэг асуудал, яг амьдрал дээр энэ одоо татвар төлөгчдийн мөнгийг бас зөв зарцуулахад анхаараач, тийм гэдэг ийм асуудлыг тавимаар байна. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя гишүүдээ. Улсын Их Хурлын

гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалангийн урилгаар Говь-Алтай аймгийн Төгрөг сумын ЕБС-ийн 1990 оны төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Өвөө маань Сурмаажавын Монгол гэдэг Говь-Алтай аймгийн харьяат хүн байсан. Эрхэм та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен үг хэлнэ.

Б.Бейсен: Энэ мэргэжил сургалт, үйлдвэрийн төвийн одоо сургалтын талаар хуулийн төсөл оруулж ирж байгаа нь сайн сайшаалтай хэрэг байна. Энэ МСҮТ бол Боловсролын яаманд очиж байгаа нь бас сайд нь бас юмаа шуурхай шийддэг, шударгаар шийддэг, асуудалд бас зөв талаас нь ханддаг учраас энэ хуулийн төсөл хэрэгжих байх гэж бодож байна. Энэтэй холбоотой нэг хэд хэдэн санал хэлье гэж бодож байгаа юм.

МСҮТ төгссөн дөчөөд мянган хүн ажлын байргүй гэж байна. МСҮТ дээр ямар хүн ордог вэ гэвэл одоо энэ дарга нарын юм уу, төсөвт байгууллагад ажиллаж байгаа улсуудын хүүхдүүд сурдаггүй л дээ. Ядуу айл өрхийн хүүхэд, малчдыг хүүхэд л сурч байгаа нөгөө сургалтын төлбөр чаддаггүй, аль эсвэл ядуу айл өрх нь тэр нэг 200000 төлбөрт нь яагаад хүүхдээ сургаж байгаа ч тохиолдол байгаа юм. Тийм учраас энэ дээр нэлээн анхаарч сургалтын чанар дээр анхаараад түрүүн Дэлгэрсайхан гишүүний ярьдгаар багш нарын чадварыг сайжруулаад, нөгөө талаар бэлдэхдээ бас нэг төрлийн тогооч, үсчин гэхгүйгээр одоо шаардлагатай, жишээлбэл барилгын засал чимэглэлийн чанартай сургах ч юм уу, нөгөө талаараа бол явган хүний зам бэлдэх хавтгай блок бэлдэх чиглэлээр ч юм уу, хүнсний бүтээгдэхүүн савлах, бэлдэх, савлах асуудлаар ч юм уу, тэгээд л малын сүү сүүн бүтээгдэхүүн бэлдэх талын ч юм уу, тийм нарийн мэргэжил, сантехникийн одоо цэвэр бохир усны слесарь гэдэг ч юм уу,

судалгаа авч байгаад яг бодитой төлөвлөгөөтэй сургахгүй бол нэг чиглэлээр сургаад байхаар чинь аргагүй тэгээд ажлын байр нь ч олдохгүй ийм байдалд хүрээд байна л даа. Тийм учраас энэ дээр нэг анхаарч ажиллана уу гэсэн санал хэлье.

Тэгээд нөгөө талаар энэ МСҮТ урьд нь одоо МСҮТ төгссөн, онц төгссөн улсуудыг техникум коллеж, их дээд сургуульд ингээд дамжин суралцуулдаг юутай байсан. Энийг бас уламжил болгоод дахиж одоо цаашаага дэвшүүлэн сургах асуудал яриа бол энд бас олон хүүхэд хамрагдаад бас чанартай боловсон хүчин гарах байх гэж бодож байна. Энэ талаар анхаарч ажиллана уу гэсэн санал хэлье.

Т.Аюурсайхан: Ингээд тийм 5 гишүүн дэмжсэн, дэмжээгүй үг хэлсэн байгаа. Одоо Улсын Их хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьяаа үг хэлнэ. Тэгээд санал хураана гишүүдээ.

Ш.Адьяаа: Энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа юм. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энэ хуулийн төсөл 21 онд орж ирээд унаж байсан. Тэгээд өнөөдөр энэ Боловсролын яам энэ хуулийн төслийг Засгийн газраас өргөн барьж оруулж ирж байна. Энэ хуулийн төслийг бид зайлиггүй баталж гаргах ёстой. Энэ дээр санал нэг байна. Энэ Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамнаас оруулж ирсэн төслөөс зарчмын хувьд Боловсролын яам зөв бодлого боловсруулж орж ирсэн байна гэсэн ийм ойлголттой байна.

Хөдөлмөрийн зах зээл дээр Монгол иргэнийг ажиллах нөхцөлийг, Пүрэвдоржоо энэ үгээ ярьчихъя, чимээгүй байгаарай. Энэ нөхцөлийг бүрдүүлэх энэ хуулийг бид маш их хариуцлагатай, маш их бодлоготой, энэ асуудлыг ярьж хэлэлцэх ёстой, ингэж шийдэх ёстой. Энд нэг л асуудал байгаа юм. Энэ мэргэжлийн сургалт үйлдвэрийн төв, энэ политехник коллежийн

удирдлага, засаглалын асуудлаас энэ хамгийн их замхарч байгаа. Энэ татвар төлөгчдийн мөнгийг энд одоо янз бүрийн хэлбэрээр зарцуулж, тэр Монгол мэргэжилтэй ажилтан бэлтгэж байна гэдэг нэрийдлийн дор үр дүнгүй үйл ажиллагаа явуулж байснаас мэргэжлийн, сургалт үйлдвэрлэлийн төв, политехник, коллежийн удирдлага, засаглалын асуудал дампуурснаас өнөөдөр энэ мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх энэ бодлого маань 2 толгойтой могой шиг болж явсан. Нуух юм бол байхгүй.

Энд багш нарын нэг Боловсролын яам хариуцдаг ч юм шиг, засаглалыг нь бол Нийгмийн хамгааллын яам хариуцдаг ч юм шиг. Тэгээд энэ хувьсах зардлыг хуурамчаар бүрдүүлж, сургалтын төлбөрийг хууль бусаар авдаг, ийм одоо асуудлууд гарч ирсэн. Энийг одоо Боловсролын яам цаашидаа энэ бодлогыг сургалтын хувьд Монгол иргэнийг бэлтгэх бодлогын хувьд энэ хуульд зааснаар авч явах ёстой. Удирдлага, зохион байгуулалт, удирдлагын засаглалын асуудлыг Боловсролын яам шууд шийддэг энэ хуулийн эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгөх ёстой. Ингэж байж бид өнөөдөр чанартай багш, мэдлэгтэй, зүтгэлтэй, хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай, мэдлэг боловсролтой ийм Монгол иргэнийг бэлтгэх энэ төрийн бодлого чинь энэ хуулиар дамжиж биелэгдэх ёстой гэж бодож байгаа.

Тэгээд энэ сургалт үйлдвэрлэлийн сургалтын асуудал, бодлогын асуудал, Монгол хүнийг бэлтгэх ас асуудал бол өнөөдөр зүгээр нэг урсгалаар явж байгаа. Урсгалаар явж байгаа юм. Тэнд засаглал гэж байхгүй, боловсролын бодлого гэж байхгүй, чиглэл гэж байхгүй. Цаашаа төлөвлөгөө гэж байхгүй. Энэ зах зээлд бэлтгэж байгаа ажилчин чинь хаана ажиллах юм, ямар хөдөлмөрийн зах зээл байгаа гэдгийг нь судалгаа дээр тулгуурлаж байж энэний элсэлт бусад

зүйлийг авч шийдэж байж өнөөдөр энэ бодлого чинь хэрэгжинэ.

Тэрнээс биш одоо энэ политехник коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрийн төвд элсэгчдийг зүгээр л бодлого биш зүгээр одоо юу гэж ярих юм, тийм таамаг маягаар ингэж баахан юм бэлддэг. Тэгээд тэр нь эргээд зах зээлд ажилладаггүй, ажиллах нөхцөл бүрдүүлдэггүй, тэгээд өнөөдөр хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах боловсон хүчин үнэхээр хомсдолтой байна. Энэ дээр одоо энэ хуулийн төслийг хэлэлцэх явцад энэ саналуудаа бид яриад явах ёстой. Ийм байдлаар бид өнөөдөр энэ хөдөлмөрийн зах зээл дээр Монгол иргэнийг төлөвшүүлж ажиллах ийм нөхцөлийг бүрдүүлэх, энэ хууль, эрх зүйн орчин, орчноор дамжуулж төрийн бодлогыг явуулахаас хамгийн чухал байгаа юм.

Боловсролын яамнаас оруулж ирсэн энэ хуулийн төслийг бид дэмжиж байгаа. Өнөөдөр Боловсролын яам бол бас Монгол иргэнийг төлөвшүүлэх, Монгол хүний сургалтын асуудал дээр бас тодорхой бодлоготой асуудлуудыг дэс дараалан явуулж байгаа гэдэг дээр би санал нэг байгаа. Энийг дэмжиж цаашдаа энэ мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв гэдэг энэ байгууллагын засаглалыг, тэр боловсон хүчний бодлогыг сайжруулахын тулд Боловсролын яам энд манлайлж ажиллана гэдэгт итгэлтэй байна. Тэгээд энэ хуулийн төслийг.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Багийн хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай

хуульд нэмэлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна гишүүдээ. Үйлдвэржилтийн байнгын хорооны гишүүд танхимд яаралтай хүрэлцэн орж ирээрэй, Тамгын газраас. Дээрээс нь төсвийн, Төсвийн ажлын хэсгийн гишүүд яаралтай орж ирээрэй. Үйлдвэржилтийн байнгын хороон дээр.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг, Төмөрбаатарын Аюурсайхан, Жамъянхорлоогийн Сүхбаатар нарын урилгаар Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Гишүүдээ санал хураалт явуулъя. Саналын томъёоллыг танилцуулсан, хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Саналаа. 72 хувийн саналаар дэмжигдлээ. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БСШУС-ын байнгын хороонд шилжүүлж байна.

16.16 цагт

Дараагийн асуудалдаа оръё эрхэм гишүүдээ. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг төсөл санаачлагчийн хүсэлт гаргасан тул өнөөдрийн хэлэлцэх асуудлын дарааллаас хойшлуулж байна. Дараагийн асуудал.

Тав. “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хүний эмийн чанарын асуудлаарх хянан шалгах түр хороо/

Хянан шалгах түр хорооны юу, Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн хүрээнд Хүний эмийн чанарын асуудлаарх хянан шалгах түр хороог байгуулах тогтоол баталсан билээ. Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд тус хянан шалгах хорооны бүрэлдэхүүнээс гарах хүсэлтээ ирүүлснийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу Байнгын хороо 2022 оны 10 сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Байнгын хорооны гишүүд асуулт асууж, үг хэлээгүй бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтыг үндэслэсэн Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандыг түр хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөх санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн тул Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Т.Аюурсайхан: Байрандаа сууж байгаарай гишүүдээ. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд асуулт асууж, үг хэлнэ.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр үг хэлэх гэсэн юм. Энэ нөгөө өөрийнхөө саналаар энэ түр хорооноос нэрээ татаж байгаа юм шиг ийм ойлголт бол явчих шиг боллоо. Тэгээд ийм ойлголт бол байхгүй шүү. Яг ямар үндэслэлээр хасагдаж байгаа юм бэ гэхээр өнөөдөр нэг Улсын Их Хурлын гишүүн 3 түр хороонд л ажиллах боломжтой юм байна. Тэр нь болохоор олонход биш юм байна, цөөнхөд юм байна. Тэгээд нөгөө цөөнх чинь ийм цөөхөн парламент, давжаа парламент. Тэгээд ийм болохоор бид нар энэ цөөнхийнхөө гишүүдийн тооноос хамаараад маш их хязгаарлагдмал ийм түр хороог ажиллуулах боломж боломжтой юм байна шүү Их Хурлын гишүүдээ.

Өөрөөр хэлэх юм бол бид нар сая бүтэн жилийн турш л ярьсан. Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт хийе, парламент чинь хэтэрхий давжаа байна, жижигхэн байна, хяналтаа тавьж чадахгүй байна. Тэгээд хууль боловруулахад бас чанартай хууль гаргаж чадахгүй байна. Тийм болохоор Улсын Их Хурлын гишүүдийн тоог өсгөх шаардлагатай байна гээд байдаг бодит жишээ нь энэ шүү. Өнөөдөр маш их хэмжээний хулгайнууд гарч байгаа шүү.

Жишээ нь Хөгжлийн банкны 2 их наядын хулгайнаас авхуулаад, төмөр замын хулгай, маш олон хулгай, одоо тухайлбал энэ эмийн асуудлаар энэ төрийн эмийн мафийг яаж энийг арилгах юм бэ гэдэг асуудлаар би тухайлбал саналаараа энэ түр хорооны хянан шалгах түр хорооны гишүүн больё гээд орсон.

Харамсалтай нь уучлаарай та бол одоо ингээд 3 түр хороонд ажилладаг юм байна. 4 дэх нь бол боломжгүй юм байна. Тийм болохоор та нэрээ татаач гээд, ингээд процессын дагуу өнөөдөр орж ирж байгаа шүү. Үүгээрээ юу хэлж байна гээд тэгэхээр Монгол Улсын Их Хурал хяналт шалгалт хийдэг нэг л ийм боломж байна. Энэ бол хяналт шалгалт хийдэг түр хороо. Сайн зохицуулалт хийсэн. Харамсалтай нь бид нар ингээд шаардлагатай Улсын Их Хурал, парламентын зүгээс хяналт шалгалт тавих ийм шаардлагууд их байдаг боловчиг ийм давжаа парламентаас чинь, энэ цөөхөн гишүүдээс чинь болоод өнөөдөр хангалттай хяналт шалгалтаа хийж чадахгүй ийм нөхцөл байдал бодитой байна шүү, бодитой байна. Би эдийн засагч хүн. Тэгээд цаашаагаа маш олон энэ асуудлуудаар түр хороонд нь ороод цөөнхийнхөө хяналтыг тавиад, бас мэргэжилтэн хүний хувьд өөрийнхөө байр суурийг илэрхийлээд явъя гэсэн хүлээлттэй байлаа.

Гэтэл одоо ердөө гуравхан түр хороонд л та орж болно, үгүй бол болохгүй. Яагаад гэвэл цөөхөн гишүүнтэй, яагаад гэвэл энэ сөрөг хүчин цөөнх чинь хэтэрхий цөөхөн байна гээд. Ингээд манай Улсын Их Хурлын хянан шалгалт хийдэг гар чинь ингээд мухардаад байна шүү дээ. Тэгээд ийм болохоороо цаашидаа бол бид нар энэ Хяналт шалгалтын түр хорооныхоо хуульд дахиж өөрчлөлт хийх юм уу, аль эсвэл одоо Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг эр зоригтойгоор хийгээд энэ парламентаа тоог нь өсгөөд, илүү Засгийн газрынхаа үйл ажиллагаанд, энэ томоохон хулгай луйвартаа хяналт

тавьж чаддаг ийм чадавхтай парламент болох чиглэлээр бид нар явах хэрэгтэй юм байна. Энэ асуудлыг бас энэ удаагийн хэлэлцүүлгээр яг энэ тохиолдол дээр эрхэм гишүүд маань сайн санаарай. Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал хөндөхөд бас энэ асуудлаа бас та бүгд бодож, шийдвэрээ гаргаарай гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн хамгийн түрүүнд баталсан хуулийнхаа хэрэгжилтийг хангаж, хууль дээдэлж ажиллана. Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа үг хэлнэ.

Ш.Адьшаа: Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдаад, анхны түр хороод байгуулагдаад, энэ хуулийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүд энэ түр хорооны үйл ажиллагааны дагуу 2, 3 түр хороо байгуулагдаад өнөөдөр бид энэ үйл ажиллагаа явуулж байгаа. Энд олон бэрхшээл байна, олон бэрхшээл байна. Хамгийн наад захын бэрхшээл гэхэд энэ хөрөнгө санхүүгийн асуудал байна. Бид саяхан энэ хилийн боомтуудын үйл ажиллагаа, тээвэр логистикийн үйл ажиллагаа шалгах Улсын Их Хурлын түр хороо Ховд, Баян-Өлгий аймагт ажилласан. Энэ томилолтын мөнгө гаргаж өгөхгүй байна. Хүмүүстэй уулзаж судалгаа хийх нөхцөл боломжоор Улсын Их Хурлын Тамгын газар хангаж өгөхгүй байна. Энэ нөхцөл боломжийг нь хангахгүйгээр энэ хуулийн хэрэгжилтийг яаж шалгах юм бэ, яаж энэ үйл ажиллагаа чинь явах юм бэ.

Тэгээд энэ ийм асуудлыг шийдэхгүй байж, зүгээр энэ түр хорооны үйл ажиллагаа гээд энэ саарал ордон дотор энэ Их Хурлын Тамгын газар эргэлдсэн ийм байдлаар энэ түр хорооны үйл ажиллагаа чинь явахгүй. Энэ хууль чинь хэрэгжихгүй байна. Онгоцны зардал олгох асуудал шийдэж өгөөгүй. Гишүүд бид хувийнхаа машинаар явсан. Ийм

байдлаар бид нар яаж өнөөдөр энэ хуулийн хэрэгжилт, энэ хууль зөрчсөн, энэ хулгай луйвар гарсан энэ схемтэй чинь бид яаж тэмцэх юм. Тэр хуульд заасан тэр хянан шалгагч, хэвлэл мэдээлэл, ил тод байдал, иргэдийг оролцуулах асуудал чинь өнөөдөр зүгээр нэг тунхгийн шинж чанартай байна.

Үнэхээр өнөөдөр энэ ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурал хяналт шалгалтынхаа хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулах боломжоор хангахгүй юм бол бид нар өнөөдөр ингээж худлаа түр хороо байгуулж, ажил хийсэн юм шиг, хийгээгүй ч юм шиг ийм байдалтай өнөөдөр байж болохгүй. Одоо Хөгжлийн банкны түр хороо байгууллагуудад ажил нь явагдаж байгаа. Энийг сунгах гэж байгаа гэсэн. 6 сарын хугацаатай түр хороо байгуулагддаг, энэ 6 сарын хугацаанд ажил хийх хөрөнгө санхүү бусад юмыг нь шийдэхгүй бол бид нар энэ хуулийг хэрэгжүүлбэ, энэ булхай луйврыг арилгая, ард түмнийхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүл гэдэг тухай ярихын ч аргагүй байгаа шүү. Өнөөдөр энэ улсын төсөв хэлэлцэж байна. Энэ түр хорооны үйл ажиллагаа, энэ хууль зөрчсөн үйлдэлтэй тэмцэх энэ дээр энэ хөрөнгө мөнгөнийхөө асуудлыг тавьж өгмөөр байна.

Дээр нь өнөөдөр энэ Улсын Их Хурлын гишүүдийн ажиллах нөхцөл боломжоор хангах талаар энэ төсөв дээр ч энэ асуудал ярьж өгмөөр байна. Бид нар өнөөдөр энэ 76 хамгийн муу хүн гэж ард түмэн нэрлэгдээд байгаа юм. Өнөөдөр энэ үйл ажиллагаа явуулах зардал мөнгийг нь шийдэхгүй байна шүү дээ бид нар. Хэмнэлтийн хууль гээд бүх зардлыг нь 2 дахин танасан. Тэгээд өнөөдөр дахиад энэ түр хорооны үйл ажиллагаа бид нар чинь энэ хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх, үүргээ биелүүлэх боломжоор хангахгүй байж бид нар ийм олон түр хороо байгуулж, худлаа ийм цаас үйлдвэрлэж, энэ саарал ордон дотор үлгэр ярьж явж яах юм бэ. Энийг энэ Улсын Их Хурлын удирдлага,

энэ санхүүгийн байгууллагууд энэ дээр дүгнэлт хийе. Үнэхээр бид нар хууль тогтоогчид, энэ хуулийг хэрэгжүүлэх гэж байгаа юм бол энэ бололцоогоо олгох асуудлыг шийдүүлбэ. Энэ дээр бол ийм одоо лоозонгийн шинж чанартай юм яриад л өнөөдөр ингээд үлгэр яриад л, муур хулгана болоод явахаа больё. Одоо та нар энэ дээр энэ шийдэж өгмөөр байна. Тэгэхгүй бол энд хий дэмий ийм юм ярьж яадаг юм.

Т.Аюурсайхан: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо санал хураана. Сая танхимд цугласан Улсын Их Хурлын гишүүд байраа эзлээрэй. Сая нөгөө Байнгын хорооны хэлэлцүүлэг дуусчихсан уу, завсарлалчихсан уу, дуусчихсан уу. Байнгын хорооны гишүүдийг дуудаарай. Энхтүвшин даргаа хэлэлцүүлэгтэй байсан. Гишүүд байраа эзлээрэй. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ нарын урилгаар Хэнтий аймгийн Хэрлэн сумын малчдын төлөөлөл болон спорт малчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Техникийн санал хураалт явуулж төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгая. Ирцэд байгаа гишүүд. Байраа эзлээрэй гишүүдээ. Санал хураалт явуулъя. Чинзориг гишүүнээ санал хураалт. 56.8 хувийн саналаар дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолыг уншиж танилцуулъя. Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1.Монгол Улсын Их Хурлын 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 21дүгээр тогтоолоор байгуулсан Хүний хүний эмийн чанарын асуудлаарх Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг нь үндэслэн Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржхандыг чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонсонд тооцлоо.

16.30 цаг

Зургаа. “Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг бүхий түр хороо/

Дараагийн асуудалд гишүүдээ. Хянан шалгах түр хорооны ажиллагааг ажиллах хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр юм уу? Баагаагийн Баттөмөр гишүүн танилцуулах юм байна.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хянан шалгах түр хорооны дарга Сүхбаатар 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Монгол Улсын Хөгжлийн банкны асуудлыг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай санал ирүүлснийг Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 11 дүгээр 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын хөгжлийн банкны асуудлыг хянан шалгах явцад нэмэлт нотлох баримт гаргуулан авах, тухайн нотлох баримтад шинжээч томилон ажиллуулах зэрэг зэрэгт тодорхой хугацаа шаардлагатай байгаа талаар саналыг үндэслэн Эдийн засгийн байнгын хороо Хяналт шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах нь зүйтэй гэж үзэж төслийг нь тогтоолын төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлгийг дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүгдээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Т.Аюурсайхан: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байвал нэрээ өгье. Нэрийг тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд асуулт асууж, үг хэлнэ.

Т.Доржханд: Тэгэхээр би дахиад саналаа бас дахиад хэлье, баталгаажуулж хэлье. 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөр бид нар парламент хяналт шалгалтаа хийдэг байна л гэсэн.

Тэгэхдээ яг бодит байдал дээрээ хяналт явахгүй байна эрхэм гишүүдээ. Түрүүн манай Адьшаа гишүүний хэлж байгаа үнэн шүү дээ. Хяналт шалгалт хийхийн тулд энэ чинь зардал хэрэгтэй шүү дээ. Тэгээд боомтууд руу очъё гээд тэгэхэд зардлыг нь тавьж өгдөггүй, газар дээр нь очъё гэхээр байдаггүй. Тэгээд л бичиг цаасны ажил гээд л зөндөө л олон зардлууд байгаа шүү дээ. Тэгээд энэ чинь бол явахгүй байна. Хөгжлийн банкн дээр тухайлбал 2 шинжээч ингээд томилчихсон. Тэгээд энэ өрөөний ингээд талаар дүүрэн цаас ингээд тэр хоёр хүн ухаад үзээд явах ямар ч боломжгүй байхгүй юу.

Би Сангийн яаманд байж байхад Оюу толгойн хэлэлцээртэй холбоотойгоор манайх ажлын хэсэг гаргаж байсан юм. Сангийн яамаар ахлуулаад, Татварын ерөнхий газар, хяналт шалгалтын байгууллагууд, тэгээд нийтдээ 200-гаад гаруй хүн ингээд нэлээн хэдэн контейнер ийм бичиг баримтуудыг 2 сар ухааж байж арай гэж ард нь гарч байсан байхгүй юу. Энэ чинь бодит ажил шүү дээ эрхэм нөхдөө. Ажил тэгж явдаг юм. Гэтэл тэрнээс илүү их ийм бичиг баримтууд Хөгжлийн банкны энэ бичиг баримт ингээд хуудас хуудсаараа байна. Архивлагдсан зүйлүүд байна. Хоёрхон хүн боломж байхгүй. 6 сар боломжгүй. Үгүй ээ тэгээд яаж ажил хий гээд, яаж хяналт шалгалтаа тавь гээд байгаа юм. Тэгээд тийм болохоор одоо энэ төсвийн энэ хэлэлцүүлэг дээр энэ хяналт шалгалтаа хийх юм уу, үгүй юм уу гэдэг тэр шийдлээ гаргаад, төсөв тавих хэрэгтэй нэг. Энэ бол бодитой шүү.

Хоёрдугаарт, энэ Хөгжлийн банкны хэрэг бол анх удаагаа энэ хянан шалгах түр хороо ажиллах юм уу, ажиллахгүй юм уу? Цаашидаа ер нь зөв юм уу, буруу юм уу, үр дүн гарах юм уу, үгүй юм уу гэдэг жишиг тогтоож байгаа ийм ажлын хэсэг. Тэгээд яах вэ энэ хурлын шийдвэрээр бол дарга нь бол өөрчлөгдсөн. Түгжрэлийн сайд болсон. Тэгээд оронд нь бол бас гишүүн болсон.

Энхбаяр гишүүн. Энхбаяр гишүүнийг бол дэмжиж байгаа. Ямар ч байсан эр зоригтойгоор ард нь гарах байх гээд. Гэхдээ хамтарч ажиллахад асуудал байна. Тэр нь юу байна гээд тэгэхээр хүн хүчний нөөц байхгүй байна тэр ажлын хэсэг дээр чинь. Хуулийн байгууллагууд нь орж ирээд энэ төрийн нууц байна, энийг мэдээлэл өгөх боломжгүй гээд л ам таглаад байгаа байхгүй юу.

Гэтэл хажууд нь тэрийг чинь ухааж гаргаж ирээд, энэ чинь юу билээ гээд тулгах ажил хийгдэх хэрэгтэй байгаа байхгүй юу. Ингээд явахаар түрүүчийн хэлдэг зүгээр нэг хууль ингээд гарчихдаг. Гэхдээ парламент нь хяналт шалгалтаа хийж чаддаггүй. Хангалттай түвшинд хийж чаддаггүй, мөнгө байдаггүй. Тэгээд цөөнхийн гишүүд нь хяналтаа байхын тулд тэр түр хороонд оръё гэхэд ингээд хязгаарлалт байна шүү дээ. Түрүүчийнх чинь бол 3 хүнээр л хэд, 3 түр хороогоор л хязгаарлаж байна шүү дээ. Цөөнхийн нэг гишүүнээс болоод. 4 дэх тухайлбал Төрийн банкн дээр асуудал гарлаа, хяналт шалгалт хийе гэхэд би бол орох боломжгүй л байгаа байхгүй юу жишээ нь.

Тэгээд энд байгаа хүмүүс боломжгүй л байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь энэ чинь нөгөө хууль чинь хэрэгжихгүй гэсэн үг шүү дээ. Хуулиа бид нар парламент хяналтаа тавьж чадахгүй бол ямар юмных нь парламент байх вэ дээ энэ чинь. Тэгээд ийм болохоороо ийм зүйлүүд дээр анхаарах хэрэгтэй. Цаашиа хулгайтай тэмцье, луйвартайгаа тэмцье, ажлын хэсэг байгуулаад парламент нь хянаж шалгадаг байя, хариуцлага тооцдог байя гээд тэгэх юм бол одоо энэ дээр анхаарах хэрэгтэй. Бодитой ажил хийе гэх юм бол анхаарах хэрэгтэй. Тэгээд энэ хугацааг нь цаашиагаа илүү сунгахгүй бол амжихгүй байна шүү дээ. Энэ өрөөний талаар хэмжих хэмжээний ийм нэг цаасыг чинь хоёрхон хүн үзнэ гээд бод доо. Одоо арай хийж нэг 3-ыг нэмэх үү,

үгүй юу гээд явж байгаа. Бодит байдал ийм байгаа шүү.

Тэгэхээр хугацааг нь сунгахаас өөр аргагүй. Гэтэл 2 нэгхэн удаа сунгах ийм зохицуулалттай юм байна лээ шүү дээ. Том хулгайнууд байхгүй байна шүү дээ. Төмөр замын хулгайг ийм байдлаар шийднэ гэвэл боломжгүй. Хөгжлийн банкн дээр боломж алга. Тэгэхдээ яаж ийж байгаад л энэний ард талд нь гарахын тулд бол парламент энэ дээрээ нэгдэж ажиллах хэрэгтэй юм байна лээ шүү. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Үг хэллээ. Зочин танилцуулъя. Өвөрхангай аймгийн Тарагт сумын иргэд, малчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Б.Энхбаяр: Баярлалаа. Тэгэхээр Хөгжлийн банкны хянан шалгах түр хороо 6, даргаа энэ Чинзориг гишүүнийг одоо хурал үймүүлэхийг болиулмаар байна, энэ ерөөсөө энэ танхимыг хурал биш болгож байна шүү дээ энэ чинь. Би минутаа эхлүүлмээр байна, эхнээс нь авмаар. Энэ Хөгжлийн банкны хянан шалгах түр хорооны хугацаа 6 сарын хугацаатай ажиллана, нэг удаа 6 сарын хугацаагаар сунгаж болно гэж заасны дагуу сунгаж, 6 сарын хугацаагаар сунгаж ажиллах шаардлагатай байгаа. Ингээд сунгалаа гэхэд энэ хугацаа маань энэ намрын чуулганы төгсгөлд дуусаж байгаа юм. Өөрөөр хэлбэл одоо энэ Хөгжлийн банкны хянан шалгах хороо нэг ээлжит чуулганд маш шахуу хугацаатай ажиллах үүрэг хүлээж байгаа юм.

Ингээд Улсын Их Хуралд тайлангаа тавина. Сая Адьшаа гишүүн, Доржханд гишүүд бол одоо маш чухал үнэнийг хэлж байна. Ороод одоо өчигдөр ажлаа аваад эхэлсэн. Энэ төсөв гэж юм алга түр хороонд. Тэгээд мөнгөгүй

болохоор би ажиллахгүй гээд байгаа биш, хэлж байгаа юм биш шүү. Ажиллана. Тэгэхдээ энд одоо сая хэлж байна шүү дээ 2016 онд одоо шалгаж байх тэр төмөр замын хэрэг зөвхөн цаас нь нэг портер цаас байгаа байхгүй юу. Зөвхөн төмөр замын. Энэ дамжуулан зээлд өгөх гэрээ чинь 1200 ААН-д дамжуулан зээлдчихсэн асуудал яригдаж байгаа юм. Төслийн асуудал. Мөн одоо энэтэй холбоотой хууль хяналтын байгууллагууд ер нь одоо тэр ял завишуулаад байна уу, үгүй юу. Гарцаагүй хүмүүсийг хэрэг үүсгэхгүй. Тэрийг чинь яаж нотлох юм бэ гэхээр тэр хуулийн байгууллагуудын чинь ажилтанд нь хөндлөнгөөс оролцохыг нь хуулиар хориотой шүү дээ энэ Улсын Их Хурлын гишүүд чинь. Яаж үзэх гээд байна вэ гэхээр энэ шинжээч хараат бус шинжээчдийг одоо татаж дайчилж ажиллуулах шаардлага үүсээд байгаа юм. Мэргэжлийн.

Ингэнгүүт энэ хүнийг чинь ямар одоо бүхэл бүтэн Улсын Их Хурлын түр хороо одоо үнэгүй ажиллачхаач гэж ингэж ярьж болохгүй шүү дээ. Хүний хөдөлмөрийг. Тэгээд одоо ийм том хэрэг рүү оруулж байж, хараат бус ажиллах тэр нөхцөлийг нь хангах ёстой, үүрэгтэй байгаад байгаа байхгүй юу. Тэгэнгүүт одоо би одоо яах юм бэ одоо энэ чинь одоо хувиараа цалинжуулъя гэж одоо ярих юм уу. Энэ ийм утгагүй юм руугаа орох гээд байна. Хэрэг дээрээ одоо энэ зориуд энэ түр хороог одоо ер нь ажиллах бололцоогүйгээр наанаа дэмжээд, цаанаа чагтлаад байгаа юм биш байгаа гэдэг энэ өмнө нь Сүхбаатар гишүүн ахалж байхад хэлж байсан юм. Энэ Сангийн яам зориуд нэг ч төгрөг тавиагүй юм байна лээ шүү дээ. Бичиг өгөөд байсан чинь. Төсвийн байнгын хороо нэг ч төгрөг тавьж өгөөгүй юм байна лээ.

Тэгсэн мөртөө яадаг ийдэг ч гэнэ үү, зөндөө хөшөө дурсгал энд тэнд булаад байдаг, хэдэн тэрбумаар нь. Тэгээд хулгайтайгаа яг тэмцье гэнгүүт мөнгө тавихгүй. Энэ чинь эс үйлдэл

байхгүй юу. Эс үйлдэл. Би бол одоо энэ удаа бол энэ төсөв дээр Төсвийн байнгын хороон дарга маань шинэ хүн болсон. Арай нөгөө ширэн нүүртэй, цаагуураа ийм 2 нүүртэй ийм хүн биш болчихсон учраас нөхцөл байдал өөрчлөгдөх байх гэж найдаж байгаа юм. Тийм. Тэгээд энэ дээр бас нэг дэмжлэг үзүүлж манай гишүүд маань энэ түр хороо дээр бас нэг тэр нэг хэдэн хүмүүсийг ажиллах нөхцөл бололцоогоор одоо хангах ийм одоо боломжийг бүрдүүлээч. Нэг албан бичгээ явуулах гээд өчигдөр принтер байна уу гээд явж байна шүү дээ энэ чинь шинжээч нь. Энэ чинь болохгүй биз дээ. Та нар зүгээр яг бодит байдал нь ийм байна шүү дээ. Тэгээд нэг гишүүдийн туслахыг царайчилчихсан, канон энийг канондоод өгөөч гээд явж байна шүү дээ бодит байдал. Ийм байдалтай байж болохгүй шүү. Тэгэхээр та бүхэн маань дэмжиж өгөөрэй энэ. Би бол ичихгүй шүү. Түр хороо дээр харин би бол ичихгүй одоо зарлана шүү харин шууд.

Т.Аюурсайхан: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна гишүүдээ. Санал хураалт. Байнгын хорооны саналаар Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 67.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Тогтоолыг уншиж танилцуулъя. Улсын Монгол Улсын Их Хурлын тогтоол. Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай. Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох.

1.Монгол Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор байгуулсан Хянан

шалгах түр хорооны ажиллах хугацааг 2022 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 6 сарын хугацаагаар сунгасугай гэсэн.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөсгүй гэсэн тогтоолыг уншиж танилцуулж байна. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссон тооцлоо.

16.43 цаг

Долоо. “Түр хорооны даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороо/

Дараагийн асуудалд оръё гишүүдээ. Түр хорооны даргыг сонгох тухай асуудал хэлэлцэнэ. Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих түр хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2022 оны 7 дугаар сарын зургааны 48 дугаар тогтоолоор хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгтгэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хороог байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Түр хорооны даргыг сонгох тухай асуудлыг Түр хорооны 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Түр хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг нь харгалзан Түр хорооны даргад нэр дэвшүүлэн хэлэлцүүлээ.

Ж.Бат-Эрдэнэ нь 1965 онд төрсөн, эхнэр, 3 хүүхдийн хамт амьдардаг, авто механик инженер, эрх зүйч мэргэжилтэй, удирдахуйн ухааны магистр. Тэрээр 90-92 онд ОХУ-ын Рыпкооп УУГ-т менежер, 94-2000 онд Ашид Эрдэнэ компанийн захирал, 2000-2004 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто тээврийн газрын дарга, 2007-12 онд Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга, 2008-12 онд Монголын төмөр зам ТӨХК-ийн ТУЗ-ийн дарга, 2011-12 онд МИАТ компанийн ТУЗ-ийн дарга, 2013 оноос Булган аймгийн МАН-ын хорооны дарга, 17, 18 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээвэр хөгжлийн сайд, 16 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Түр хорооны хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар нэр дэвшигчид хандан малчдын орлогыг нэмэгдүүлэхийн тулд малын гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, махны экспортыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үнийг

хатуу тогтоохгүй байх, мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг механикжуулах, агуулахын үйл ажиллагааг үйлдвэрлэл эрхлэлттэй уялдуулан хөгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин говийн бүсэд хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхийг бодлогоор дэмжих, Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тусгагдсан хүнсний үйлдвэрлэл, мал аж ахуй, газар тариалангийн салбар, жижиг дунд үйлдвэрлэлийг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тусгагдсан хүнсний үйлдвэр, мал аж ахуй, газар тариалангийн салбар, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг оновчтой зарцуулахад түр хороо анхаарч ажиллах нь зүйтэй талаар саналаа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал, дүгнэлт боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хорооны даргад нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Түр хорооны даргыг сонгох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Түр хорооны даргыг сонгох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг

баталж өгөхийг та бүхнээс хүсье.
Анхаарал тавьсанд баярлалаа.

Т.Аюурсайхан: Одоо нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье. Нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлнэ шүү. Улсын Их Хурлын гишүүн Чинзориг гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлнэ. Нэрээ татсан уу. Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг бас больсон уу. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд байраа эзлээрэй. Санал хураалт. 63 хувийн саналаар дэмжигдлээ. Түр хорооны нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг сонгохыг дэмжсэн тул Түр хорооны даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо.

Тогтоолыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол, Түр хорооны даргыг сонгох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйл, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1.Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо.

16.50 цаг

Найм.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ХЗБХ-ны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар танилцуулна. Индэрт урьж байна. Зарчмын зөрүүтэй 7 санал байгаа гишүүдээ.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн 2021 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн.

ХЗБХ 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан. Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгатай

холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, миний бие, Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа хамтран коронавируст халдвар цар тахлын үед иргэдийн орлого буурсан, зээлээ эргэн төлөхөд хүндрэл үүссэн зэргийг харгалзан Коронавируст халдвар, халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засгийн үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан батлуулсан бөгөөд барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанд хүүгийн хязгаарлалт тогтоосноор иргэдийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалт болон төдийгүй болсон төдийгүй мөнгөн зээлийн үйл ажиллагааг цэгцлэх эхний алхам байсан талаар онцолж, барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа этгээдийн бүртгэл, зохицуулалт, хязгаарлалтыг хэрхэн шийдвэр шийдсэн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарим нэр томъёог тодорхой болгох, түүнчлэн иргэд хоорондын зээлийн хүүгийн хэмжээг хэрхэн тогтоох талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан зээл олгож байгаа эх үүсвэрийг хэрхэн тодорхойлох, гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлсийн талаарх цагдаагийн байгууллагын цахим сантай хэрхэн холбогдож ажиллах, барьцааны хөрөнгийг хэт багаар үнэлдэг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд орон нутагт малыг банк болон барьцаалан зээлдүүлэх газар давхар барьцаалж зээл авах, үүнээс шалтгаалан иргэдийн зээлийн эргэн төлөлтөд асуудал үүсэх эрсдэлийг хэрхэн зохицуулах талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан

даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 2 санал хураалт явуулсан бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т заасныг баримтлан 5 санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусгасан тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Т.Аюурсайхан: Ажлын хэсгийг танилцуулъя. Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Цолмон мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Итгэлсүрэн СЗХ-ны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга, Одмандах, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны ахлах мэргэжилтэн,

Пүрэвсүрэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын газрын мэргэжилтэн үү, Мөнх-Ундарга Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал, Октябр Татварын ерөнхий газрын хуулийн хэрэгжилтийг хангах газрын татварын улсын байцаагч, Баялагцэнгэл Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Өнөрлхам Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч, Баянмөнх СЗХ-ны Хяналт шалгалт зохицуулалтын газрын ахлах зөвлөх, Мөнх-Оргил мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт гэсэн ажлын хэсгийг танилцуулж байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байвал нэрээ өгье. Алга байна. Одоо санал хураалт явуулна гишүүдээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй 7 санал байгаа Байнгын хорооноос гаргасан. Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг эхлүүлье.

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа. Нэгдүгээрт. Байнгын хорооны дэмжсэн саналууд явж байгаа юм байна.

1.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “10 өдрийн” гэснийг “15 өдрийн” гэж, 11.4 дэх хэсгийн “харьяалах бүртгэх байгууллагад ирүүлж болно” гэснийг ирүүлнэ гэж, 11.5 дахь хэсгийн “бүртгэх байгууллага” гэснийг “энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлээгүй бол бүртгэх байгууллага” гэж, 11.11 дэх хэсгийн “цахимаар, нээлттэй” гэснийг “мэдээлэл хүргэх цахим хуудас, мэдээллийн самбарт гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “өөрчлөлтийг ажлын гурван өдрийн дотор” гэснийг “өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн

байнгын хороо. Гишүүдээ байраа эзлээрэй. Байраа эзлээрэй, санал хураалт явууллаа. Санал хураалт. 66,7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсгийн “Энэ тохиолдолд бүртгэх байгууллага тухайн этгээдийг бүртгэхгүй.” гэснийг, 11.3, 11.4, 11.5 дахь хэсгийн “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг, 11.12 дахь хэсгийг болон “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлийн хугацаа сунгах” гэсэн 13 дугаар зүйлийг тус тус хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 66,7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дараагийн санал. Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “удирдлага, эсхүл менежерээр томилогдсоны дараа энэ хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан нөхцөл үүссэн бол” гэснийг “удирдлага, эсхүл менежерээр томилогдсоны дараа энэ хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан шаардлагыг хангахгүй болох нь тогтоогдсон бол” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 64,4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс” гэснийг “2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 64,4 хувийн саналаар дэмжигдлээ.

Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 286.2 дахь хэсгийн “зөвхөн хөдлөх хөрөнгө барьцаалж болно” гэснийг “зөвхөн хөдлөх хөрөнгө барьцаална” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн “Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 6.1.12 дахь заалтыг хасах гэснийг Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.1.13 дахь заалт болгох:

6.1.13.иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт. 64,4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Төслийн 18¹.1 дэх хэсэг болон 18¹.1.1 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18¹.1.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа болон иргэнээс байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн этгээдэд гэрчилгээ олгоход 100,000-250,000 төгрөгийн хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.”. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт. 57,8 хувийн саналаар дэмжигдлээ. Болсон тийм ээ, дууссан уу? Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

17.02 цаг

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Гишүүд, ажлын хэсэгтээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА